



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2022 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2022 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2022 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр, Баасан гараг

| | |
|--|-------|
| <i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i> | |
| <i>Хуралдааны товч тэмдэглэл:</i> | 2-9 |
| <i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i> | 10-62 |
| <hr/> | |
| <i>1.Хуулийн төсөл эцэслэн батлах /Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн, холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүд/</i> | 10-17 |
| <i>2.Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг нарын 5 гишүүн 2022.10.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i> | 17-31 |
| <i>3.Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэл /Монгол Улсын Хөгжлийн банкны чанаргүй зээлийг барагдуулах, олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын өмнө гэрээгээр хүлээсэн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангах, гадаад эх үүсвэрүүд хугацаанаас өмнө дуудагдах эрсдэл, урьдчилан сэргийлэх чиглэлээр Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар/</i> | 31-62 |

**Монгол Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы
11 дүгээр сарын 04-ний өдөр /Баасан гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 76 гишүүнээс 40 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 10 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Ц.Анандбазар, Ж.Ганбаатар, Б.Саранчимэг;

Чөлөөтэй: Ж.Батжаргал, Г.Дамдинням, Л.Оюун-Эрдэнэ;

Эмнэлгийн чөлөөтэй: Х.Болорчулуун;

Тасалсан: Д.Бат-Эрдэнэ, С.Ганбаатар, Х.Нямбаатар;

Хоцорсон: С.Амарсайхан-12 минут, Т.Аюурсайхан-43 минут, С.Батболд-1 цаг 33 минут, Д.Ганбат-1 цаг 08 минут, Т.Доржжанд-26 минут, Б.Дэлгэрсайхан-51 минут, Б.Жавхлан-1 цаг 33 минут, Л.Мөнхбаатар-43 минут, Ж.Мөнхбат-1 цаг 53 минут, Ц.Мөнх-Оргил-35 минут, С.Одонтуяа-23 минут, М.Оюунчимэг-1 цаг 33 минут, Д.Өнөрболор-27 минут, Ц.Сэргэлэн-1 цаг 08 минут, Г.Тэмүүлэн-1 цаг 33 минут, Н.Учрал-1 цаг 05 минут, Т.Энхтүвшин-15 минут, Ж.Эрдэнэбат-16 минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяа, Б.Пүрэвдорж, Г.Амартүвшин нараас ирүүлсэн албан бичгийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяа, Б.Пүрэвдорж, Г.Амартүвшин нар үг хэлэв.

Нэг.Хуулийн төсөл эцэслэн батлах /Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн, холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүд/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2-т заасны дагуу хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулав.

Г.Занданшатар: 1.Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 39

Татгалзсан: 11

Бүгд: 50

78.0 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

Хамт өргөн мэдүүлсэн:

2.Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 38
Татгалзсан: 11
Бүгд: 49
77.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэлийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэлийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 37
Татгалзсан: 12
Бүгд: 49
75.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 40
Татгалзсан: 11
Бүгд: 51
78.4 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

3.Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 41
Татгалзсан: 10
Бүгд: 51
80.4 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

4.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 37
Татгалзсан: 15
Бүгд: 52
71.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайханы “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайханы гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 37

Татгалзсан: 15

Бүгд: 52

71.2 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 40

Татгалзсан: 12

Бүгд: 52

76.9 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

5.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 41

Татгалзсан: 11

Бүгд: 52

78.8 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

6.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 37

Татгалзсан: 15

Бүгд: 52

71.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 38

Татгалзсан: 14

Бүгд: 52

73.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 39

Татгалзсан: 13

Бүгд: 52

75.0 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

7.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 40

Татгалзсан: 12

Бүгд: 52

76.9 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

8.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 39

Татгалзсан: 13

Бүгд: 52

75.0 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

9.Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 41

Татгалзсан: 11

Бүгд: 52

78.8 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

10.Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 42

Татгалзсан: 10

Бүгд: 52

80.8 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

Холбогдуулан боловсруулсан:

11.Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 42

Татгалзсан: 10

Бүгд: 52

80.8 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

Уг асуудлыг 10 цаг 45 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг нарын 5 гишүүн 2022.10.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Баатарзориг, Төрийн албаны зөвлөлийн гишүүн Д.Баатарсайхан, мөн зөвлөлийн Сургалт судалгаа, мэдээллийн нэгдсэн сангийн газрын дарга Ж.Эрдэнэбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх С.Дунжидмаа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан референт Э.Баттогтох нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьшаа, Н.Ганибал, Ж.Батсуурь, Ц.Туваан, Ё.Баатарбилэг нарын тавьсан асуултад Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Баатарзориг, Төрийн албаны зөвлөлийн гишүүн Д.Баатарсайхан, мөн зөвлөлийн Сургалт судалгаа, мэдээллийн нэгдсэн сангийн газрын дарга Ж.Эрдэнэбат нар хариулж, тайлбар хийв.

Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжээгүй санал:

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбатын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “Аймгийн төвөөс бусад” гэснийг хасах гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, Ц.Туваан нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 52
Бүгд: 58
10.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайхан, Ц.Идэрбат, Ц.Сандаг-Очир, Д.Тогтохсүрэн нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“51.3. Аймгийн төвөөс бусад сумын болон Нийслэлийн Багахангай, Багануур дүүрэгт тасралтгүй ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид таван жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгох бөгөөд мөнгөн урамшуулал олгох журмыг Засгийн газар батална.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, С.Амарсайхан, Н.Энхболд, Ё.Баатарбилэг, Ц.Сандаг-Очир, Ц.Туваан нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 50
Бүгд: 58
13.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 11 цаг 43 минутад хэлэлцэж дуусав.

Үдээс өмнөх хуралдаан 1 цаг 38 минут үргэлжилж, 11 цаг 43 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 00 минутад эхлэв.

Гурав.Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэл /Монгол Улсын Хөгжлийн банкны чанаргүй зээлийг барагдуулах, олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын өмнө гэрээгээр хүлээсэн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангах, гадаад эх үүсвэрүүд хугацаанаас өмнө дуудагдах эрсдэл, урьдчилан сэргийлэх чиглэлээр Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Монгол Улсын Ерөнхий прокурорын орлогч М.Чинбат, Нийслэлийн прокурорын газрын Ерөнхий прокурорын орлогч А.Энхжаргал, Авлигатай тэмцэх газрын дэд дарга Г.Азжаргал, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Б.Сүх-Очир, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга О.Амарсанаа, мөн газрын Ерөнхий шийдвэр гүйцэтгэгч Ч.Оюунцэцэг, Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, мөн банкны Хяналт шалгалтын газрын захирал Ц.Нарандалай, Монгол Улсын Хөгжлийн банкны Гүйцэтгэх захирал Н.Мандуул, мөн банкны Тэргүүн дэд захирлын үүрэг гүйцэтгэгч Ж.Батаа, Эрсдэлийн удирдлагын газрын захирал З.Батырбек, Экспорт, импорт, худалдааны санхүүжилтийн газрын захирал Б.Амгалан, Хөрөнгийн удирдлагын газрын захирал Л.Тэмүүжин, Бизнес төлөвлөлт, гүйцэтгэлийн хяналтын албаны захирал С.Мөрөн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга Ц.Батбаатар, мөн газрын Хяналт шалгалтын хэлтсийн дарга Ж.Лхагвасүрэн, референт Ж.Монголжингоо нар байлцав.

Сангийн сайд Б.Жавхлан Монгол Улсын Хөгжлийн банкны чанаргүй зээлийг барагдуулах, олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын өмнө гэрээгээр хүлээсэн

зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангах, гадаад эх үүсвэрүүд хугацаанаас өмнө дуудагдах эрсдэл, урьдчилан сэргийлэх чиглэлээр Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар мэдээлэл хийв.

Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл 1 цагийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар завсарлага авав./15:07/

Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс авсан завсарлага дуусав./16:06/

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл, Н.Алтанхуяг, Т.Доржханд, Ш.Адъяа, Б.Пүрэвдорж нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Монгол Улсын Хөгжлийн банкны гүйцэтгэх захирал Н.Мандуул, Монгол Улсын Ерөнхий прокурорын орлогч М.Чинбат, Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.13-т заасны дагуу Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Монгол Улсын Хөгжлийн банкны Гүйцэтгэх захирал Н.Мандуул, Монгол Улсын Ерөнхий прокурорын орлогч М.Чинбат, Авлигатай тэмцэх газрын дэд дарга Г.Азжаргал нар хариулж, тайлбар хийв.

Чуулганы нэгдсэн хуралдаанд Сангийн сайд Б. Жавхлан Монгол Улсын Хөгжлийн банкны чанаргүй зээлийг барагдуулах, олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын өмнө гэрээгээр хүлээсэн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангах, гадаад эх үүсвэрүүд хугацаанаас өмнө дуудагдах эрсдэл, урьдчилан сэргийлэх чиглэлээр Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар мэдээлэл хийлээ.

Уг асуудлыг 17 цаг 10 минутад хэлэлцэж дуусав.

Бусад. Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж “7 жил биш 5 жилээр тэтгэврээ тогтоолгоцгооё” гэсэн бичиг бүхий зурагт хуудсыг ширээн дээрээ байрлуулсан байв.

Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд, Б.Энх-Амгалан нарын урилгаар Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 1997 оны төгсөгчдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан, Х.Булгантуяа, Б.Саранчимэг, Ж.Чинбүрэн, Б.Энхбаяр нарын урилгаар Баянзүрх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид, Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяагийн урилгаар “Зориг сан” Төрийн бус байгууллагын Орон нутгийн эмэгтэйчүүдийг чадавхжуулах хөтөлбөр”-ийн оролцогчид, Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор, Ж.Эрдэнэбат, Ч.Ундрам нарын урилгаар Сэлэнгэ аймгийн Мандал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 1981 оны 10^е ангийн төгсөгчид, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 3 дугаар сургуулийн хамт олны төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин, Б.Дэлгэрсайхан нарын урилгаар Дорноговь аймгийн Алтанширээ сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид, Улсын Их Хурлын гишүүн Д.Батлутын урилгаар Орхон аймгийн эрүүл мэндийн салбарын албан хаагчдын төлөөлөл Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч М.Номиндулам, С.Энхзаяа нар хариуцан ажиллав.

Хуралдаан 3 цаг 44 минут үргэлжилж, 76 гишүүнээс 66 гишүүн хүрэлцэн ирж, 86.8 хувийн ирцтэйгээр 17 цаг 10 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2022 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр,
Баасан гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 10 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Занданшатар: Энэ өдрийн амар амгаланг айлтган мэндчилье. Ирц бүрдсэн байгаа тул Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы 11 дүгээр сарын 4-ний өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 3 асуудал хэлэлцэнэ. Эхлээд хуулийн төсөл эцэслэн батална. Өөрөөр хэлбэл 39-өөс дээш гишүүний ирцтэйгээр хуулийн төслүүд эцэслэн батална. Нийт 11 хуулийн төсөл эцэслэн батална.

Хоёрдугаарт, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгийг явуулна. Зарчмын зөрүүтэй 2 саналтай. Үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэл, Монгол Улсын Хөгжлийн Банкны чанаргүй зээлийг барагдуулах, олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын өмнө гэрээгээр хүлээсэн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангах, гадаад эх үүсвэрүүд хугацаанаас өмнө дуудагдах эрсдэл, урьдчилан сэргийлэх чиглэлээр Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар Ерөнхий сайдын мэдээлэл сонсоно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13-т гишүүн энэ хуулийн 9.5-д заасан нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхээр тогтсон асуудлыг хойшлуулах, дараалан өөрчлөх, хэлэлцэх асуудлын дараалалд багтсан асуудлуудаас асуудал нэмэх горимын санал гаргах бол Улсын Их

Хурлын даргад нэгдсэн хуралдаанаас өмнөх өдрийн 17 цагаас өмнө үндэслэл бүхий саналаа бичгээр ирүүлнэ гэж заасны дагуу Ширнэнбаньдын Адьшаа, Бөхчулууны Пүрэвдорж, Ганибалын Амартүвшин нараас тус тус албан бичгүүд ирүүлсэн байна.

Уншиж танилцуулъя. Ирүүлсэн дарааллаараа. Цагийн дарааллаар нь. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын 2022 оны 11 дүгээр сарын 4-ний өдрийн чуулганы нэгдсэн асуудалд хэлэлцэх асуудалтай холбогдуулан хэлэлцэх асуудлын дараалалд байсан асуудлаа татсан тул үндэслэл бүхий саналаа үүгээр хүргүүлж байна. Үг хэлэх зөвшөөрөл олгоно уу. Ширнэнбаньдын Адьшаа.
Ширнэнбаньдын Адьшаа гишүүн.

Ш.Адьяа: Эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг айлтгая. Энэ Монгол Улсын 2023 оны төсөв хэлэлцэхтэй холбогдуулж олон хуулийн өөрчлөлт оруулж ирсэн байгаа. Энэ асуудалтай холбогдуулж, энэ Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг хойшлуулах, татаж авах ийм горимын саналыг оруулж байгаатай холбогдуулж үг хэлэх гэж байгаа юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалтай зөрчилдсөн ийм Ашигт малтмалын тухай хуулийн заалтыг оруулж ирлээ. Энд ямар заалт байна вэ гэхээр тухайн орон нутагт уул уурхайн олборлолт хийж байгаа компаниуд албан ёсоор хандив, тусламж авах ийм заалтыг оруулж ирсэн.

Нөгөө талаасаа тэнд ажилладаг гадаад, дотоодын компаниудын квотын асуудлыг оруулж ирсэн байна. Энэ ямар асуудлуудад ийм салбарын сайдаас нь зөвшөөрөл авахгүйгээр ийм асуудлыг оруулж ирсэн. Энэ асуудал бол үнэхээр ноцтой асуудал шүү. Бид нар өнөөдөр Оюу толгойн ажлын хэсэг гэж ажиллаж

байхад Оюу толгойн компаниас Өмнөговь аймагт жил бүхэн 5 сая долларын орон нутагт ийм хандив тусламж олгож ирсэн. Гэтэл энэ хандив тусламжаа Монгол Улсын өр гэж бичиж байршуулсан байгаа. Бид 10 жилийн хугацаанд өнөөдөр жилд 5 сая доллар гэхэд 50 сая долларын өртэй болчихсон байгаа юм. Орон нутагт.

Гэтэл өнөөдөр энэ асуудлаар далимдуулж орон нутагт хуулийг завхруулдаг, лиценз нэрээр эзэмшсэн ийм хууль бус ажиллагаа орон нутгийн удирдлагатай хамтарч хийх асуудал өнөөдөр газар авч байна.

Тухайлбал, Ховд аймгийн Мянгад суманд Халзан Бүргэдийн орд гэдэг энэ асуудал өнөөдөр Ховдчуудын тухайд, Монголчуудын тухайд олон асуудал дагуулсан ийм нөхцөл байдал үүслээ. Энэ Монголын Зэс-Эрдэнийн корпорац гэж Эрдэнэтийн 49 хувийг авч ирсэн Пүрэвтүвшин гэдэг залуу өнөөдөр очиж тэр Ховд аймгийн Мянгад сум, Хар-Ус нуурын ай сав газарт газрын ховор элемент нэрээр уул уурхайн компани үйл ажиллагаа явуулж, Монгол Улсын Үндсэн хуулийн 6.2-т заасан Монгол Улсын иргэн аюулгүй орчныхоо байгаль орчны сөрөг нөлөөллийн тухай мэдэх эрхийнхээ тухай асуудал тавихад хууль хүчний байгууллагаар далайлгаж, нутгийн ард иргэдийг цагдаа, хүчний байгууллагаар шалгуулдаг, дарамталдаг, аливаа асуудлыг хүчээр түрэхийг оролддог ийм үйл ажиллагаа газар авсныг Ховд аймгийн олон иргэд надад ирүүлж байна.

Хэдийгээр өнөөдөр улс орны эдийн засаг хүнд, ашигт малтмалын ордыг Монгол Улсын эдийн засгийн эргэлтэд оруулах гэж байгаа хэдий ч бид өнөөдөр хууль дээдлэх зарчим Монгол Улсынхаа Үндсэн хуулийн хүрээнд энэ асуудлыг шийдэх ёстой. Өнөөдөр тухайн нутаг оронд амьдарч байгаа ард иргэд, Монголчууд бид Үндсэн хуулийн 6.2-т зааснаар тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг ордын тухай мэдэх эрхтэй.

Энэ чинь Үндсэн хуулийн 6.2-т заасан шүү дээ. Энэ мэдэх эрхээ эдлэх гэхээр нь өнөөдөр лиценз эзэмшигч, уул уурхайн компаниуд ард иргэдээ, орон нутгийн цагдаагийн байгууллагаар дарамтлуулдаг, тагнадаг, чагнадаг, мөрддөг, тэнд бичсэн сэтгүүлчдийг хүртэл өнөөдөр зүгээр байлгахгүй ийм ноёрхол бий болж байна. Энэ одоо юу вэ? Энийг Улсын Их Хурал хууль тогтоох дээд байгууллага энд анхааралдаа авч, энэ төсвийн хуулиар хэлэлцэхдээ далимдуулсан олон ийм цоорхойтой хууль оруулж ирсэн энэ асуудлаа Засгийн газар татаж ав. Энэ татаж ав. Энэ Эдийн засгийн байнгын хорооны хурал дээр Ганбаатар сайд энэ асуудлыг надад танилцуулаагүй гэж ярьж байсан.

Гэтэл өнөөдөр салбарын сайд нь танилцуулаагүй асуудлыг өнөөдөр оруулж ирээд тухайн орон нутагт хандив тусламж өгнө гэдэг хуулиар баталгаажуулдаг. Энэ тухайн орон нутгийн ард иргэдэд биш тэр орон нутагт эрх барьж байгаа сумын Засаг дарга, иргэдийн Хурлын дарга мэтийн хүмүүс сургууль, эмнэлэг нэрээр тэр мөнгийг авч иддэг энэ бусармаг тогтолцоог өнөөдөр төрийн хуулиар ингэж баталгаажуулахыг бид зөвшөөрч болохгүй. Эндээ одоо Засгийн газар дүгнэлт хийж, энэ хуулийнхаа төслийг энэ хэлэлцүүлгийн энэ Төсвийн хуулийн хамт өргөн мэдүүлсэн төслийн хэлэлцүүлгээс татаж авах, хойшлуулах ийм саналыг би оруулж байна.

Г.Занданшатар: Та өчигдөр та хэлэх ёстой л байсан санал байна даа. Өчигдөр дагасан хуулиудын анхны хэлэлцүүлгийг хийчихсэн шүү дээ. Тэрэн дээр л ярих ёстой байсан асуудал. Одоо эцсийн хэлэлцүүлэг рүү орчихсон.

Одоо Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Өчигдөр би Улсын Их Хурлын чуулганаас, индэр дээрээс бас

12 сарын 8-ны өдөр Мягмар гарагт энэ 7 биш 5 жилээр тэтгэврээ тогтоолгох тухай жагсаалыг Сүхбаатарын талбайд 12 цагаас зохион байгуулах талаар ярьсан. Тэгээд энэнийхээ дагуу пост хийсэн. Тэр пост дор 300 гаруй хүмүүс одоогийн байдлаар коммент биччихээд байгаа. Тэгээд энэ комментыг, ерөнхийдөө хүмүүсийн комментыг үзэхэд ихэнх нь та бол энэ жагсаалыг цөөхөн хүн ир гэж хэлсэн нь буруу гэж хэлж байна. Тийм учраас ер нь энэ бүгдээрээ сайхан оролцоорой гэдгийг бас хэлье. Тэгээд энэ комментоос бас харахад Пүрэвдорж их шог юм ярьдаг. Тэгэхдээ яах вэ, энэ хууль дээр чинь дэмжээд жагсаалд нь очно гэсэн ийм хүмүүс бас байх шиг байна.

Тэгэх дээр ер нь энэ миний энэ жагсаал Монголын түүхэнд анх удаагаа ард иргэдийн төлөө хууль батлуулахын тулд жагсаал болж байгаа гэдгээрээ бас онцлогтой гэдгийг бас нэгдүгээрт хэлье. Өчигдөр үг хэлсний дараа Нямбаатар сайд ирээд Пүрэвдорж чиний жагсаалын чинь аюулгүй байдлыг хангая гээд ярьж байна лээ. Энэ санаачилгад нь баярлалаа. Тэгэхдээ жоохон доромж маягтай. Цөөхөн хүн оролцох юм чинь гэсэн маягтай хандаж байна лээ. Тэгэхлээр ард иргэд бас тийм олуулаа ирээд энэ жагсаалд оролцоорой гэж бас та бүхэнд хэлье. Энэ комментоос харахад бас Цэдэндамбын Цэрэндорж гэдэг хүн Дорнод аймгаас хүртэл ирж оролцоно гээд бичээд явж байгаад их маш их баяртай байна.

Тийм учраас энэ жагсаалд хөдөө орон нутаг гэлтгүй бүгдээрээ ирээрэй гэдгийг бас хүсье. Тэр комментоос харахад бас 18 оноос өнөөдрийг хүртэл тэтгэвэрт гарчихсан 7 жилээр бодуулчихсан хүмүүс хохирч үлдэж байна гэж ярьж байгаа юм. Тэгэхээр энэ хууль бол 7 жилийг 5 жилээр, Сарангэрэл гишүүнээ би их чухал ач холбогдолтой юм ярьж байна. Тэгэхлээр энэ хууль 7 жилийг 5 жил болгох тухай хууль. Энэ бас нэг дагалдаж өргөн барьсан хууль бол 2018 оноос өнөөдрийг хүртэл 7 жилээр бодуулчихсан хүмүүсийг буцааж 5 жилээр бодуулах 2 хууль явж байгаа

шүү. Тийм учраас энэ тэтгэвэрт гарчихсан хүмүүс би нэгэнт 7 жилээр бодуулчихсан юм чинь гээд хойш сууж болохгүй. Энэ хууль батлагдах юм энэ хууль алга урвуулахын төдийд л батлагдана гэсэн үг. Тийм учраас бүгдээрээ хамт тэмцээрэй гэж бас та бүхэнд уриалъя.

Тэгээд ирэх мягмар гарагт 11 сарын 8-ны өдөр Сүхбаатарын талбайдаа 7 жил биш 5 жилээр тэтгэврээ бодуулах хүн болгон энэ хуулийн үр дүнд бас 100-150 мянган төгрөгөөр илүү тэтгэврээ тогтоолгох ийм боломж та бүхний өмнө ирж байгаа. Тийм учраас бүгдээрээ хамтдаа ирээрэй гэж та бүхэнд уриалж байна. Жагсаал маш даруухан болно. Цөөхөн хүн үг хэлнэ. Тэгээд энэ эхлэл бол амжилтын түүчээ болдог. Тийм учраас эхний ээлжийн жагсаалаа бид нар энэ Их Хурлаар хуулиа батлуулахын тулд цөөхөн ч байсан, олон ч байсан бүгдээрээ хамтдаа тэмцэж эхэлнэ гэдэг бол бидний хувьд хамгийн чухал асуудал юм. Тийм учраас та бүхнийг энэ жагсаалтаа битгий нэг нэгэндээ найдаж, хойшоо суулгүйгээр бүгдээрээ оролцоорой гэж би уриалж байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Пүрэвдорж гишүүн үндэслэл бүхий саналаа ярьж байна шүү дээ. Зарлал одоо хэлээд байхаар. Ганибалын Амартүвшин гишүүн.

Г.Амартүвшин: Баярлалаа. Өнөөдөр чуулганы хуралдаанаар үдээс хойш Хөгжлийн банктай холбоотой Ерөнхий сайдын мэдээлэл орно. Энэ мэдээллээр бас нэлээн тийм сонирхолтой бөгөөд хэрэгтэй мэдээлэл өгнө гэдэгт би итгэж байгаа. Тийм болохоор гишүүд маань бас энэ мэдээллийг анхааралтай сонсохыг би хүсэж байна. Харамсалтай нь өчигдөр Их Хурлын чуулганы танхимд Даваасүрэн гишүүн намайг үндэслэлгүй гүтгэж, дайрч, ёс зүйгүй мэдээлэл хийсэн. Энэ талаар би тодорхой хэмжээний бас өөрийнхөө мэдээллээ хийе гэж бодож байна.

Нэгдүгээрт, тэр надтай холбож яриад байгаа 33 тэрбумын зээл надад ямар ч хамаагүй. Би ер нь аливаа Хөгжлийн банкны зээлдэгчтэй хэзээ ч ямар ч холбоогүй. Байгаагүй. Энийг би хариуцлагатай мэдэгдэж байна.

Хоёрдугаарт, энэ компанийн авсан зээлээ бүрэн төлөөд дуусчихсан гээд энэ өнгөрсөн зун компанийн удирдлага нь мэдээлэл хийсэн. Зээл нь төлөгдсөн.

Гуравдугаарт, би өөрийн хүсэлтээр шалгууль гээд 4 сард мэдэгдэл хийсэн. Энэнийхээ дагуу би шалгуулж байгаа. Тийм болохоор удахгүй энэ Хөгжлийн банктай холбоотой, надтай холбож яриад байгаа асуудлын үнэн, зөв нь маш тодорхой болно. Энийг та бүгд бас сонсох болно. Хөгжлийн банкны, одоо үндсэндээ Хөгжлийн банкны зээлийн багцын чанартай зээлүүд нь үндсэндээ төлөгдөөд дуусчихлаа л даа. Боломжтой компаниуд нь бүх зээлээ төлж дуусаад, одоо үлдэгдэлд нь үндсэндээ төрийн өмчийн юм уу, төрийн өмчийн компаниуд болон улсын төсвийн хөрөнгө оруулалтын шинж чанартай зээлүүд үлдчихээд байна л даа. Тэрний дунд бол эрчим хүчний салбартай холбоотой нэлээн том багц зээл байгаа. Энэ зээлүүд нь болохоор барьцаа хөрөнгөгүй, эргэн төлөлтгүй, чанаргүй болсон зээлүүд байдаг. Тэгээд одоо Даваасүрэн гишүүний чичрээд, дайраад байгаа тэр улсын төсвийг дагалдаж орсон тогтоол Засгийн газар баталгаа гаргана гэсэн тийм тогтоолыг л шүүмжлээд энэний эсрэг санал өгсөн гишүүд рүү дайраад байгаа юм байна л даа.

Гэтэл яг үнэндээ хэлэхэд 2023 онд Засгийн газар Хөгжлийн банкны бондыг дахин санхүүжүүлэхийн тулд шаардлагатай тохиолдолд баталгаа гаргана гэсэн утгатай тогтоол байгаад байгаа юм л даа. Өөрөөр хэлбэл одоо энд эрчим хүчний тэр салбарын зээлүүд төлөгдөхгүй байгаа тэр зээлүүдийг дахин санхүүжүүлж байгаа шүү дээ. Тийм болохоор энэ дээр ямар нэгэн байдлаар надтай холбож, Даваасүрэн гишүүн

дайраад байгаа нь үнэхээр үндэслэлгүй байгаа юм.

Ер нь Даваасүрэн гишүүн таныг бол ахмад үеийн төлөөлөл, олон сонгогдсон гишүүн. Гишүүний хувьд залуу гишүүд өөрөөс чинь маань үлгэр дуурайлал хайдаг шүү. Энэ танхимд. Тийм болохоор ганцаарчилсан, бусад гишүүд рүүгээ дайрсан, доромжилсон тийм улс төр ер нь цаг үеэ өнгөрөөсөн шүү. Энийг бол яг залуу гишүүний хувьд танд баталгаатай хэлмээр байна.

Гэхдээ эцэст нь болохоор би Даваасүрэн гишүүнд бас баярлалаа гэж хэлмээр байна л даа. Намайг чуулганы хуралдааны үеэр миний нэрийг онцолж яриад миний PR-ыг маш сайн хийж өгч байгаад би маш их баяртай байгаа. Ер нь намайг социалаар ингэж дайрдаг, доромжилдог нөхдүүдийг би өөрөө бас like дараад, share хийдэг. Энэ миний PR-ыг маш сайн хийдэг. Би энд талархаж явах ёстой гэж боддог. Тийм болохоор Даваасүрэн гишүүн танд амжилт хүсье. Баярлалаа.

Г.Занданшатар: Гишүүд үг хэлж дууслаа. Мэндчилгээг дэвшүүлье зодчиддоо. Улсын Их Хурлын гишүүн Шатарбалын Раднаасэд, Бямбасүрэнгийн Энх-Амгалан нарын урилгаар Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 1997 оны төгсөгчдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Дэлгэрийн талд өнгөрөөсөн хүүхэд, залуу насаа эргэн дурсаж, эргэн дурсахуйн уулзалт хийж байгаа та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Дэлгэрч явах болтугай. Хэлэлцэх асуудалдаа орно. Гишүүд үг хэлж дууссан. Хэлэлцэх асуудалд орно. Хуулийн төслүүд эцэслэн батална.

Нэг.Хуулийн төсөл эцэслэн батлах /Мөнгөн зээлийн үйл ажиллагааг

зохицуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн, холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүд

Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлэн, мөн холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг эцэслэн батална.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.3-т 7 хоногийн Баасан гаргийн 10 цагт нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулна.

Хуралдааны ирц хуулийн төсөл эцлэн батлах шаардлага хангахаар бусад өдөр, цагт хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалтыг явуулж болно гэж заасны дагуу Байнгын хороо хуулийн төслүүдийг эцэслэн батлах хувилбарыг бэлтгэн гишүүдэд тарааж, эцэслэн батлуулахад бэлэн болсон байна.

Одоо төслүүдийг эцэслэн батлах санал хураалт явуулна. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.2-т нэгдсэн хуралдаанд хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулах бөгөөд Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжсэн бол хууль эцэслэн баталсанд тооцно гэж заасан. Энэ дагуу 39-өөс дээш гишүүд эцэслэн батлах ёстой. Санал хураалт бүртгэлийн. Хамгийн анхны санал учраас өнөө өглөөний бүртгэлийн санал. Эсрэг гарч байгаа гишүүд ирцэд тооцогдохгүй гэдгийг анхааруулъя.

Амгалангийн Адьяасүрэн гишүүн, Ширнэнбаньдын Адьшаа, Норовын Алтанхуяг, Сайнбуянгийн Амарсайхан, Энхтайваны Бат-Амгалан, Наянтайн Ганибал, Хассуурийн Ганхуяг, Цэрэнпилийн Даваасүрэн, Бөхчулууны Пүрэвдорж, Жамъянхорлоогийн Сүхбаатар, Бямбасүрэнгийн Энх-Амгалан, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан нар.

Санал хураалт явуулна. Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. 41 гишүүн байна. Санал хураалт явуулна. Пүрэвдорж гишүүнээ санал хураалт явуулна. Суудалдаа сууцгаа. Чойжилсүрэн гишүүн бас суудлаа суу. Битгий санал хураалт үймүүлээд бай. Чуулганы нэгдсэн хуралдаан үймүүлэхийг больё. Санал хураалт явуулъя. Санал хураалт. Тийм, сая туршилтын санал хураалт. Би залгаагүй. Эхнийх бүртгэлийнх, сая туршилтын санал хураалт.

Одоо Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалтыг 3 хүртэл удаа явуулж болно гэж заасан байгаа. Дэгийн хуульд. Гэхдээ Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт хэлээгүй. Санал хураалт. Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Амгалангийн Адьяасүрэн гишүүн 30 минут хоцорсон. Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн 31 минут хоцорсон байна шүү. Санал хураалтад тасалсан байна тэгвэл. Түрүүний санал хураалтыг.

39 гишүүн дэмжиж хууль эцэслэн батлагдлаа. Хамт өргөн мэдүүлсэн Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Агар-Эрдэнийг дууд. Түрүүнийхийг баталсан. 39-өөр баталчихсан. Одоо Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. Сайнбуянгийн Амарсайхан, Энхтайваны Бат-Амгалан, Цэрэнпилийн Даваасүрэн,

Даваажанцангийн Сарангэрэл,
Жамъянхорлоогийн Сүхбаатар,
Амгалангийн Адьяасүрэн,
Ширэнбандийн Адьшаа, Жамбын
Батсуурь, Бөхчулууны Пүрэвдорж,
Цэвэгдоржийн Туваан, Одонгийн
Цогтгэрэл, Норовын Алтанхуяг
гишүүдийн санал эсрэг гарсан байна. Энэ
хууль эцэслэн батлахад. Бөхчулууны
Пүрэвдорж гишүүн горимын санал.

Б.Пүрэвдорж: Монголын нийт
сонгогчдын 42 хувийн саналыг авчраад 82
хувийн Их Хурлын суудал авсан Монгол
Ардын нам.

Г.Занданшатар: Даваажанцангийн
Сарангэрэл гишүүн үг хэлнэ.

Д.Сарангэрэл: Их Хурлын даргаа
сая техникийн саатлын улмаас миний
кноп ажилласангүй. Саяын саналыг
хүчингүй болгож, дахин санал хураалт
явуулахыг хүсье.

Г.Занданшатар: Сарангэрэл
гишүүний саналаар саяын санал
хураалтыг хүчингүйд тооцох санал
хураалт явуулъя.

Үгүй үгүй? Санал хураалтад 49
гишүүн оролцож, 37 гишүүн дэмжиж,
саяны санал хураалтыг хүчингүйд
тооцлоо.

Саяын санал хураалтыг хүчингүйд
тооцсон учраас Иргэний хуульд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг
эцэслэн баталъя гэсэн саналын
томьёоллоор санал хураалт явуулъя.
Тогмидын Доржханд гишүүн 36 минут 24
секунд хоцорлоо. Санал хураалтдаа
ороорой.

Санал хураалт. 40 гишүүн дэмжиж,
Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах
тухай хуулийн төслийг эцэслэн баталлаа.

3.Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт
орлуулах тухай хуулийг дагаж мөрдөх
журмын тухай хуулийг эцэслэн баталъя

гэсэн саналын томьёоллоор санал хураалт
явуулъя.

41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн
батлагдлаа.

Дамдинсүрэнгийн Өнөрболор
гишүүн 37 минут хоцорлоо. Өнөрболор
гишүүн 37 минут хоцорсон байна шүү.

4.Иргэний хэрэг шүүхэд хянан
шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах
тухай хуулийн төслийг эцэслэн баталъя
гэсэн саналын томьёоллоор санал хураалт
явуулъя. Санал хураалт.

Санал хураалт. Санал хураалтын үед
ном яригдахаар хүмүүс ингээд.
Балжиннямын Баярсайхан гишүүн.

Б.Баярсайхан: Дарга, миний
төхөөрөмж ажилласангүй. Санал
хураалтыг хүчингүй болгоод дахин
явуулж өгнө үү. Баярлалаа.

Г.Занданшатар: Баярсайхан
гишүүний гаргасан горимын саналаар
санал хураалт явуулъя. Санал хураалтыг
хүчингүйд тооцох санал хураалт явуулж
байна.

71.2 хувийн саналаар саяны санал
хураалтыг хүчингүй тооцлоо. Өмнөх
санал хураалтыг хүчингүйд тооцсон
учраас Иргэний хэрэг шүүхэд хянан
шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах
тухай хуулийн төслийг эцэслэн баталъя
гэсэн санал хураалтыг дахин явуулна.
Гишүүд анхааралтай байгаарай. Санал
хураалт.

Эцэслэн батлах санал хураалт. 40
гишүүн дэмжиж, Иргэний хэрэг шүүхэд
хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай хууль төслийг
эцэслэн баталлаа. Пүрэвдорж гишүүн
судалдаа суу. Битгий санал хураалт
үймүүлээд бай.

5.Мөнгө угаах болон терроризмыг
санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд

нэмэлт оруулах тухай хууль төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулья.

Мөнгө угаахтай тэнцэхгүй хүмүүсийг харъя. 41 гишүүн дэмжиж энэ хууль эцэслэн батлагдлаа.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулья. Санал хураалт. Нямаагийн Энхболд гишүүн. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн суудалдаа суу. Санууллаа шүү. Дараагийн удаа шууд цалингийн 20 хувь.

Н.Энхболд: Даргаа сая миний юу ажилласангүй. Кноп ажилласангүй. Саяын санал хураалтыг хүчингүй болгож өгөх санал хураалгахыг хүсье.

Г.Занданшатар: Нямаагийн Энхболд гишүүний гаргасан горимын саналаар энэ санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулья. Санал хураалт. 73.1 хувийн саналаар өмнөх санал хураалтыг хүчингүйд тооцлоо.

Санал хураалтыг хүчингүйд тооцсон учраас Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулья.

39 гишүүн дэмжиж, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл эцэслэн батлагдлаа.

7.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Гишүүд анхааралтай байгаарай. Эцэслэн батлах санал хураалт.

40 гишүүн дэмжиж, 76.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Мөнгө хүүлэхтэй тэмцэх ажлын холбоотой хууль шүү дээ. Энэ чинь тээ?

Тэрийг дэмжиж, эцэслэн батлахгүй байгаа гишүүдийн нэрсийг сайн гаргах ёстой юм уу?

8.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулья. Санал хураалт. 39 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа. Одоо чинь 8 бил үү? 9 бил үү?

9.Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг. Пүрэвдорж гишүүн битгий, Пүрэвдорж гишүүн сүүлийн удаа санууллаа шүү.

Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулья. Санал хураалт явуулья. Саналаа өгөөрэй.

41 гишүүн дэмжиж, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл эцэслэн батлагдлаа. Одоо 2 байна.

10.Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Холбогдуулан боловсруулсан Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулья. Санал хураалт.

42 гишүүн дэмжиж, 80.8 хувийн саналаар эцэслэн батлагдлаа.

Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль батлагдлаа. Энэ

бас ард иргэдийн хүсэн хүлээж байсан, шаардлага тавьж байсан, энэ зээлийн мөнгө хүүлэхтэй ч холбоотой, хүндрэлтэй асуудлуудыг шийдвэрлэх зорилготой холбоотой хууль эцэслэн батлагдлаа. Гишүүд ажлын хэсэгт баярлалаа. Дараагийн асуудалд орно. Зочид танилцуулъя.

10.45 цаг

Хоёр.Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл/Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг нарын 5 гишүүн 2022.10.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Дараагийн асуудал бол Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Улсын Их Хурлын гишүүн Энхтайваны Бат-Амгалан, Хүрэлбаатарын Булгантуяа, Батсүхийн Саранчимэг, Жигжидсүрэнгийн Чинбүрэн, Баттөмөрийн Энхбаяр нарын урилгаар Баянзүрх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Ард түмний төлөөлөл болж анхан шатанд идэвх чармайлттай ажиллаж байгаа та бүхний ажил үйлсэд өндөр амжилтыг хүсэн ерөөе.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Жамбын Батсуурь танилцуулна. Индэрт урьж байна.

Ж.Батсуурь: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг нарын 5 гишүүн 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрийн албаны

тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн байна.

Төрийн байгуулалтын байнгын хороо 2022 оны 11 дүгээр сарын 1-ний өдрийн хуралдаанаараа хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулж, дараах санал, дүгнэлтийг та бүхэнд танилцуулж байна.

Хуулийн төсөлд иргэдийн оролцоог хангах, санал авах зорилгоор Улсын Их Хурлын D.Parliament.mn цахим системээр олон нийтээс тухайн төсөлтэй холбогдуулан санал авахад нэр бүхий 10 иргэнээс 13 санал ирсэнтэй танилцсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат төслийн 1 дүгээр зүйлд аймгийн төвийн, сумын төрийн захиргааны албан хаагчдыг хамруулах, Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайхан, Ц.Идэрбат,Ц.Сандаг-Очир, Д.Тогтохсүрэн нар мөн зүйлийг аймгийн төвөөс бусад сумын болон нийслэлийн Багахангай, Багануур дүүрэгт тасралтгүй ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид 5 жил тутамд 1 удаа 6 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгох бөгөөд мөнгөн урамшуулал олгох журмыг Засгийн газар батална гэж өөрчлөн найруулах санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй болно.

Хэлэлцүүлгийн үед Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат Засаг даргын Тамгын газарт тасралтгүй ажиллаж байгаа гэдгийг хэрхэн ойлгох, аймгийн төвийн сумын Засаг даргын Тамгын газарт

ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдыг хамруулах эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Мөн Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг хуулийн төсөлд аймгийн төвөөс бусад сумын Засаг даргын Тамгын газарт тасралтгүй ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид 5 жил тутамд 1 удаа 6 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгоно гэж тусгахаар суманд ажиллаж байгаа иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны албан хаагчид болон аймгийн төвийн сумын төрийн захиргааны албан хаагчид хамаарахгүй байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил төслийн талаарх Засгийн газрын байр суурийг харгалзан үзэх, албан хаагчдад сар бүрийн цалин дээр нь тогтмол олох нэмэгдэл нь 1 удаагийн шинжтэй мөнгөн урамшуулал, тэтгэмжээс илүү үр дүнтэй, Монгол Улсын 23 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдтэй хамтатган хэлэлцэх нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, Ё.Баатарбилэг нар хуулийн төслийн агуулгыг өөрчлөх, хамрах хүрээг нэмэгдүүлэх нь анх өргөн мэдүүлсэн төслийн үзэл баримтлалтай нийцэхгүй, үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар Засгийн газар орон нутагт ажиллаж байгаа албан хаагчаа дэмжих бодлогоо хэрэгжүүлж байгаа бөгөөд Монгол Улсын 23 оны төсөвт орон нутагт ажиллаж байгаа төрийн албан хаагчдын цалинг 20 хувиар нэмэгдүүлэхээр тусгасан тул хуулийн хамрах хүрээг нэмэгдүүлэхгүй байх нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн хуулийн дагаж мөрдөх хугацааг 23 оны Төсвийн тухай хуулийн төсөлтэй уялдуулан тооцох, энэ оны улсын төсөвт тусгах, боломжтой бол хэрэгжих хугацааг хэвээр үлдээх, анхаарах талаар, Улсын Их Хурлын гишүүн Г.Занданшатар хуулийн төслийг баталснаар улсын төсвийн орлогын хэмжээ буурах, зарлагын хэмжээ нэмэгдэхээр байвал энэ тухай Засгийн

газрын саналыг сонсох, зардал нэмэх нь төсөвт ямар нөлөө үзүүлэхийг тооцох, судалгаагүйгээр хамрах хүрээг нэмэгдүүлбэл хуулийн хэрэгжилтэд нь сөрөг нөлөөтэй талаар тус тус саналаа илэрхийлсэн болно.

Байнгын хороо Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан саналын томъёоллыг нэг бүрчлэн хэлэлцэж, санал хураалт явуулж дэмжсэн, дэмжээгүйгээр нь бүлэглэн бэлдсэн зарчмын зөрүүтэй саналын томъёолол болон анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсэж байна.

Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

Г.Занданшатар: Баярлалаа Жамбын Батсуурь гишүүнд. Одоо ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Төрийн албаны зөвлөлийн дарга Баатарзориг, Төрийн албаны зөвлөлийн гишүүн Должингийн Баатарсайхан, Төрийн албаны зөвлөлийн Сургалт судалгаа, мэдээллийн нэгдсэн сангийн газрын дарга Жамбаагийн Эрдэнэбат.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улс Их Хурлын гишүүн байна уу? Ганибал гишүүнээр тасалъя. Ийм олон. Тасаллаа Жадамбын Бат-Эрдэнэ гишүүнээр. Ширнэнбаньдын Адьшаа гишүүн асуулт асууна.

Ш.Адьяа: Энэ хуулийн төслийг зарчмын хувьд дэмжиж байгаа. Энэ хуулийн төсөл батлагдсанаар бас хөдөө

орон нутагт дутагдалтай байгаа төрийн албан хаагчдыг бас ажиллах нөхцөлийг нь сайжруулах бас ийм бодлого явагдаж байгаад их талархалтай байгаа юм.

Гэхдээ энэ асуудлыг цогцоор нь оруулж ирэх ёстой байсан. Өнөөдөр 5 жил ажиллаад 1 удаа нэмэгдэл авна ч гэдэг юм уу, ийм аргацаасан байдлаар энэ асуудлыг шийдэж байгаа нь цаашдаа улам олон асуудал дагуулна. Энэ дээр бас төсөл санаачлагчид бас цуг оруулж ирэх ийм боломж байгаагүй юм уу гэдэг ийм асуудлыг нэгдүгээрт асууя.

Хоёрдугаарт нь өнөөдөр энэ хөдөө орон нутагт ажиллаж байгаа энэ төрийн албан хаагчдын ажлын байрны нөхцөл, шаардлага гэдэг юмыг энд хамт оруулж ирэх боломж байсан уу? Өнөөдөр хөдөө орон нутагт ажиллаж байгаа сумын Тамгын газар бусад төрийн албан хаагчдыг ажиллах ажлын байрны шаардлага гэдэг энэ юм чинь үнэхээр болохгүй байгаа шүү. Өнөөдөр маш өндөр шалгуур тавьдаг. Тэгээд тэрэнд нь ордог хүн байдаггүй. Тэгээд эргээд орон тоо нь байж байдаг. Тэрнээс болоод төрийн энэ үйл ажиллагаа цалгардах, цаашлаад энэ төрийн дархлааны асуудал хүртэл энд яригдаж байгаа шүү дээ. Энэ асуудал дээр ямар байр суурь цаашид баримтлах уу гэдэг талаар бас ажлын хэсгээс асууж байна.

Нөгөө талаар энэ Төрийн албаны тухай 2017 онд батлагдсан хуулийн хэрэгжилт өнөөдөр ер нь ямар байна? Өнөөдөр энэ мэрит зарчим гээд байгаа. Мэрит зарчим гэдэг энэ үйлчлэл хэр явагдаж байна? Өнөөдөр Төрийн албаны зөвлөл бол ер нь ажиглахад маш сайн ажиллаж байгаа гэж ойлгож байгаа. Тэгээд энд их том дарамтад байдаг, улс төрийн нөлөөлөл ордог, дээрээс янз бүрийн шахааны хүмүүс өгдөг. Нөгөө талаасаа тэр үүрэг гүйцэтгэгч гэдэг ийм нэр томьёо өнөөдөр сүүлийн 3 жилийн хугацаанд КОВИД гэдэг нэрийн дор олон арван төрийн албан хаагчдыг хууль бусаар томилж ирсэн энэ үйл ажиллагаа

үргэлжилсээр байгаа. Энд ямар дүгнэлт хийх вэ? Түүнчлэн өнөөдөр яамнууд дээр байгаа Төрийн албаны салбар зөвлөл гэж байгаа. Энэ салбар зөвлөл гэдэг энийг толгойлж байгаа хүмүүс өнөөдөр маш хариуцлагагүй ажилладаг.

Тухайлбал, Байгаль орчны яам. Байгаль орчны яамны Төрийн нарийн бичгийн дарга Баттулга гээд нөхөр байгаа. Энэ хүн бол сонгон шалгаруулалтаар нэгээр гарч ирсэн хүнийг томилдоггүй. Тэгээд 10 хэдэн жилийн өмнө төрийн албан хаагчийн шалгалт өгсөн эсэхэд эргэлзэж байгаа гээд цагдаагийн байгууллагаар шалгуулдаг. Тэгээд цагдаа, прокурор нь өнөөдөр тэр хүний тухай ямар ч мэдээлэл өгөхгүйгээр хохироож байна. Ийм мэт хууль бус үйл ажиллагаа чинь цаашдаа үргэлжлэх юм уу? Ийм хүмүүстэйгээ энэ Төрийн албаны зөвлөл, Засгийн газар ер нь ямар хариуцлага хүлээлгэж байна? Ингээд дураараа дургиддаг, дунд чөмгөөрөө жиргэдэг гэдэг ийм юм өнөөдөр Төрийн албаны салбар зөвлөл гэдэг тэр яам, агентлагууд дээр байгаа энэ газар чинь бүр хэрээс хэтэрч байна. Энд одоо ямар дүгнэлт хийж байна вэ гэдгийг Төрийн албаны зөвлөл буюу энэ ажлын хэсгээс асууя.

Г.Занданшатар: 93 Төрийн албаны зөвлөлийн дарга Баатарзориг хариулна. Баатарзориг дарга түр байж байгаарай. 93 түр хүлээж байгаарай.

Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Булгантуяагийн урилгаар “Зориг” сан Төрийн бус байгууллагын орон нутгийн эмэгтэйчүүдийг чадавхжуулах хөтөлбөрийн оролцогчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс орон нутгийн эмэгтэйчүүдээ чадавхжуулж, бэхжүүлэх, өсгөж хөгжүүлэх энэ их ажилд нь өндөр амжилт хүсэн ерөөе.

93, Баатарзориг дарга харуулья.

Б.Баатарзориг: Та бүхний өдрийн амгаланг айлтгая. Адьшаа гишүүний асуултад хариулъя. Төрийн албаны шинэтгэлийн хүрээнд иж бүрэн цалин хөлсний шинэтгэлийг үе шаттайгаар судалж, оруулж ирж байгаа. Энэ жилийн тухайд бол Төсвийн хуулиар гол 5 алхмын шинэтгэл хийхээр оруулж ирсэн. Төрийн захиргааны болон төрийн тусгай албан хаагчдын цалинг 15 ангилал зэрэглэлтэй, дотроо 5, 5 хүртэл шатлалтай. Энэ бүхнийг багасгаж, ангилал доторх шаталтыг багасгаад хамгийн өндөр шатлалаар нь авч, цалинг нэмэгдүүлэх ийм зүйлүүдийг хийж байна.

Хоёрдугаарт нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдэж байгаатай холбоотойгоор цалин хөлс нь нэмэгдээгүй, бага цалинтай төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлэх асуудал бас тусгагдаж орж ирсэн.

Гуравдугаарт нь төрийн албан хаагчид 5 жил тутам хүлээлтийн горимоор ажилласан жилийн нэмэгдлээ хүлээдэг байсан бол жил бүхэн олгох ийм зохицуулалт орж ирж байгаа.

Дөрөвдүгээрт нь төрийн захиргааны албан хаагчид орон нутгийн нэмэгдэлтэй болох.

Тавдугаарт нь гүйцэтгэлд суурилсан, үр дүнд суурилсан цалин хөлсний нэмэгдэл гээд олон багц асуудлууд орж ирж байгаа юм.

Дараагийн асуудал. Ер нь орон нутагт төрийн захиргааны албан хаагчид, төрийн байгууллагуудын ажиллах нөхцөл туйлын хангалтгүй байгаа тохиолдлууд олон байна. Одоо ер нь сумд очиход хамгийн муухан барилгыг нь сонгоод очиход л захиргааны барилга болж үлдэж байна.

Мөн төрийн захиргааны албан хаагчдын ажиллах нөхцөл, орчин үеийн тоног төхөөрөмжөөр хангагдсан байдал, хөрөнгө оруулалтын байдал бол

хязгаарлагдмал байгаа. Ийм учраас энэ асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэх захиргааны шинэтгэлийн реформын үе шат эхэлж байгаа.

Хоёр дахь асуудал. КОВИД-ын хуультай холбоотой мөн хууль бус томилгоотой холбоотойгоор Төрийн албаны зөвлөлөөс олон ажлууд зохион байгуулсан. Та ч гэсэн сая дурдаж хэлж байна. Өнгөрсөн жил 417 байгууллагад Төрийн албаны зөвлөлөөс хяналт шалгалт зохион байгуулсан. 5803 төрийн албан хаагчид хамрагдсан. 577 төрийн албан хаагч хууль бусаар томилогдсонтой холбоотойгоор Төрийн албаны зөвлөлөөс ажлаас нь чөлөөлөх шийдвэр өгч, энэ шийдвэр хэрэгжсэн байгаа. КОВИД-ын хуультай холбоотойгоор 2708 хүн 3.2-ыг барьж томилогдсон байсан. Болзол шаардлага хангагдаагүй 1319 хүнийг чөлөөлөх ажлуудыг бас хийсэн байгаа.

Төрийн албаны зөвлөлөөс сонгон шалгаруулалт зохион байгуулаад нэгд орсон хүнийг нэр дэвшүүлэхэд томилоогүй тохиолдол гарсан. Зөвхөн хуульд заасан үндэслэлээр л 1 удаа буцаах ийм боломж нь томилохгүй этгээдэд байдаг. Энэнээс өөрөөр буцаасан, эс үйлдэл хийсэн тохиолдолд Төрийн албаны зөвлөл хууль хэрэгжүүлэх ажлуудыг үе шаттайгаар хийж байгаа болно. Таны асуултад товч хариуллаа.

Г.Занданшатар: Наянтайн Ганибал гишүүн.

Н.Ганибал: Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах энэ хуулийн төслийг дэмжиж байгаа. Тэгэхдээ энэ хуульд хэд хэдэн бас дутагдалтай тал байна. Ер нь хөдөө орон нутагт сумын хэмжээнээсээ хамаараад 50-100 төрийн албан хаагч нар ажиллаж байгаа. Эд нарын маань бараг 70, 80 хувь нь энэ зохицуулалтаар бас мөнгөн урамшуулал авах ийм боломжоор хангагдах юм байна.

Харамсалтай нь яг одоо Монгол төрийн үйлчилгээг анхан шатанд хүргэдэг төрийн хамгийн чухал албан тушаалтан болох энэ багийн Засаг дарга нар маань урамшууллын асуудал нь хөндөгдсөнгүй. Үнэхээр багын дарга гэдэг өнөөдөр төрийн бүх үйлчилгээг иргэдэд хүргэдэг. Дээрээс нь ер нь тэр баг дээр болж байгаа бүхий л арга хэмжээг зохион байгуулдаг. Буяны ажилд гэхэд 1 сарынх нь цалингийн бас хэдэн хувийг нь өгчхөж байх шиг байгаа юм. Тэр баг дээр хүн эмчилгээнд явлаа гэхэд бас эргэлт гээд тодорхой хэмжээнд зарчхаж байгаа шиг байгаа юм. Тодорхой арга хэмжээ зохион байгуулсан тэр болгонд өөрсдийнхөө мөнгөөр, цалингаараа арга хэмжээг зохион байгуулж, ингэж явдаг хүмүүс.

Тэгэхээр ер нь улс төрийн албан тушаалтан гээд энэ хүмүүсийг орхиж болохгүй л дээ. Энэ хүмүүс 4 жил хийх энэ ажилдаа хамгийн сайн ажиллахын тулд тэр цалин, урамшуулал нь хангалттай л байх ёстой. Ямар ч үйл ажиллагааны зардалгүйгээр өнөөдөр багын дарга нар маань ажлаа хийдэг. Тэгэхээр энэ дээр 4 жилийн нэмэгдэл гэдэг ийм бас боломжийг нээх ийм боломж байгаа юу гэдгийг бас асууя.

Дээр нь мэдээж Засаг даргын Тамгын газарт хэдэн харуул, үйлчлэгч нар байдаг. Сумын эмнэлэг, цэцэрлэгт, сургуульд хэдэн үйлчлэгч, харуулууд байдаг. Энэ хүмүүс бол сумын бүхий л ажлыг хийдэг. Энэ сумын хөгжил, цэцэглэлт, бүх юмтай байнгын холбогдож байдаг ийм хэдэн төрийн үйлчилгээний албан тушаалтнууд урамшуулалгүй үлдээд байна.

Өнөөдрийн байдлаар мэдээж багш нар маань, эмч нар маань авч байна. Энэ дээр бол бас анхаарах ёстой юм уу даа гэж хууль санаачлагчид болон энэ Төрийн албаны зөвлөлийнхөнд бас хэлье. Баярлалаа.

Г.Занданшатар: Үг хэлчихлээ тиймээ? Жамбын Батсуурь гишүүн.

Ж.Батсуурь: Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж гарсан хөдөөгийн сумд, түүний Тамгын газарт ажиллаж байгаа төрийн албан хаагчдад нэмэгдэл өгч байгаа энэ асуудлыг ерөнхийд нь дэмжиж байгаа. Гэхдээ энийг цогцоор нь оруулж ирж, иж бүрэн шинэчлэл хийх ёстой гэж ингэж ойлгож байгаа юм. Төрийн алба хэт данхайдаг, данхайж байгаа асуудал ерөөсөө Засгийн газар, яам, агентлаг, Ерөнхийлөгчийн тамгын газар, Засгийн газар, Их Хурал гэж данхайдаг. Тэгээд ямар нэгэн хэмнэлт ярих болонгуут анхан шатанд ярьдаг. Ерөөсөө л нөгөө хотонд байгаа төлгөө бариад иддэг шиг л анхан шатанд ажиллаж байгаа хүмүүсээс л хэмнэлт ярьж эхэлдэг. Энэ асуудлыг зогсоох хэрэгтэй.

Өнөөдөр Монгол Улсын энэ түгжрэл, энэ стресс, энэ утаа, энэ нөхцөл байдал юу вэ гэхлээр Улаанбаатарт амьдарч байгаа хүн, аймагт амьдарч байгаа хүмүүсийн амьдралын чанар адилхан байх ёстой. Аймагт амьдарч байгаа хүн, суманд амьдарч байгаа хүмүүсийн амьдралын чанар адилхан байх ёстой. Гэтэл бүх эрх мэдлийг төвд татсанаар төрийн албын чанар, чансааг төвдөө илүү онцгойлон үзсэнээр анхан, дунд шатны төрийн албан хаагчдын чанар, чансаа муудаж, тэнд ажиллах тэр алслагдсан хөдөө очоод энэ хэмжээний цалин аваад ажиллах чанартай боловсон хүчнүүд хөдөөд очихгүй байгаа.

Тийм учраас энэ нэмэгдлийг дэмжиж байгаа. Үүний хажуугаар энийг зөвхөн ингэж тастаж авч, төрийн захиргааны албан хаагч гэхээс илүү аймаг, суманд ажиллаж байгаа дан ялангуяа суманд ажиллаж байгаа төрийн бүх үйлчилгээний бөгөөд төрийн захиргааны, улс төрийн албан тушаалтнуудын цалинг иж бүрэн нэмэх ёстой л гэж ингэж ойлгож байгаа юм. Иж бүрэн нэмэх ёстой. Тэгж байж төвлөрөл саарна. Тэгж байж аймагт дунд шатанд хөгжил ирнэ. Тэгж байж анхан шатанд, суманд хөгжил, суманд

амьдрах хүн, багт ажиллах хүмүүсийн чанар сайжирна.

Тэгэхгүйгээр одоо баг, сумаа хаядаг, баг, сумаас нь байнга хэмнэлт хайдаг ийм байдлаар явах юм төвлөрөл улам нэмэгдэнэ, түгжрэл улам нэмэгдэнэ, утаа улам нэмэгдэнэ. Сүүл дээрээ одоо хэн нь хэнээ боомилсон ийм хөгжлийн гарцгүй ийм нөхцөл рүү орох юм. Ийм учраас ингэж сугалж авч биш, иж бүрэн байдлаар цалинг нэмэх ёстой. Анхан шатанд ажиллаж байгаа төрийн үйлчилгээний албан хаагчид, төрийн захиргааны албан хаагчид, төрийн онцгой албан хаагчид, улс төрийн албан хаагчдын бүгдийнх нь цалинг нэмэгдүүлэх, дээр нь тасралтгүй 5, түүнээс дээш ажилласан төрийн албан хаагчдыг бол энэ мөнгөн урамшуулал олгох нь зүйтэй гэж ингэж үзэж байгаа юм.

Дараагийн нэг асуудал бол энэ төрийн захиргааны албан албан хаагч нарт нөгөө дипломын асуудал яригдаж эхэлсэн. Би Төрийн албаны зөвлөлийн даргаас асуух гэж байна. Тэгээд нэг гарч ирснээ хэдэн хүн ч билээ зарлаад нам чимээгүй болчихлоо. Тэр дипломгүй хүмүүс цаашаа ажиллах юм уу, ажиллахгүй юм уу, хойшид ямар чиг баримжаатай ажиллах юм бэ гэсэн асуултыг бас асууж байна. Баярлалаа.

Г.Занданшатар: 93 Балдангийн Баатарзориг дарга, Төрийн албаны зөвлөлийн дарга харуулъя.

Д.Баатарсайхан: Батсуурь гишүүний эхнийх нь санал байлаа. Дипломын асуудалтай холбоотой асуудал дээр Төрийн албаны зөвлөл Боловсролын яам, Мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтарч энэ сургууль төгсөгчдийн цагаан номын эх үүсвэрт тулгуурлан хяналт хийх ажил эхлэл эхэлсэн байгаа. Тэгээд зарим байгууллагууд дээр салбарын байгууллагуудтай хамтарч хийсэн. 23 онд багтаагаад бид ер нь нийт төрийн албан хаагчдын дипломын асуудал дээр бас

анхаарч ажиллана гэж төлөвлөсөн байгаа. Баярлалаа.

Г.Занданшатар: Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Дамдинсүрэнгийн Өнөрболор, Жаргалтулгын Эрдэнэбат, Чинбатын Ундрам нарын урилгаар Сэлэнгэ аймгийн Мандал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 1981 оны 10е ангийн төгсөгчдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэнд сайн сайхан, эрүүл энх, аз жаргалыг хүсэн ерөөе. Бүх гишүүдийн нэрийн өмнөөс. Цэвэгдоржийн Туваан гишүүн.

Ц.Туваан: Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах цаг нь бол өнгөрчихсөн юм. Тэх, энэ өнгөрсөн хугацаанд би маш олон удаа хэлж ирсэн. Энэ хөдөө орон нутагт төрийн албан хаагчид чинь ажиллахгүй байна. Орон тоо дутуу байна гэдэг чинь яагаад вэ гэхлээр авч байгаа цалин нь хүрэхгүй юм чинь. Хэн сонирхож очих вэ дээ тийм ээ? Тэр гайгүй цаг үед шүү. Юмны үнэ нь гайгүй, инфляцын ийм өндөр биш, валютын ханш ийм өндөр биш цагт. Одоо бол бүр л хэцүү байгаа.

Тэгэхээр Монгол Улс төртэй улс юм бол бас тэнд ажиллаж байгаа хүмүүсийнхээ энэ цалин цавуу, ахуйн хангамжийн асуудлыг ярих цаг нь өнгөрчихсөн. Өнгөрсөн хугацаанд бол бид нар энэ ганцхан төрийн захиргааны гэлтгүй бүх улс хүмүүсийнхээ цалингийн асуудлыг нэм гэдэг ийм шаардлагыг тавьж ирсэн. Монгол Улсын Засгийн газрын зүгээс энэ 23 оны төсөв дээр энэ асуудлыг цогцоор нь оруулж ирнэ. Нийгмийн даатгалын ерөнхий болон багц хуулиудыг оруулж ирж, энэ цалин тэтгэврүүдийг бүгдийг нь ярина гэсэн боловч энэ удаагийн төсөв дээр хангалтгүй орж ирж байгаа юм. Бид нар дээр харахаар, туршлагаас харахаар сүрэг хонинд орсон чоно шиг оочин цоочин,

алаг цоог алагчлах байдлаар энэ төрийн албаны цалингууд нэмэгдлүүд ингэж яваад байгаа юм. Одоогийн энэ хууль дотор орж ирж байгаа энэ 5 жилд тутам 6 сарын цалинтай тэнцэх урамшуулал гээд. Энийг ер нь жоохон өргөн хүрээнд авч үзье. Тэгээд хууль санаачлагч энийг хугацааг нь 24 оны 1 сарын 1-нээс гэж саналаа татаж авч байна лээ. Тэгэхээр энэ дээр бол нэгмөсөн бүтэн байдлаар нь, цогц байдлаар энэ асуудлыг ярья гэсэн ийм саналтай байгаад байгаа юм.

Тэр төрийн үйлчилгээний албан хаагчид гээд хамгийн хүнд хүчир ажил хийдэг энэ хэд рүүгээ л нэлээн дайрах юм. Сая өнгөрсөн төсөв батлагдахад юу боллоо? Сануулчихъя. Тэр нь болохоор нөгөө төрийн үйлчилгээний албан хаагчдыг цомхотголд оруулаад, гэрээт ажилтан болгоод, тэгээд тоог нь цөөлөөд, орон нутагт нь цалин цавууг нь өгөхөөр ийм байдлаар шийдэж байсныг бас үйлдвэрчний эвлэлтэй бас бусад шаардлагуудыг тавьж байхад энийг болиулсан. Одоо дахиад цалин гээд яриад ирэхээр л ТЗ гээд л ороод ирэх юм. Энэ чинь яг нэг газраас, нэг тогооноос адилхан ажил хийгээд явж байгаа улсууд ингэж Үндсэн хууль зөрчиж алагчилж болдог юм уу?

Тэгэхээр энэ дээр цогцоор нь ярьчихъя. Нэгэнтээ 23 оны төсөвтэй холбоотой асуудал байхгүй юм бол энийгээ өргөтгөөд бүгдийг нь оруулмаар байна. Цалингийнхаа энд тэнд шийддэг асуудлуудыг бүр нэгтгээд нэг шийдэх ийм шаардлага байгаа гэж ингэж бодож байна. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ажлын албаныхан яах юм? Энэ багийн Засаг дарга нар гээд улсууд байна. Энэ хүмүүс бас яах юм? Маш бага цалингаар маш их ажил хийдэг. Хүн болгон багийн дарга нар руугаа л ярьдаг.

Тэгэхээр энэ асуудлыг хэдүүлээ цогцоор нь ярья гэж ингэж бодож байна. Орон нутагт байгаа энэ төрийн захиргааны ТҮ-гийн ажилчид чинь мал бүхий иргэн байдаг юм. Давхар. Хамаатан

садан дээрээ цөөхөн мал тавьчихдаг. Түүнээсээ гаргаж идээд, мах өрдөхгүй тулдаа л болоод байсан. Одоо тэгсэн чинь мал нь борлогдохоо больчихсон, мах үнэгүй болчихсон, зөрөөд юмны үнэ тэнгэрт хадчихсан. Ялангуяа тэр Монголчуудын түгээмэл хэрэглээ мах, гурил гэдэг энэ 2 бүтээгдэхүүн 2-уулаа хүнд болчихсон. Гурилынх нь үнэ өсчихсөн, махных нь үнэ буурчихсан.

Тэгэхээр энэ хүмүүс чинь бүр л хэцүү болж байгаа юм. Энэний түрүүн бас би хэлсэн. Энэ төрийн захиргааны албан хаагчид хөдөө орон нутагт чөлөө аваад самарт явж байна гээд хүмүүс их эгдүүцэж байна лээ. Ер нь яг үнэндээ энэ самар, Солонгос 2 руу энэ төрийн захиргааны албан хаагчид чинь их хэмжээгээр явж байгаа нь үнэн шүү дээ.

Г.Занданшатар: Үг хэллээ. Ёндонпэрэнлэйн Баатарбилэг гишүүн.

Ё.Баатарбилэг: Гишүүдийнхээ өглөөний амрыг айлтгая. Тэгэхээр энэ хуулийн үзэл баримтлал анхнаасаа сумын Тамгын газрын энэ сул орон тоо маш өндөр байна. Хөдөө сумдад Тамгын газарт ажиллаж байгаа төрийн захиргааны ажилтнуудад цалин, хөлс бага байна. Эд нартаа 5 жил тутам 1 удаа урамшуулал олгоё гэдэг ийм асуудал яригдсан. Ийм хуулийн төсөл. Энэ бол тэтгэмж биш, халамж биш, цалингийн нэмэгдэл биш. 1 удаа юм олох л юм байгаа юм л даа.

Тэгээд Төрийн албаны зөвлөлөөс 11 сарын 2-ноор орон тооны мэдээлэл юмнууд авсан. Тэгээд энэ сул орон тоонууд, сумдын Тамгын газар одоо нийтдээ аймаг, сумын төвийн Тамгын газрын Иргэдийн төлөөлөгчдийн сул орон тоо 1238-аас 810 нь сумын Тамгын газрын албан тушаалтнууд байгаа байхгүй юу. Сумын Тамгын газар хамгийн бага цалинтай. Сумынхаа хамаг юмны түрүүнд явж байдаг л хэдэн албан хаагчдын асуудал.

Тэгээд энийг нь анхнаасаа дэмжээд явсан. Тэгэхээр энэ дээр хэдэн тоо баримтуудыг нь харахаар хэдэн аймаг байгаа. Баян-Өлгий, Дархан-Уул, Дорноговь, Дорнод гэсэн энэ 4 аймаг дээр бараг 100-гаад төрийн албан хаагчид, төрийн захиргааны албан хаагчийн сул орон тоо байгаа. Бусад аймгууд дээр 2, 3, 4, 5 гэсэн цөөн тооны албан тушаалтнууд. Аймгийн төвийн сумдын орон тоо, сул орон тоон дээр байгаад байна лээ. Тэрнээс үлдсэн тэр 810 нь яг хөдөө сумын Тамгын газруудын орон тооны юм байгаад байгаа юм л даа. Тэгээд бас манай зарим гишүүд аймгийн төвийн сумыг хамруулъя гэхээр нь энэ тоо баримтыг гаргаж үзсэн юм.

Тэгэхээр Төрийн албаны зөвлөл дээр судалгаа ямархуу юм байдаг юм? Саяын энэ нэр дурдсан 4 аймаг дээр яагаад ийм олон тоогоороо орон тоо дутуу байгаа юм? Бараг Тамгын газрынх нь тал нь байхгүй байна шүү дээ. Сул орон тоотой. Тийм. Тэгэхээр энэ ямархуу, ямар учраас ийм энэ саяын нэрлэсэн 4 аймгийн төвийн Тамгын газар дээр ийм орон тооны дутагдалтай байгаа юм гэдгийг нэгдүгээрт хэлээдхээч.

Хоёрдугаарт, бусад аймгууд дээр тийм юм алга. Тийм олноороо дутуу байгаа гэсэн ийм тоо баримт байхгүй байна. Бодвол түр үүрэг гүйцэтгэгч энэ тэрээр ажиллаж байгаа юм уу? Тэгэхээр миний санал төслийг орж ирсэн хувилбараар нь батлаад эхний ээлжид энэ хөдөө сумдын Тамгын газрын тэр сул орон тоо маш олон байгаа хөдөө сумдын Тамгын газрын ажилтнуудаа тасралтгүй гэж тэр шалгуурыг нь тавиад, тасралтгүй ажилласан, хөдөө сумдын гэдгээр нь явуулах хэрэгтэй л гэж ингэж үзээд байгаа юм. Тасралтгүй 5 жилээс дээш, тасралтгүй ажилласан.

Тэгэхгүй болохоор энийг тасралтгүй гэдгийг нь бас Байнгын хороо ажлын хэсэг дээр тасралтгүй гэдгийг нь байхгүй болгоод, Тэгэхээр хэсэг хугацаанд өөр юман дээр ажиллаж байгаад 5 жилийнхээ өмнө Тамгын газар руу орж ирсэн хүн

чинь бараг нэмэгдэл авч болохоор юм шиг, урамшуулал авч болохоор юм шиг болгоод олон янзын тийм саналууд орж ирээд, энэ анх орж ирсэн Чинзориг гишүүний өргөн барьсан анх орж ирсэн концепцоосоо жаахан хүрээ нь өрөгдөөд, үзэл баримтлал нь жаахан өөр болчих гээд байгаа юм л даа. Тэгэхээр энэ дээр нэгдүгээрт Төрийн албаны зөвлөл тоо, тэр 4 аймаг дээр яагаад тийм байгаа гэдгийг хэлээдхээч.

Хоёрдугаарт, тэр тасралтгүй 5 жил ажилласан. Хөдөө сумдын гэдгээрээ эхний ээлжид явчихъя гэдэг ийм саналтай байгаа. Анхнаасаа тэр сумдын Иргэдийн хурлын ажлын алба гээд хоёр, гуравхан орон тоонуудыг анхнаасаа оруулаад ирсэн байсан бол саяын энэ олон хүрээ өргөтгөх гэсэн энэ саналууд гарахгүй л байсан юм л даа. Уг нь бол тэд нарыг оруулчихмаар байгаа юм. Тэрний дагуу гуя дагаж хүзүү гэх гээд байгаа учраас энэ бол боломгүй байна.

Г.Занданшатар: 93 Балдангийн, Хэн хариулах уу? Эрдэнэбат дарга хариулъя. 95 байна уу? Жамбаагийн Эрдэнэбат 94.

Ж.Эрдэнэбат: Баатарбилэг гишүүний асуултад хариулъя. Аймгийн төвийн сумын Засаг даргын Тамгын газрын сул орон тооны мэдээлэл дээр бол энэ Дархан-Уул, Баян-Өлгий, Дорноговь, Дорнод аймгуудын сул орон тоо бол өндөр байгаа. Үүнтэй холбоотойгоор бид бас лавлагааг тухайн Дархан-Уул аймгийн ч юм уу, салбар зөвлөлийн Нарийн бичгийн дарга руу утасдаж асуусан байгаа. Энэ яагаад энэ бусдаасаа өндөр гараад байна вэ? Энэ чинь танай дээр 47 ийм орон тоо байна гэж асуусан. Энэ дээр бол Дархан-Уул аймаг дээр 16 баг ажиллаж байгаа. Энэ 16 багт байгаа багийн зохион байгуулагч болон нийгмийн ажилтан ерөөсөө огт байхгүй байгаа гэж байгаа юм. Тэгэхээр 32 оронтой болчихож байгаа. Сая шинээр батлагдсан орон тоон дээр 6 орон тоо сул гэх мэтчилэн энэ багийн зохион

байгуулагч, нийгмийн ажилтантай холбоотойгоор энэ сул орон тоо өндөр байгаа юм. Баярлалаа.

Г.Занданшатар: Одоо санал хураалттай тул гишүүд чуулганы танхимд цуглаарай. Тогтохсүрэн даргаа санал хураалтад бэлдье. Ёндонпэрэнлэйн Баатарбилэг гишүүн тодруулж асууна. 1 минут.

Ё.Баатарбилэг: Төрийн албаны зөвлөлөөс тодруулъя. Эртээд Сэлэнгэ аймагт, Хэнтий аймагт гээд бас орон тооны дутуу байна гээд яриад байсан. Тэгээд саяын энэ дээр болохоор яг гишүүдийн ярьсан тоо биш, нэлээн бага тоо орж ирчхээд сая Дархан дээр та нар болохоор багийн зааварлагч нарын асуудлыг ярьж байна шүү дээ. Тэгэхэд нөгөө Хэнтий, Сэлэнгэ аймгуудынх чинь бас ийм юмнууд байгаа юм биш үү? Та хэд яг багийн юмнуудыг нь заримыг нь аваад, заримыг нь аваагүй байна гэдэг ийм асуудал яригдаад байна шүү дээ. Төрийн албаны зөвлөл. Одоо Хэнтийг жишээлэхэд багийнхыг оруулаад 10 гаруй гээд тэгж байна шүү дээ. Тэгэхэд та нар Дархан дээр багийнхыг сая оруулчихсан. Хэнтийнхийг оруулаагүй орж ирсэн байна шүү дээ гэж харагдаад байна. Энэ дээр тодруулга өгөөч.

Г.Занданшатар: 94 Жамбаагийн Эрдэнэбат. Сургалт судалгаа, мэдээллийн сангийн дарга. Төрийн албаны зөвлөл.

Ж.Эрдэнэбат: Энэ бол ерөөсөө бүх салбар зөвлөлүүдээс бүгдээрэнд нь ижил загвараар Excel файл өгч нэгтгэж авсан ийм дүн байгаа. Энэ дээрээ бол бүгд ижил түвшинд нь авсан байгаа. Тэрнээс биш зарим газарт нь багийн зохион байгуулагчийг оруулаад зарим аймаг дээр нь оруулаагүй гэсэн юм байхгүй. Бүгд дээр нь оруулаад явсан байгаа.

Г.Занданшатар: Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Жаргалтулгын Эрдэнэбат, Чинбатын Ундрам, Дамдинсүрэнгийн Өнөрболор

нарын урилгаар Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн хамт олны төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс боловсорч, соён гэгээрүүлэх их үйлст нь өндрөөс өндөр амжилтыг хүсэн ерөөе. Сайн, сайхныг хүсье.

Тодруулах юм байхгүй л дээ энэ. Ажлын хэсгийн нэр өгөөгүй байна. Одоо Даваажанцангийн Сарангэрэл гишүүн алга байна. Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн алга байна. Санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй 2 санал байна. Зарчмын зөрүүтэй 2 саналаар санал хураалт явуулна. Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжээгүй 2 саналаар санал хураалт явуулна. Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжээгүй санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн аймгийн төвөөс бусад гэснийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Цагаанхүүгийн Идэрбат. Идэрбат гишүүн саяын асуултад хариулангаа үг хэлж болно. Үг хэлэхгүй байсан ч болно. Хэлэхгүй юм уу тээ? Цагаанхүүгийн Идэрбат гишүүн.

Ц.Идэрбат: Та бүхэнд өглөөний мэнд хүргэе. Төрийн албаны хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотой асуудал дээр Төрийн байгуулалтын байнгын хороон дээр аймгийн төвийн сумдын төрийн албан хаагчдын энэ 5 жилийн урамшууллын асуудлыг гаргаж тавьсан. Харамсалтай нь дэмжигдээгүй. Яагаад энийг гаргаж тавих болсон шалтгаан гэвэл тодорхой байгаа. Үнэхээр аймгийн төвийн сумууд бас боловсон хүчний үнэхээр асуудалд орсон. Сая Төрийн албаны зөвлөлөөс ирсэн тэр хүснэгт дээр Хэнтий аймаг 3 гэж байгаа. Өчигдөр надаас

дахиад нэмэгдэж байна лээ шүү. 4 болж байгаа.

Дээрээс нь Дархан-Уулын тэр багийн зохион байгуулагч, нийгмийн ажилтнуудыг оруулаад өндөр гарсан байна шүү дээ. Яг Хэнтийгийн тоог гаргахдаа тэрийг нэмээгүй байна лээ. Тэрийг нэмэхээр Хэнтий аймгийн Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газраас 10 хүн дутуу гэсэн ийм мэдээ гарна. Тэгэхээр танай мэдээ бас жоохон хуудуутай ирсэн байна лээ. Цаанаасаа дутуу өгсөн байх. Тэгэхээр ер нь аймгийн төвийн сум дээр ямар асуудлууд үүсдэг вэ гэхээр хамгийн их сэлгэлт хөдөлгөөн явагдаад байдаг. Нэг аятайхан залуу мэргэжилтэн орлоо гэхэд төд удалгүй л өөр тийшээ шилжээд явчихдаг. Өөр байгууллагууд, агентлагууд нь аваад явчихдаг. Тэгээд л сумын, аймгийн төвийн сумын Засаг даргын Тамгын газар, баг, нийгмийн ажилтан, зохион байгуулагч нар зүгээр л дамжин өнгөрч төрийн албан хаагчийг бэлдэж өгдөг ийм л юм руу орчхоод байгаа юм л даа.

Тийм учраас аймгийн төвийн энэ сумын, аймгийн төвийн сумын Засаг даргын Тамгын газрын энэ ажилтнуудыг энэ 5 жилийн урамшуулалд оруулж өгөөч. Энэ Байнгын хороон дэмжээгүй саналыг бас та бүхэн дэмжиж, босгож өгөөч гэж би гишүүдээс бас хүсэх гэж байгаа юм.

Нөгөө талдаа энэ гишүүдийн хэлж байгаа төрийн албаны энэ цалингийн энэ хувь, энэ зүйлүүд рүү одоо бүр цогцоор нь томоор харах зайлшгүй шаардлага гарсан. Энэ төрийн захиргаа гэж явж байгаа боловч цаана нь тэр төрийн үйлчилгээнийхэн гэдэг нэлээдгүй хүмүүс бас үлдэх гээд байгаа. Тэгэхээр энэ дээр ч гэсэн гишүүд маань бас дэмжиж өгөөрэй гэж та бүхнээс бас хүсье. Баярлалаа.

Г.Занданшатар: Дэмжсэн, дэмжээгүй л үг хэлнэ. Дэмжээгүй юм уу, дэмжсэн үг хэлэх юм уу? Санал гаргасан гишүүн. Цэвэгдоржийн Туваан гишүүн. Дэмжсэн, дэмжээгүй үг хэлж болно.

Ц.Туваан: Одоо бас нэг ч гэсэн хүн цалин цавуугаа нэмэгдүүлж байгаа, нэмэгдүүлэх ийм боломж гарч байгаа учраас дэмжье. Тэгээд ер нь цогцоор нь гээд одоо авч үзмээр байгаа юм. Сая Идэрбат гишүүн ч гэсэн бас хэллээ. Өмнөх гишүүд ч гэсэн хэллээ. Тэгэхээр энэ Байнгын хороон дээр дэмжээгүй саналыг хэдүүлээ бас дэмжихгүй буюу кноподоо хүрэхгүй санал өгч байж байж энэ санал нь босож ирэх байх. Манай гишүүдэд анхааруулаад хэлчихье. Тэгээд энэ дээр энэ санал дэмжигдсэнээр аймгийн төвийн сумуудыг энэ тэр гээд ялгачихсан байгаа энэ ялгавартай байдал нь ч гэсэн бага ч гэсэн бас арилах юм байна гэж ингэж ойлгож байгаа. Тэгээд энэний дараагийнх дээр тэр Чинзориг гишүүнээ ТҮ чинь бас орж ирсэн дараагийн санал уу? Ороогүй байгаа юу? Тэгэхээр манайхан Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжихгүй байж байж дэмжье. 5 хүн ч гэсэн 5 жилийн нэмэгдлээ аваг дээ.

Г.Занданшатар: Санал хураалт явуулъя. Ирц их өндөр байна даа. Яах юм бэ, зүгээр үү? Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжээгүй саналаар санал хураалт явуулъя.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн аймгийн төвөөс бусад гэснийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Цагаанхүүгийн Идэрбат. Санал хураалт.

6 гишүүн дэмжиж, 52 гишүүн татгалзаж, Идэрбат гишүүний санал дэмжигдэж Төрийн байгуулалтын дэмжээгүй санал уналаа.

Засгийн газар журмыг нь батлах юм чинь тэгээд учир нь олдох байлгүй.

2.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

51.3 аймгийн төвөөс бусад сумын болон нийслэлийн Багахангай, Багануур дүүрэгт тасралтгүй ажиллаж байгаа

төрийн захиргааны албан хаагчид 5 жил тутамд 1 удаа 6 сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгох бөгөөд мөнгөн урамшуулал олгох журмыг Засгийн газар батална. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сайнбуянгийн Амарсайхан, Цагаанхүүгийн Идэрбат, Цэндийн Сандаг-Очир, Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн. Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн, Сайнбуянгийн Амарсайхан гишүүн, Нямаагийн Энхболд гишүүн, Цэндийн Сандаг-Очир, Ёндонпэрэнлэйн Баатарбилэг, Цэвэгдоржийн Туваан гишүүн. Дэмжсэн, дэмжээгүй 3 л хэлнэ шүү. Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Тэгэхээр ийм байгаа юм гишүүд ээ,

Нэгдүгээрт, манайхан жаахан ойлголт буруу байгаа юм. Суманд байгаа боловсролынхон 5 жил тутамд 1 удаа 6 сарын тэтгэмжээ авч байгаа. Соёлынхон 5 жил тутамд авч байгаа. Эмч нар бүр 3 жил тутамд авч байгаа юм. Тэгээд суманд ажиллаж байгаа хүмүүсээс энэ төрийн захиргааны жинхэнэ албан хаагчид хоцорчихсон юм.

Тийм учраас энэ хууль бол төрийн захиргааны жинхэнэ албан хаагчдад 1 удаагийн 5 тутамд олгох нэмэгдлийн асуудал байгаа юм.

Хоёрдугаарт нь ийм юм байгаа юм. Бид хэд л барьсан юм л даа. Өргөн барьсан. Өргөн барихдаа гэхдээ явцуу хүрээнд хандчихсан байна лээ. Тэр нь яасан гэхээр сумын Засаг даргын Тамгын газар гэхчхэн юм. Тэгээд сумын Засаг даргын Тамгын газарт ордоггүй хэд хэдэн албан тушаалтанд суманд ажиллаж байгаа юм. Татварын байцаагч, нийгмийн даатгалын байцаагч, халамжийн ажилтан, газрын тос, газар зохион байгуулагч, байгаль орчны байцаагч, Иргэдийн Хурлын Нарийн бичгийн дарга, ажилтан, улсын бүртгэлийн ажилтан гэсэн хүмүүс хоцорчхоод байгаа байхгүй юу. Тэгэхээр

миний томьёолол ямар томьёолол байгаа гэх дээр зэрэг суманд болон Нийслэлийн Багахангай, Багануур дүүрэгт тасралтгүй ажиллаж байгаа төрийн захиргааны жинхэнэ албан хаагч гэсэн байхгүй юу.

Тийм учраас энэ томьёолол дотор бүгд миний энэ сая хоцрогдсон хүмүүс нь орчхож байгаа юм. Тэгээд бид нар бол нэгэнт хандаж байгаа, цогцоор нь хандъя гээд сая Туваан гишүүн нарын ярьж байгаа мөн. Тамгын газар гээд 5 хүн авчихгүй, суманд ажиллаж л байгаа юм чинь ялгаагүй авах ёстой. Тийм учраас энэ агуулгаар нь хандаад жаахан өргөн хүрээнд хандчихвал яасан юм бэ гэсэн ийм санал байгаа юм. Тийм учраас энэ саналыг та бүгдийг дэмжиж өгөхийг хүсье. Баярлалаа.

Г.Занданшатар: Дэс дарааллаараа. Сайнбуянгийн Амарсайхан гишүүн байгаа.

С.Амарсайхан: Энэ зарчмын зөрүүтэй санал дээр Багануур, Багахангай гээд 2 дүүрэг орчихсон байгаа. Улаанбаатар хотын алслагдсан 3 дүүрэг Налайхыг нэмж оруулья гэж байгаа Их Хурлын даргаа. Яагаад гэвэл бас энэ 3 дүүрэг 3-уулаа алслагдсан дүүрэг, газар нутгийн хувьд ч, байршлын хувьд ч, зарим аймгуудтай ялгаагүй ийм ижил төстэй орчин нөхцөлд байдаг.

Тэгэхээр 3 дүүргийн нэгийг орхиод, 2-ыг нь оруулчхаж болохгүй учраас гурвууланг нь оруулаад явъя гэсэн ийм санал нэмж гаргаж байгаа юм. Тэгээд энэ дээр бас дэмжиж шийдвэрлэж өгөхийг хүсье.

Г.Занданшатар: Энэ Амарсайхан гишүүний гаргаж байгаа санал бол үндэслэлтэй бөгөөд Үндсэн хуулийн ялгаварлан гадуурхахгүй, тэгш байх зарчмыг жигд хангахгүй бол 3 дүүргийн нэгийг нь үлдээхээр энэ ялгаварлаж байгаа тийм байдал үүсэх учраас Үндсэн хуульд нийцүүлэхийг чиглэл болгож байна. Нямаагийн Энхболд гишүүн.

Н.Энхболд: Энэ анх санал болгож оруулсан хуулийнхаа үзэл баримтлалаас бүр өөр юм болоод явчихлаа даргаа. Тийм, энэ чинь бид нар сумд л хүмүүс дутагдалтай байна гээд л ажил хийх хүн олдохгүй байна гээд санаачилсан хууль байхгүй юу. Тэгээд сүүлдээ аймгийн төв рүү орлоо, одоо нийслэл рүү орлоо. Тэгээд өөрөө дөнгөж сая энийг нь дэмжээрэй гээд хэлээд байна шүү дээ. Тэгвэл ерөөсөө бүх, нийслэлийнхнийхээ ч гэсэн тийм болго. Хэрэв даргын хэлж байгаа тэр Үндсэн хууль ижил тэгш байх эрхтэй гэж байгаа бол тэгвэл бол Улаанбаатарынхаа ажилчдыг ч гэсэн нэм. Тэгж байж санал хураалга. Тэгэхгүй бол наадах анхны бид нарын оруулсан үзэл баримтлалаас их өөр болоод явчихлаа. Нэгдүгээрт. Болно л доо. Нэгдүгээрт.

Татаж авч болно бид нар. Ямар ч шатанд нь. Ярьж байгаад, тэгээд тэр дараа нь бүх хүмүүс, Улаанбаатар нийслэл, бүгдээрэнг нь нэмэх тэр хуулиа хүмүүс санаачлаад оруулна биз. Бид яах вэ, яг одоо тулгамдаад байгаа асуудал нь орон нутагт, суманд хүн ажиллахаа больчихлоо. Үүнийг нэг ч гэсэн асуудлаар цалинг нь тэртээ тэргүй нэмнэ гэж байгаа.

Дээр нь тэр урамшуулал нь бусад суманд ажиллаж байгаа хүмүүсээс хоцорчихсон байсан учраас энийг нь л гэсэн юм. Тэгээд орсон хууль маань шал өөр болж байгаа учраас би бол ер нь санал анх боловсруулсан улсуудтайгаа санал тавиад, хэлэлцүүлэг дуусаагүй байна. Ерөөсөө энийгээ татаж авдаг юм уу гэдэг асуудлаа ярина.

Тэгээд гишүүд нөгөө бүгдийг нь оруулъя, нийслэл, дүүрэг, аймаг, сум гээд санаачлаад явбал тэгээд л эхнээс нь дахиад л хэдүүлээ хэлэлцсэн биз тиймээ? Ийм байна шүү даргаа. Засгийн газартай яриагүй, төсөв мөнгөтэй холбоотой асуудал. Уг нь хуулиар бас ямар нэг хэмжээгээр зөвшилцөх ёстой. Их, бага нь хамаагүй л дээ. 1 тэрбум байна уу, 5 тэрбум байна уу, 100 тэрбум байна уу?

Ийм нэмэгдэж байгаа тохиолдолд уг нь Засгийн газрын саналыг авч хэлэлцэх ёстой бид нар. Тэгээд л чимээгүй л яваад л байгаа. Хэрэгжих хугацааг нь яах вэ, 24 оноос болох юм даа гэж. Тэгсэн одоо бүр бүгдээрээ боллоо. Энэ хуулийн маань утга алга болчихлоо. Эс үгүй бол дараа нь хамтраад ерөөсөө сум, нийслэл, дүүрэг бүгдийг нь оруулъя гээд явж болж байна.

Г.Занданшатар: Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Төмөртоогоогийн Энхтүвшин, Борхүүгийн Дэлгэрсайхан нарын урилгаар Дорноговь аймгийн Алтанширээ сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс та бүхэнд ажлын өндөр амжилт хүсэж, ард түмнийг төлөөлөх анхан шатны энэ үйл ажиллагаанд нь төр, ард түмнийг холбох их үйлсэд нь өндрөөс өндөр амжилтыг хүсье, ерөөе.

Санал хураалт явуулна. Энэ чинь үг хэлэх дарааллаараа Ёндонпэрэнлэйн Баатарбилэг. 2 дэмжсэн, 1 дэмжээгүй үг хэлсэн. Одоо Ёндонпэрэнлэйн Баатарбилэг гишүүн.

Ё.Баатарбилэг: Би Нямаа Энхболд даргын саналтай санал нэг байна. Энэ анхнаасаа хөдөө сумын Тамгын газрын тэр цалингийн нэмэгдлийн юманд нь ороогүй, хамгийн бага цалинтай, тэгээд хамгийн олон сул орон тоотой. Хамгийн гол нь сул орон тоо маш их байгаа байхгүй юу. 810 байна шүү дээ. Улсын хэмжээнд. Ийм хүмүүсийн 5 жил тасралтгүй ажилласан ийм хүмүүст 1 удаа урамшуулал олгох асуудал л яригдсан шүү дээ. Үгүй, энэ Засгийн газраас энэ Шинэ сэргэлтийн бодлого гээд хөдөө орон нутаг руу ажиллах, амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлъя. Хөдөө суманд очиж ажиллах, амьдрах энэ хүмүүсийг дэмжье гэдэг ийм бодлого явж байгаа. Тэрний хүрээнд орж ирж байна гэж бодсон шүү дээ.

Одоо хөдөө сум руу чинь цалин багатай, ажиллаж, амьдрах орчин нөхцөл сайнгүй байна гээд энэ залуучууд ялангуяа очиж ажиллахгүй байна шүү дээ. Тэр агуулгаар энэ хуулийн үзэл баримтлал чинь боловсрогдоод, гишүүд нь тийм агуулгаар энэ хуулийн төслийг өргөн барьсан шүү дээ. Тийм их мөнгө байгаад байгаа юм уу? Одоо улсын хэмжээнд тэгвэл бүх Тамгын газрын ажилтнуудынхаа, төрийн захиргааны ажилтнуудынхаа цалин хөлс, урамшууллыг нь нэмээд л явъя л даа. Хамгийн гол зарчим нь тэр орон нутгийн, хөдөө сумын Тамгын газрын нэмэгдэлд ороогүй ийм хүмүүсийнхийг л гэж оруулж ирээд явах юм бол дэмжих боломжтой байна. Нямаа Энхболд даргын саналтай санал нэг байна.

Хэрвээ ийм маягаар явах юм бол Нямаа Энхболд дарга бараг энэ хуулийнхаа төслийг татсан нь дээр.

Г.Занданшатар: Нэг бол татан авчихмаар юм. За хоёр, хоёр. Цэндийн Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Үгүй нэг энэ алслагдсан 3 дүүргийг юунд нь ад үздэг юм бэ? Онцлогтой шүү дээ. Онцлогтой. Газар зүйн хувьд, нэг талаас харахаар нийслэлийг яриад байдаг. Нийслэл дотроо болохоор хөдөө болчихдог байхгүй юу. Улс орны юм ярихаар ерөөсөө хаягдчихаад байдаг. Ингээд ерөөсөө явж ирээд анх удаа энэ Их Хурал харин, энэ эрх баригч нам энэ 3 дүүргийн онцлогийг харгалзаад Улсын Их Хурлын бие даасан тойрог болгож өгсөн юм. Тэрнээс урьд нь хотын дандаа дүүргүүдийн суганд хавчуулагдаж явж ирсэн. Тэгээд энэ яг сум, орон нутагтай адилхан төрийн албан хаагчид тэнд ажиллаж байгаа байхгүй юу.

Тийм учраас та бүхэн тэр дүүргүүдэд очоод алслагдсан дүүрэгт очоод ажил үз. Бас сул орон тоонууд хэдэн арваараа байж байгаа. Нөхцөл байдал нь яг адилхан, аймгийн асуудлыг, сумын

асуудлыг ярьдаг. Малтай бол малтай, өвөлжөө бэлчээр, газар, худаг усны асуудал ярьдаг ийм л орон нутаг байгаа юм шүү дээ. Энэ орон нутгийн онцлогийг нь харгалзаад үнэхээр энэ хуулийн чинь үзэл баримтлалыг тухайн орон нутаг, төрийн захиргааны албан хаагчдыг тогтвортой ажиллах нөхцөл бололцоог нь хангах үүднээс тэр хөшүүрэг болгож л өгөх гэж байгаа гэж ойлгож байгаа.

Тэгвэл энэ 3 дүүрэг чинь нийслэлийн төвийн 6 дүүргээсээ ялгаатай юм гэдгийг та бүхэн маань өмнөх ер нь хуулиуд дээр дандаа энэ онцлогийг харгалзахгүйгээр хаяж явж ирсэн учраас энэ удаа энэ тойрогт 2 төлөөлөлтэй болсны хувьд энэ 3 дүүргийн энэ 5 жилийн хугацаанд 6-хан сарын цалинтай тэнцэх хэмжээний энэ урамшууллыг нь олгох тал дээр нь та бүхэн дэмжиж өгөөч. Ямар та бүхний карманаас гаргах гэж байгаа биш. Энэ чинь тухайн орон нутагт ажиллаж байгаа төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллах. Пүрэвдорж гишүүн ээ би таныг 3 дүүрэгт очоод ажиллаад үз гэж гуйж байна. Жаргал, зовлонг нь та мэдэхгүй байна. Тийм. Баярлалаа.

Г.Занданшатар: 3 гишүүн дэмжиж үг хэллээ. 2 гишүүн эсрэг үг хэллээ. Одоо дэмжээгүй л үг хэлж болно. Цэвэгдоржийн Туваан гишүүн.

Ц.Туваан: Энэ уг нь Энхболд гишүүн сая хэлж байна. Ер нь цогцоор нь авч үзэх талын юм руу л бараг орчихлоо гээд. Миний хувьд бас тэр талд байгаа. Тэгэхдээ ер нь энэ нэг ч гэсэн хүн цалин цавуу нь нэмэгдэж энэ ядуурал руу унаж байгаа энэ уналтаасаа гараасай л гэдэг үндэслэлээр хэлж байгаа юм.

Алслагдсан 3 дүүрэг нэг нь Багануур дүүрэг 130 километр, Багахангай дүүрэг 85 километр, Налайх дүүрэг 45 километр оршдог. Тэгээд энэ дүүргүүд тэр Багануур дүүрэгт Төв аймгийн Баяндэлгэр, Мөнгөнморьт, Архуст, Баянжаргалан сумд, Налайх дүүрэг дээр Сэргэлэн,

Эрдэнэ сум, Багахангай дүүрэг дээр Баян, Сэргэлэн сумын иргэд нэлээн байдаг. Энд төвлөрсөн газар учраас энэ дээр эрүүл мэндийн, сургуулийн үйлчилгээнүүдээ авдаг. Дээрээс нь энд нэлээдгүй иргэд маань амьдардаг. Энэ асуудлыг мөн маш их, олон удаа тавьдаг. Тэд нар бид нарыг энэ яг нийслэлийн дүүрэг гэдгээр авч үздэг. Яг яс юман дээр бас Төв аймгийн л хүмүүс ихэнх нь амьдраад, 2 салж амьдраад байгаа юм гэсэн ийм асуудал явж байгаа юм. Тийм. Тэгэхээр энэ дээр тэр алслагдсан дүүргүүдийн энэ асуудал, хэрвээ хууль санаачлагчид нь энийгээ татаад авчихгүй бол энэ саналыг нь дэмжиж байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Ер нь тэгээд энэ цалин урамшууллын тогтолцоогоо нэгдсэн журмаар шийдэхгүй бол сар бүрийн цалингаар л энэ тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг хангах нь зүйтэй гэж Засгийн газар санал өгсөн юм байна лээ. Тэгээд одоо бас хууль санаачлагчид бас. Санал хураалт явуулъя. Анхааралтай байя. Пүрэвдорж гишүүнээ болно. Санал хураалт явуулъя. Мэтгэлцээний цаг дууссан. Одоо Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллын Төрийн байгуулалтын дэмжээгүй саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явна. Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжээгүйг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна.

Аймгийн төвөөс бусад сумын болон нийслэлийн Багахангай, Багануур дүүрэгт тасралтгүй ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид 5 жил тутамд 1 удаа 6 сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгох бөгөөд мөнгөн урамшуулал олгох журмыг Засгийн газар батална. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сайнбуянгийн Амарсайхан, Цагаанхүүгийн Идэрбат, Цэндийн Сандаг-Очир, Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн. Санал хураалт.

Энэ санал дэмжигдсэн байна. Горимын санал байхгүй. Байж байгаарай, гишүүд байж байгаарай. Дахиад санал хураалтай шүү. 8 гишүүн дэмжиж Төрийн байгуулалтын байнгын хорооны санал дэмжигдсэнгүй.

Сайнбуянгийн Амарсайхан, Цагаанхүүгийн Идэрбат, Цэндийн Идэрбат, Дуламдоржийн Тогтохсүрэн нарын гишүүдийн санал дэмжигдэж байна. Энэ хуулийн зөрчил эхний 2 санал 2-улаа дэмжигдэж байгаа учраас, зөрчил гарч байгаа учраас Байнгын хороон дээрээ 1 дэх санал дэмжигдчихээр нөгөө энэ 2 дахь саналыг чинь аймгийн төвөөс бусад гэдэг үг байхгүй болчхож байна шүү дээ. Тэгэхээр зөрчил гарч байгаа учраас Төрийн байгуулалтын байнгын хороон дээрээ гүйцээн боловсруулах чиглэл өгч байна.

Энийгээ бас хууль санаачлагч нар бас харгалзаж үзээд энэ яахыгаа нэг тийш шийдэхгүй бол. Энэ бас дэгт ийм байгаа юм шүү. Би Байнгын хороон дээр хэлсэн. Нямаагийн Энхболд гишүүнээ Байнгын хороон дээр хэлсэн. Дэгээрээ бол яг ийм хууль санаачлахад Засгийн газрын саналыг заавал сонсоно гэсэн нэг дэг байгаа юм. Төсвийн зарлагыг нэмэгдүүлэх бол гэж. Тэрийгээ хийсэн юм уу, үгүй юм уу гэдгийг яг? Гэхдээ хэлэлцэх эсэх дээрээ. Санал хураалт явуулж дууслаа. Одоо дараагийн асуудалд орно. Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлээ.

Үдээс өмнөх нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул үдээс өмнөх чуулганы нэгдсэн хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

Үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэл, Монгол Улсын Хөгжлийн банкны чанаргүй зээлийг барагдуулах, олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын

өмнө гэрээгээр хүлээсэн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангах, гадаад эх үүсвэрүүд хугацаанаас өмнө дуудагдах эрсдэл, урьдчилан сэргийлэх чиглэлээр Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар сонсоно.

11.43 цаг

*Баасан гараг 04 Аравнэгдүгээр сар 2022
Төрийн ордон “Их хуралдай” танхим
14 цаг 00 минут.*

ҮДЭЭС ХОЙШИХ НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Гурав.Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэл /Монгол Улсын Хөгжлийн банкны чанаргүй зээлийг барагдуулах, олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын өмнө гэрээгээр хүлээсэн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангах, гадаад эх үүсвэрүүд хугацаанаас өмнө дуудагдах эрсдэл, урьдчилан сэргийлэх чиглэлээр Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар/

Г.Занданшатар: Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы 11 дүгээр сарын 4-ний өдрийн үдээс хойших нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. Хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Монгол Улсын Хөгжлийн банкны чанаргүй зээлийг барагдуулах, олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын өмнө гэрээгээр хүлээсэн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангах, гадаад эх үүсвэрүүд, хугацаанаас өмнө дуудагдах эрсдэл, урьдчилан сэргийлэх чиглэлээр Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар Ерөнхий сайдын мэдээллийг сонсоно.

Мэдээллийг Сангийн сайд Болдын Жавхлан хийнэ. Сангийн сайд Болдын Жавхланг индэрт урьж байна. Түр байж байгаарай. Гол сонсох ёстой нөгөө

цөөнхийн бүлгийн гишүүд маань, Одонгийн Цогтгэрэл гишүүн. Гол асуулт асуух цөөнхийн бүлгийн гишүүн орж ирлээ. Салдангийн Одонтуяа гишүүн асуулт асууна. Сангийн сайд Болдын Жавхлан мэдээллээ хийе.

Б.Жавхлан: Монгол Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Засгийн газрын 2010 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн 195 дугаар тогтоолоор Монгол Улсын Хөгжлийн банкныг байгуулахаар шийдвэрлэж, Улсын Их Хурлаас 2011 оны 2 дугаар сарын 10-ны өдөр Монгол Улсын Хөгжлийн банкны тухай бие даасан хуулийг баталснаар 2011 оны 5 дугаар сарын 12-ны өдөр албан ёсоор нээлт хийж, үйл ажиллагаагаа эхлүүлсэн.

Хөгжлийн банк нь олон улсын зах зээлээс гадаад валютаар хөрөнгө татан төвлөрүүлж, түүнийг үндэсний стратегийн ач холбогдол бүхий эдийн засгийн өсөлтийг дэмжих, томоохон төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх замаар макро эдийн засгийг бодитоор дэмжих зорилготой төрийн өмчийн цорын ганц бодлогын банк юм. Хөгжлийн банкны өнгөрсөн 11 жилийн түүхийг 2011 оны Хөгжлийн банкны тухай хуулийн үйлчлэлийн үе, 2017 оны Хөгжлийн банкны тухай хуулийн шинэчилсэн найруулгын үйлчлэлийн үе гэсэн 2 үндсэн хэсэгт хуваана.

Учир нь энэ 2 хуулиар банкны засаглал, санхүүжилтийн шийдвэр гаргалт, хяналтын тогтолцоо 2 өөр байдлаар тодорхойлогдсон байдаг. Хөгжлийн банк нь үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш буюу 2011-22 оны хооронд нийт 3.5 тэрбум ам доллартой тэнцэх хэмжээний урт хугацаат эх үүсвэрийг олон улсын зах зээлээс татан төвлөрүүлснээс 1.5 тэрбум ам доллар нь Засгийн газрын буюу Чингис бондын эх үүсвэр, үлдсэн 2 тэрбум ам долларын эх үүсвэрийг Хөгжлийн банк өөрөө татан төвлөрүүлсэн байна.

Олон улсын зах зээлээс татан төвлөрүүлсэн уг 3.5 тэрбум ам долларын эх үүсвэрийн 3 тэрбум ам долларыг төсөл, хөтөлбөр санхүүжүүлэхэд зарцуулсан бол 0.5 тэрбум доллароор өрийн удирдлага буюу эх үүсвэрийн дахин санхүүжилт хийжээ. Хөгжлийн банк нь дээрх татан төвлөрүүлсэн гадаад эх үүсвэр болон өөрийн хөрөнгийг ашиглан нийт 3.5 тэрбум доллартой тэнцэх хэмжээний санхүүжилт олгосон бөгөөд үүнээс 1.4 тэрбум доллар буюу 40.8 хувийг төслийн орлогоос эргэн төлөгдөх нөхцөлтэй шууд санхүүжилтээр 0.5 тэрбум доллар буюу 15.1 хувийг дамжуулан санхүүжилтийн хэлбэрээр, үлдсэн 1.5 тэрбум ам доллар буюу 44 хувийг улсын төсвийн шинжтэй буюу өндөр хүүтэй валютын эх үүсвэрээс санхүүжүүлж болохгүй төслүүдэд олгосон үндсэн 3 хэлбэрээр төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлсэн байна.

Үүнээс 2011-16 онд буюу анхны хуулийн хэрэгжилтийн хугацаанд нийт 2.5 тэрбум доллар буюу 70 хувьтай тэнцэх хэмжээний зээл олгосон бол 17-22 онд 1 тэрбум доллар буюу 30 хувьтай тэнцэх хэмжээний санхүүжилтийг олгожээ.

2011-16 оны дуусталх хугацаанд Хөгжлийн банк нь Улсын Их Хурлаас Монгол Улсын хөгжлийн томоохон төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжилтээр хангах ба санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрүүдийн жагсаалтыг Улсын Их Хурал жил бүрийн хаврын чуулганаар батална гэж хуульчилсан байдаг. Төв банкны хяналт шалгалт, зохицуулалтын оролцоог хангах талаар тусгаагүй, санхүүгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд, сайн засаглалын зарчмуудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгож ажиллаагүй нь засаглал, үйл ажиллагааны эрсдэлийг бий болгож, банкны санхүүгийн чадавхыг сулруулж, Хөгжлийн банканд өнөөдрийн үүсээд байгаа хүндрэл, эрсдэлтэй нөхцөл байдлыг бий болгоод байна.

Хөгжлийн банкнаас санхүүжүүлэх төсөл хөтөлбөрийг баталсан Улсын Их Хурлын 15 дугаар тогтоолоор ердөө 1 удаа 2011 онд баталсан байдаг. Үүнээс хойш Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн гаргасан зөвлөмжийг үндэслэл болгон Бодлогын зөвлөл нэртэй бондын зарцуулалтын шийдвэр гаргадаг бүтцийг Засгийн газрын 2012 оны 12 дугаар сарын 15-ны 179 дүгээр тогтоолоор байгуулж, тэр зөвлөл нь бүх шийдвэрийг гаргадаг байжээ. Ингээд 2012-16 онуудад Засгийн газар дангаараа шийдвэр гарган өөрийн мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Хөгжлийн банкны санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийг ийнхүү шийдвэрлэжээ.

Тодруулбал, 2012-16 онуудад Засгийн газрын нийт 120 тогтоолоор тухайн үеийн ханшаар 8.1 их наяд төгрөгтэй тэнцэх хэмжээний санхүүжилтийг Хөгжлийн банкаар гаргуулахаар даалгаснаас 2.5 тэрбум доллар буюу тухайн үеийн ханшаар 5.4 их наяд төгрөгийн зээлийн санхүүжилтийг олгосон байна. Тус тогтоолууд нь бүтээн байгуулалт, аж үйлдвэрийг дэмжих хэмээн чихэнд сонсголтой, сүржин нэрийн дор ихэвчлэн техник эдийн засгийн үндэслэл, судалгаа нь бэлэн болоогүй төсөл нэртэй хувь компаниудын нэр цохон зөвхөн энэ компанид санхүүжилтийг олго хэмээн даалгасан тогтоолууд байна. Жишээ нь, шинэ бүтээн байгуулалтыг дэмжих нэртэй “Эрэл” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн байшин үйлдвэрлэх комбинат төслийг тусгайлан нэр зааж дурдаад олгох санхүүжилтийн дүнг нь тогтоолдоо бичиж үүрэг болгосон байдаг.

“Шинэ Яармаг” орон сууцын хороололд 50 сая ам долларын зээл олго гэж үүрэгдсэн тогтоол ч байна. Мөн төмрийн үйлдвэрийг дэмжих нэрийн дор “Мон-лаа” хязгаарлагдмал хариуцлагатай компани “Бэрэн” группт зээл олгохыг шууд Хөгжлийн банканд даалгасан байдаг.

Монгол Улсын Засгийн газрын шийдвэр нь тухайлан нэр бүхий компаниудад л зээл олго гэж Хөгжлийн банканд үүрэг өгөх байдлаар гарсан нь шударга, ардчилсан ёсны зарчимд нийцэхгүй, төр нь өөрөө хэн нэгэнд илт давуу байдал бий болгосон, бидний сургамж авч хэзээ ч дахин давтаж болохгүй алдаа юм.

Нэг үгээр хэлэх юм бол Хөгжлийн банкнаас олгож байсан санхүүжилтүүд нь Монгол Улсад хэрэгцээтэй эсэх, урт хугацаанд эдийн засгийн үр өгөөжтэй байх эсэхээс үл хамааран тухайн үеийн Улсын Их Хурлын гишүүд, сайд дарга нар, тэдгээрийн хамаарал бүхий этгээдүүдийн төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх явдал байсан гэж үзэж болохоор байна.

Мөн өнөөдөр балаг нь үүгээр дуусаагүй байна. Эдгээр нэр цохуулан засгийн газрын тогтоолоор санхүүжилт авсан төслүүдээс өнөөдрийг хүртэл үйл ажиллагаа нь эхлээгүй, улмаар зээл нь чанаргүй болж, Хөгжлийн банкны чанаргүй зээлийн багцын 74 хувийг эзэлж байна.

Валютаар авсан зээлийг буцаагаад валютаар төлнө. Гэтэл их чанаргүй зээлээс валют битгий хэл төгрөгөөр ч зээл төлөгдөхгүй, чанаргүйдэхэд хүрч байна.

Бид улсын валютын нөөцийг шавхан байж гадаад тал дахь үүргээ биелүүлэхээр Монгол Улсын Хөгжлийн банк, Засгийн газар бүхий л арга чаргаа ашиглан ажиллаж байна.

Мөн түүнчлэн төслийн нэгжийг санхүүжүүлэхийг үүрэг болгосон тогтоолууд байна. Хүү тооцогддог, валютаар буцаан төлөх үүрэгтэй зээлийн хөрөнгүүдийг ажилтнуудын цалин, машин тэрэг, хэрэгтэй, хэрэггүй зөвлөх үйлчилгээ гэх мэт зүйлд зарцуулаад үр дүнд нь бэлэн болж хөдөлсөн төсөл ч үгүй, эргэн төлөлт ч үгүй, хариуцах эзэн ч

үгүй Хөгжлийн банканд чанаргүй зээл болсоор байна.

Жишээ нь, Эгийн голын усан цахилгаан станц байгуулах төслийн нэгжийн зардал, Сайншандын аж үйлдвэрийн парк байгуулах төслийн нэгжийн зардлыг Хөгжлийн банкаар санхүүжүүлсэн. Мөнгө нь олгогдсон ч төсөл нь хэрэгжээгүй, нүдэнд харагдаж, гарт баригдах үр дүн байхгүй, зөвхөн өр л үлдсэн. Эдгээр дурдсан асуудлууд зөвхөн төслийн орлогоос эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр шууд хэлбэрээр олгосон зээлүүд боловч одоог хүртэл ямар эх үүсвэрээр төлөгдөх нь огт тодорхойгүй, чанаргүй зээлүүд болжээ.

Харин улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр буюу улсын төсөв өөрөө хийх ёстой байсан төслүүдэд нийт 1.5 ам доллар тухайн үеийн ханшаар 2.5 их наяд төгрөгийн зээлийг засгийн тогтоолоор Хөгжлийн банк санхүүжүүлсэн байдаг. Эдгээр төслүүдийг авто зам, төмөр зам, инженерийн дэд бүтэц, гудамж төслийн нэрийн дор олгосон санхүүжилтүүд дийлэнх хэсгийг нь эзэлдэг.

Гэвч тус ажлуудын тендерийн сонгон шалгаруулалт болон олгосон санхүүжилтийн зарцуулалтын хяналтыг хариуцсан яамнууд нь өөрсдөө хэрэгжүүлдэг байсан. Хөгжлийн банк өг гэснийг нь л өгдөг үүрэгтэй байж. Зарим ажлуудын нийт өртөг батлагдсаны анхны төсөвт өртгөөсөө огцом нэмэгдэж, нэмэгдсэн дүнгээр нэхэмжлэл бичин Хөгжлийн банканд ирүүлдэг байжээ. Ямар үндэслэлээр яагаад санхүүжилтийн дүнгээ өсгөж байгааг тухайн үеийн яамнууд дотроо шийддэг байсан ба зарцуулалтад хийх хяналт шалгалт маш сул байжээ.

Энд маш ноцтой нэг зүйл байна. Тендерийн тухай хуульд Хөгжлийн банктай холбогдсон үйл ажиллагаанд Тендерийн тухай хууль үйлчлэхгүй гэсэн заалт оруулж байгаад энэ бүх

зарцуулалтууд ямар ч тендергүйгээр яамнууд нь шийдээд, санхүүжилтийг нь Хөгжлийн банк хийж байжээ.

2016 оны эцэст Хөгжлийн банкнаас олгосон нийт зээлийн үлдэгдэл 6 их наяд төгрөгт хүрч өссөн ба үүний 50-иас дээш хувийг буюу тухайн үеийн ханшаар 3.1 их наяд төгрөгийн багц улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр олгогдсон байсан нь тус банкныг байгуулсан үндсэн зорилгоос нь хазайлгаж, төсвийн шинжтэй үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллага болгон хувирагжээ.

Улмаар Улсын Их Хурлын 2016 оны 81 дүгээр тогтоол, Засгийн газрын 2016 оны 219 дүгээр тогтоол, Засгийн газрын 2017 оны 53 дугаар тогтоолыг тус тус хэрэгжүүлэх ажлын хүрээнд тухай бүр Засгийн газрын тогтоолын хүрээнд зээлийн эргэн төлөлтийг улсын төсвөөс эргэн төлөх гэрээний үүрэг хүлээсэн 348 төсөл, арга хэмжээний 3.1 их наяд төгрөгтэй тэнцэх хэмжээний зээлийн багцыг улсын төсөвт шилжүүлэх арга хэмжээг авчээ.

Үүний дараа 2017 оны 4 дүгээр сараас Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Хөгжлийн банкны засаглалыг сайжруулах, хараат бус, бие даасан байдлыг нэмэгдүүлэх, үндсэн үйл ажиллагааны чиглэлийг өргөжүүлэх зорилгоор Улсын Их Хурлаас Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2017 оны 2 дугаар сард баталсан бөгөөд энэхүү хуулийн шинэчилсэн найруулгаар банкны зээл олгох үйл ажиллагаанд Улсын Их Хурал, Засгийн газраас шууд оролцдогийг зогсоосон. Тодруулбал, Хөгжлийн банк мэргэжлийн байгууллагын хувьд Улсын Их Хурал, Засгийн газраас хамааралгүйгээр бие даан шийдвэр гаргаж, гаргасан шийдвэрийнхээ хариуцлагыг тус банкны эрх бүхий албан тушаалтан хүлээдэг механизмыг

бүрдүүлэх зорилгоор Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, дунд хугацааны хөгжлийн бодлогод нийцсэн, хуульд заасан шаардлагыг хангасан төсөл, хөтөлбөрийг Хөгжлийн банк санхүүжүүлэх бие даасан шийдвэрийг гаргадаг байдлаар хуульчилсан.

Хяналтын тогтолцоог сайжруулах хүрээнд Монголбанкнаас санхүүгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг тогтоож, актив ангилах, эрдэлийн сан байгуулах тухай журмыг Сангийн сайд болон Монголбанкны Ерөнхийлөгчийн хамтарсан тушаалаар баталж, Монголбанк тус банкны үйл ажиллагаанд хяналт тавьж эхэлсэн. Энэ цагаас хойш өнөөдрийг хүртэл дахиж улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийг Хөгжлийн банк санхүүжүүлээгүй ба Монголбанкнаас жил бүр хяналт шалгалт хийж, Засгийн газраас 2 жилд 1 удаа хяналт шалгалт хийж байжээ.

Олон улсын санхүүгийн зах зээлээс төр, ард иргэдийнхээ нэрийн өмнөөс их хэмжээний мөнгөн хөрөнгийг татан төвлөрүүлж авсан зээлээ гадаад валютаар ашигласан цаг, хором мөч бүрдээ хүү тооцуулан тогтоосон хугацаанд буцаан төлөх гэрээний хатуу үүрэг хүлээдэг мэргэжлийн байгууллагын хувьд санхүүгийн сахилга бат, хариуцлага онцгой өндөр түвшинд байх учиртай.

Гэвч Монголбанкны 2021 онд Хөгжлийн банканд хийсэн шалгалтаар Хөгжлийн банкны идэвхтэй байгаа нийт зээл буюу 3.2 их наяд төгрөгийн зээлд эзэлж буй чанаргүй зээл нь 1.8 их наяд төгрөгт хүрч, чанаргүй зээлийн хэмжээнд нийт зээлийн багцын 55.3 хувийг эзэлж байгааг дүгнэсэн актыг 21 оны 12 дугаар сарын 21-нд албажуулсан байдаг. Нийт чанаргүй болсон 1.8 их наяд төгрөгийн чанаргүй зээлийн 73 хувь буюу 1.4 их наяд төгрөгийн чанаргүй зээлийг 12-16 онд Засгийн газрын тогтоолтойгоор олгосон зээлүүд эзэлж байна.

Ингэснээр хамгийн багадаа 10 хувь болон түүнээс дээш хувь байх ёстой санхүүгийн сахилга бат, санхүүгийн байгууллагын амин чухал үзүүлэлт болох өөрийн хөрөнгийн хүрэлцээ 0 утга руу ойртож 1.3 хувьд хүрсэн нь дампуурлын ирмэгт хүрснийг илтгэнэ.

Хөгжлийн банк 2023 оны 10 болон 12 дугаар саруудад олон улсын хөрөнгийн зах зээл дээр 2018 онд дахин санхүүжилт хийх зорилгоор арилжаалсан 500 сая ам долларын евро бонд, Япон улсын зах зээл дээр 2013 онд хаалтай арилжаалсан 30 тэрбум иений “Самурай” бондын эх үүсвэр буюу өнөөдрийн ханшаар ирэх онд нийт 2.6 их наяд төгрөгийн эргэн төлөлт гүйцэтгэх хуваарьтай байна.

Хөгжлийн банк нь олон улсын банк, санхүүгийн байгууллагуудтай байгуулсан зээлийн гэрээ хүчин төгөлдөр байх хугацаанд чанаргүй зээлийн харьцаа үзүүлэлтийг 10 хувиас бага, өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцаа үзүүлэлтийг 10 хувиас их хэмжээнд тус тус ханган ажиллах үүргийг хүлээдэг.

Гэтэл чанаргүй зээлийн харьцаа 55.3 хувь, өөрийн хөрөнгийн хүрэлцээ 1.3 хувьд хүрчихсэн байна гэдэг нь банк үндсэндээ эмнэлгийн сэхээний орон дээр байгаатай ижил юм. Хэрэв яаралтай арга хэмжээ авахгүй бол Хөгжлийн банкны олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын өмнө гэрээгээр хүлээсэн үүргийн зөрчил үүсэж, эх үүсвэрүүд хуваарьт төлөлтийн хугацаанаас өмнө буцаан дуудагдах эрсдэл үүснэ.

Ингэснээр Хөгжлийн банкны Засгийн газрын баталгаатай эх үүсвэрт үүргийн зөрчил илэрч, хугацаанаас өмнө буцаан дуудагдах нь Засгийн газрын бусад гадаад эх үүсвэрүүд ч мөн хугацаанаас нь өмнө нь төлөгдөхөөр буцаан дуудагдаж, Засгийн гадаад өрд шууд дарамт учруулах бодит эрсдэлтэй юм.

Иймээс зөв гарц, гаргалгааг цаг алдалгүй гаргаж шийдвэрлэх ажил руу ханцуй шамлан орох хэрэгцээ үүссэн. Засгийн газрын зүгээс Хөгжлийн банкны 10 гаруй жил хуримтлагдсан хур их өртэй тэнцэж байна.

Шинэ сэргэлтийн бодлогыг тодорхойлогдсон хөгжлийн томоохон төслүүдийг санхүүжүүлэх чухал үүрэг гүйцэтгэх Хөгжлийн банк сүүлийн 1 жил цэвэр өр барагдуулах алба болон хувираад байна. Шалгаад, шүүгээд, алдаа оноог нь ялгаад эхлэхээр үүрээ эвдүүлсэн шоргоолж шиг бужигналдаж, хувь, хувьсгалын олон дарамт шахалт тулгарч байна. Тэглээ гээд ухарч хулчийхгүй Хөгжлийн банкны асуудлыг заавал эцэслэн шийдвэрлэж, буруу, зөвийг шүүн тогтоох ёстой. Гадаад талдаа энэ бүгд бид бүгдийн л өр. Тиймээс ч бид үүргээ биелүүлнэ.

Харин дотоод талдаа энэ их өрийг төлүүлэхийн эсрэг хамтдаа тэмцэх болно. Хөгжлийн банк яагаад ийм хүнд байдалд хүрэв? Энд яг юу болж өнгөрөв? Үүнээс нэг зүйл маш тодорхой харагдана. Хүрэх цэгээ тодорхойлолгүйгээр, тооцоо судалгаагүйгээр юунд зарцуулахаа тодорхой болголгүйгээр их хэмжээний өр, төлбөр аваад эдийн засгийн үр өгөөжгүй, дутуу дулимаг боловсруулсан төсөл нэртэй цаасыг гарын салаагаар урсах элс мэт санхүүжүүлсний үр дүнд өнөөдрийн Хөгжлийн банкны нөхцөл байдал үүссэн юм. Үүний горьг бид улсаараа үүрч байна. Хаанаас яаж олсон хөрөнгийг ийнхүү зарцуулсныг мөн дурдах хэрэгтэй.

Нэгд, Хөгжлийн банк 2012 онд Засгийн газрын баталгаатайгаар нээлттэй хэлбэрээр олон улсын зах зээлд 5 жилийн хугацаатай 580 сая ам долларын дунд хугацааны евро бондыг гаргасан. Энэ хөрөнгийг төсөл, хөтөлбөр санхүүжүүлэхэд зарцуулсан байдаг.

Хоёрт, Засгийн газрын 2012 онд гаргасан 1.5 тэрбум долларын “Чингис” бондын эх үүсвэрийг санхүүгийн

зуучлалын гэрээ байгуулж, тус гэрээний хүрээнд 269.9 сая ам доллар болон 2 их наяд төгрөгийг 2013-14 онуудад үе шаттайгаар тухайн үеийн Эдийн засгийн хөгжлийн яам болон Сангийн яамнаас шилжүүлж авч зарцуулсан.

Ингэхдээ уг хөрөнгийг мөн л Засгийн газрын үүрэг болгосноор тогтоолын дагуу төсөл, хөтөлбөр санхүүжүүлэхэд зарцуулжээ.

Гурав.2013 онд Японы зах зээлд 10 жилийн хугацаатай Засгийн газрын баталгаатай 34 иений “Самурай” бонд гаргасан. Үүнийг мөн л төсөл, хөтөлбөрт санхүүжүүлсэн.

Дөрөв.2015 онд хаалттай хэлбэрээр 6 жилийн хугацаатайгаар дотоодын арилжааны банкнуудад 233.4 тэрбум төгрөгийг “АСЕМ” бонд гаргасан ба Ази, Европын дээд түвшний 11 дүгээр уулзалтын хүрээнд “АСЕМ Вилла” цогцолбор хотхон төслийг санхүүжүүлэх болон уулзалтад оролцох төлөөлөгчдийг байрлуулах зочид буудлуудад олгох хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг бүрдүүлэхэд зарцуулжээ.

Тав.Үүнээс гадна 2014-20 оны хооронд нийт 683.8 сая ам доллартой тэнцэх хэмжээний эх үүсвэрийг олон улсын банк, санхүүгийн байгууллагуудаас 2 талт болон олон талт гэрээний хүрээнд татан төвлөрүүлж зарцуулсан.

Үүний дараа 2018 онд олон улсын хөрөнгийн зах зээлд 5 жилийн хугацаатай Засгийн газрын баталгаагүй 500 сая ам долларын евро бонд гаргасан ба тус бондоор Олон улсын валютын сангийн хөтөлбөрийн хүрээнд цэвэр өрийн удирдлага хэрэгжүүлж дахин санхүүжилт хийсэн байдаг.

Үүний үр дүнд нэгт, Засгийн газрын баталгаатай өр төлбөрийг бууруулсан.

Хоёрт, өр төлбөрийн жигнэсэн дундаж хугацааг 3.8 жилээр сунгасан.

Гуравт, хүүгийн зардлыг бууруулж, хөвөгч хүүг тогтмол болгож чадсан. 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн байдлаар Хөгжлийн банкны олон улсын зах зээлд арилжаалсан үнэт цаасны үлдэгдэл нийт 2.6 их наяд төгрөг байна. Үүнд 2018 онд гаргасан “Евро” бондын 500 сая ам доллар, 2013 онд гаргасан 30 тэрбум иений “Самурай” бондууд байна.

Нэг ёсондоо 2012-16 онд аль хэдийн зарцуулагдаад дуусчихсан зээлийн хөрөнгийг эргэн төлөхөөр ажиллаж байна. 2017 оноос хойш олон улсын зах зээлд гаргасан Засгийн газрын болон Хөгжлийн банкны бондууд чухамдаа анх 2012 онд Засгийн газрын гаргасан 1.5 тэрбум долларын “Чингис” бонд, Хөгжлийн банкны 580 сая ам долларын “Евро” бондын өрнүүдийг төлөхөд л зарцуулаа.

Өрийг өрөөр, урд хормойгоороо хойд хормойгоо нөхсөөр өдийг хүрлээ. Одоо бид анхны их өрийн хөрөнгийг яаж зарцуулав? Бодлогоо төлөвлөлтгүй, хэрхэн үр ашиггүй зарцуулж, үрэн таран хийснээр 10 гаруй жилийн өрийн дахин санхүүжилтийн их урсгалыг бий болгов гэдгийг шүүн хэлэлцэх цаг нь болжээ.

Ном журмын дагуу бол гадаадаас 10 их наядыг зээлж авч ирсэн бол түүгээрээ санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрөөс бий болсон үр дүн нь 20, 30 их наядын өгөөжийг улсын эдийн засагт оруулж, суурь дэд бүтэц, хүнд үйлдвэрүүдийн суурь дээр солонгорон солонгорсон эдийн засаг бий болгон хөгжиж, хувийн хэвшлийнхэн чадавхиж байж сая зорилгодоо хүрч, энэ бондуудын эх үүсвэр бүрдсэн байх учиртай.

Гэтэл бодит нөхцөл байдал дээр татан төвлөрүүлсэн эх үүсвэрийн зарцуулалт үр дүнгүй, өгөөжгүй, бүр цаашлаад чанаргүй болж, энэ нь эргээд эдийн засгийн хүндрэлтэй нөхцөлд

хүргэж байгаа нь бодлого, шийдвэр гаргалт, менежментийн том алдаа байгааг илэрхий харуулж байна.

Засгийн газрын зүгээс Хөгжлийн банкны асуудлыг анхаарлын төвөөс гаргалгүй, тус банкны үйл ажиллагаатай Засгийн хуралдаанаар тогтмол мэдээлэл авч, үүрэг чиглэл өгч ажиллаж байна. Энэ оны 1 сараас эхлэн чанаргүй зээлийг эргэн төлүүлэх үйл ажиллагааг бид эрс эрчимжүүлж, асуудлыг олон нийтэд нээлттэй, ил тод болгосон. Холбогдох байгууллагууд энэхүү асуудалд анхаарлаа хандуулж, хуулийн хүрээнд түргэн шуурхай асуудлыг шийдвэрлэх чиглэлээр уриалж, дэмжлэг хүсэж ажилласны үр дүнд хуулиар зөвшөөрөгдсөн ажиллагааг шуурхай хийж гүйцэтгэж байна.

Үүний үр дүнд зээлийн ард байсан хээл хахууль, авлига, албан тушаалын хэргүүд ч илэрч, хэргүүд эрчимтэй шийдэгдэж байна. Чанаргүй зээлийг төлүүлэх ажиллагааны хүрээнд Иргэний хэргийн шүүхэд 2019-22 он хооронд 689.8 тэрбум төгрөгийн 18 зээл, 2022 оны 1 дүгээр сараас хойш 691.6 тэрбум төгрөгийн 15 зээлдэгчийн нэхэмжлэлийг шүүхэд шинээр гаргасан.

2022 онд 367.5 тэрбум төгрөгийн 7 зээлийн шийдвэр эцэслэгдэн гарч, өнөөдрийн байдлаар 915.1 тэрбум төгрөгийн 16 зээлдэгчтэй холбоотой хэрэг иргэний журмаар шүүхийн шатанд шийдвэрлэгдэж байна.

Мөн шүүхийн шийдвэр гаргасан 15 зээлээс шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагаа хийгдэж буй 10 зээлд шүүхийн бус журмаар төлбөр төвлөрүүлэхээр ажиллаж буй 8 зээл, нийт 41 зээлийг эргэн төлүүлэхээр ажиллаж байна.

Эрүүгийн журмаар 32 компанийг шалгуулахаар Авлигатай тэмцэх газарт гомдол гаргаж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үргэлжилж байна. Авлигатай тэмцэх газраас эхний байдлаар 19 зээлийн

хувийн хэрэгт холбогдох, хянан шалгах ажиллагааг багцалж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусах шатандаа орсон гэж мэдээлэл өгч байна.

Хөгжлийн банкнаас төрийн өмчит хуулийн этгээдүүдэд олгосон зээлийн эргэн төлөлтийг шийдвэрлэх зорилгоор Засгийн газрын 2022 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн Хөгжлийн банкнаас олгосон зээлийн өр төлбөрийг барагдуулах зарим арга хэмжээний тухай 220 дугаар тогтоол батлагдаж, төрийн өмчит 9 хуулийн этгээдэд холбогдох 565.5 тэрбум төгрөгийн активын эргэн төлөлтийг шийдвэрлэх арга замуудыг тодорхойлж, тогтоолыг хэрэгжүүлж ажиллахыг холбогдох этгээдүүдэд даалгасан.

Тогтоолын хэрэгжилтийн хүрээнд “МИАТ” хувьцаат компанийн 14.9 тэрбум төгрөгийг төлснөөр зээл бүрэн төлөгдөж хаагдлаа. Мөн “Эрдэнэс Монгол” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 22 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр 117 төгрөгийг, НОСК, ТОСК-ийн зээлийн төлбөрөөс 10.1 тэрбум төгрөг төлөгдөөд байна. Мөн QSC компаниас 210 тэрбум төгрөгийг бэлнээр төлсөн.

Дээрх арга хэмжээнүүдийн үр дүнд Хөгжлийн банканд 2022 оны 1 дүгээр сарын 20-ны өдрөөс 10 дугаар сарын 25-ны өдрийг хүртэлх хугацаанд нийт 777 тэрбум төгрөгийн зээлийн эргэн төлөлтийг хийлээ. Үүнээс 689.1 тэрбум төгрөг бэлэн мөнгөөр төлөгдөж, 87.9 тэрбум төгрөг нь өмчлөх бусад хувь, хөрөнгөөр эргэн төлөгдлөө.

365 тэрбум төгрөг бүхий нийт 14 зээл бүрэн төлөгдөж хаагдлаа. Хөгжлийн банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээ 1.3 хувиас 16 хувьд хүрч зохистой харьцааныхаа хэмжээнд хүрлээ.

Хөгжлийн банкны 22 оны зээлийн эргэн төлөлтийг Төрийн сангийн тусгай дансанд төвлөрүүлсэн ба тус хөрөнгөөр хойтон төлөгдөх “Самурай” бондын эргэн

төлөх мөнгөн хөрөнгийг бүрдүүлж чадлаа.

Олон улсын эдийн засгийн нөхцөл байдал хүнд, эгзэгтэй КОВИД-ын дараах эдийн засаг сэхээ авч амжаагүй байтал улс орнуудын сөргөлдөөн бий болж, дэлхийн эдийн засгийн тэр аяараа хүндрэлтэй байгаа ч бодитоор тулан ирсэн Хөгжлийн банкны эрсдэлийг бид сөрөн зогсож, галыг цурамд оруулаад байгаа ч Хөгжлийн банк яагаад ийм байдалд хүрэх гэдгийг заавал шүүн тунгааж, тос, усыг ялган, алдаа, оноог дэнсэлсээр цаашдын ирээдүй рүү бид алхах учиртай.

Бондын эргэн төлөлтийн талаар авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан. Энэ хүрээнд 500 сая ам долларын “Евро” бондоос Хөгжлийн банканд оны эцэс хүртэл төлөгдөх зээлийн эргэн төлөлтөөр хэсэгчлэн худалдан авах ажиллагааг хийхээр ажиллаж байна. Бондуудыг хугацаанаас нь өмнө эргэн төлөх саналыг хөрөнгө оруулагчдад тавьснаар биднийг хүлээсэн үүргээ биелүүлэх хариуцлагаа бүрэн ухамсарлаж байгаа, мөн бондын төлбөрөө төлөх чадвартай, найдвартай түнш гэдгийг бид илэрхийлсээр байна.

Хөгжлийн банкны активын чанар, зээлжих зэрэглэл тогтоох аргачлалуудад өөрчлөлт орсонтой холбоотойгоор 22 оны 1, 2 дугаар улирлуудад Эс энд Пи /, Мүүдис /Mood's/, Фитч /Fitch/ агентлагуудаас ээлжит бус үнэлгээ хийсэн ба удаа дараагийн хэлэлцүүлгийн үр дүнд тус агентлагуудын зүгээс банкны зээлжих зэрэглэлийн үнэлгээ болон төлөвийг хэвээр үлдээхээр шийдвэрлэсэн ба Хөгжлийн банкны зээлжих зэрэглэл, улсын зээлжих зэрэглэлтэйгээ адил түвшинд хадгалагдаж байна.

Хөгжлийн банкны Оросын Холбооны Улсын Внешэконом банктай байгуулсан гэрээний үүрэг 2019 оноос эхлэн зөрчигдсөн ба гэрээний үүргээс чөлөөлөгдөх хэлэлцээрийг тус банктай хийж, гэрээний зөрчил үүссэнээр бусад эх

үүсвэрүүд хугацаанаас өмнө буцаан дуудагдах эрсдэлийг хаасан.

Олон улсын хөрөнгө оруулагчид, түншүүд, олон улсын зэрэглэл тогтоогч үнэлгээний агентлагууд, Монгол Улсын Хөгжлийн банкны асуудалд Монголын төр ямар шийдэл гаргахыг анхааралтай ажиглан сууж байна.

Хөгжлийн банкны хувьцаа эзэмшигчдийн хувьд Монгол Улсын Засгийн газар, Хөгжлийн банкныг бүрэн дэмжиж ажиллаж байгаагаа илэрхийлж байна.

Бид оны эцэст нийт эргэн төлөлтийг 1 их наяд төгрөгт хүргэе зорин ажиллаж байна. Ингэснээр оны эхэнд 1.3 хувь байсан банкны өөрийн хөрөнгийн үзүүлэлт 20 хувьд хүрэх боломж бүрдэнэ. Ингэснээр Хөгжлийн банкныг санхүүгийн үзүүлэлтүүдийн хувьд дампуурах эрсдэлээс бүрэн гарч, хэвийн үйл ажиллагаатай болж, банк бие даан ирэх оны өрийн удирдлага хэрэгжүүлэх чадамжтай болж, цаашид Хөгжлийн банкны Монгол Улсын хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх, цаашилбал Шинэ сэргэлтийн бодлогыг стратегийн ач холбогдол бүхий томоохон төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжилтээр хангах үндсэн чиг үүргээ гүйцэтгэх боломжийг бүрдүүлнэ гэж бид зорин ажиллаж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Баярлалаа. Одоо ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Дашзэвэгийн Амарбаясгалан, Эдийн засаг хөгжлийн сайд Чимэдийн Хүрэлбаатар, Зам тээврийн хөгжлийн сайд Сандагийн Бямбацогт, Монголбанкны Ерөнхийлөгч Бядрангийн Лхагвасүрэн, Монголбанкны Хяналт шалгалтын газрын захирал Цэдэвсүрэнгийн Нарандалай, Монгол Улсын Ерөнхий прокурорын орлогч Максимын Чинбат, Нийслэлийн прокурорын газрын Ерөнхий прокурорын

орлогч Агванбалдангийн Энхжаргал, Барилга хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга Сандагийн Магнайсүрэн, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Батсүхийн Сүх-Очир, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга Оюунхүүгийн Амарсанаа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Ерөнхий шийдвэр гүйцэтгэгч Чойжамцын Оюунцэцэг, Монгол Улсын Хөгжлийн банкны гүйцэтгэх захирал Нямандэлэгийн Мандуул, Монгол Улсын Хөгжлийн банкны Тэргүүн дэд захирлын үүрэг гүйцэтгэгч Жалсрайн Батаа, Монгол Улсын Хөгжлийн банкны Эрсдэлийн удирдлагын газрын захирал Зулпайн Батырбек, Монгол Улсын Хөгжлийн банкны Экспорт, импортын санхүүжилтийн газрын захирал Баттулгын Амгалан, Монгол Улсын Хөгжлийн банкны Төсвийн санхүүжилтийн газрын захирал Бат-Өлзийтийн Сайнзаяа, Монгол Улсын Хөгжлийн банкны Удирдлагын газрын захирал Лхагвасүрэнгийн Тэмүүжин, Монгол Улсын Хөгжлийн банкны Бизнес төлөвлөлт, хяналтын албаны захирал Солирын Мөрөн, Монгол Улсын Хөгжлийн банкны хуулийн зөвлөх Жаргалцэнгэлийн Эрхэмбаатар. Ажлын хэсэг танилцууллаа.

Мэдээлэлтэй холбогдуулж цөөнхийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл үг хэлнэ.

О.Цогтгэрэл: Улсын Их Хурлын дарга эрхэм гишүүд ээ,

Өнөөдөр Монгол Улсын Хөгжлийн банкны асуудлаар Ерөнхий сайдын мэдээлэл хийхээр материал тараагдсан. Сая Сангийн сайд Жавхлан танилцууллаа. Бид бүгд цөөнхийн, энэ бол Ерөнхий сайдын мэдээлэл гэдэг цөөнх ард түмнийг төлөөлж асуудаг ийм маш чухал Улсын Их Хурлын функц.

Гэтэл одоо сая тараагдсан материалаас шал зөрүү, саран дээр байж байгаад ирсэн хүмүүс шиг шал өөр материал уншчих юм. Бид нар уг нь бол Ерөнхий сайдын мэдээлэл 7 хоногийн өмнө ирэх ёстой. Энэ бол 3 хоногийн өмнө ирсэн. Одоо сая энэ тараагдсан материалын хүрээнд би энэ дүгнэлт унших гэж байгаа. Гишүүд асуулт бэлдэж байгаа. Гэтэл тараагдсан материалаас шал өөр мэдээлэл өгчихлөө. Одоо бид нар яах ёстой вэ? Ийм болохоор Улсын Их Хурлын даргаа энэ нь дараа дараа болоод энэнд ямар үүрэг хариуцлага байх ёстой вэ? Нэгдүгээрт нь.

Хоёрдугаарт нь одоо энэ лав л энэ цөөнхийн бүлгийн гишүүдэд энэ мэдээллийг тарааж өг. Энэ мэдээлэлтэй танилцаж байж тодорхой хэмжээний асуулт, дүгнэлт хийхгүй бол тараагдсан материал нэг өөр, ярьсан асуудал шал өөр асуудал яригдчихлаа.

Тийм болохоор би энэ дүгнэлтийг материалтай танилцаж байж энэ дүгнэлтийг уншъя. Тэгэхдээ энэ удаагийн Ерөнхий сайдын мэдээлэл хойшлохгүй байх ёстой гэдгийг хэлбэ.

Г.Занданшатар: Материал өөр болсон юм уу? Мэдээлэл гэхдээ өөр байж болно л доо. Тэр Амарбаясгалан дарга хариулах юм уу? Жавхлан сайд хариулах юм уу? Мэдээлэлтэй холбогдуулж Сангийн сайд болон ажлын хэсгийн гишүүдээс асуулт асууж, үг хэлэх цөөнхийн гишүүдийг. Хойшлуулахгүй, үргэлжлүүлж хэлэлцье гэсэн. Өөр яах юм бэ энэ чинь? Үгүй, материал тараагдчихсан биз дээ? Шал өөр юм уншиж болно шүү дээ. Заавал тараагдсан материалаа уншина гэсэн үг байхгүй. Үг үсэгчлэн. Дэлгэрүүлээд ярьж болно. Тэр бол хуулиар хориглосон зүйл байхгүй. Материалаа ингээд өгчихсөн. Заавал энэ материалаа яг уншина гэсэн үг байхгүй шүү дээ. Тийм. Энэ чинь нэмэлт материал өгч байна. Энэ өгсөн материалтай нь холбогдуулаад асуулт асууж болно. Та бүхэнд, Тийм. Энийгээ нэгэнт тараагдсан

гэж үзээд, уншчихсан гэж үзээд цөөнхийн бүлгийн гишүүд дараа нь цөөнхийг төлөөлж 1 гишүүн мэтгэлцээн явуулах учраас энэ чинь дэлгэрүүлж материалаа өгч болно, ярилцаж болно. Энэ бол хуулиар хориглосон зүйл байхгүй гэж үзэж байна. Тамга. Тийм, тэгэхгүй л дээ. Энэ тараагдсан материалаас асуух асуулт чинь нээлттэй байна шүү дээ. Энийг чинь худлаа юм өгчихсөн гэсэн үг биш. Энэнтэй холбогдуулаад асуулт асууж болно. Асуулт асуух гишүүд байхгүй байгаа гэсэн үг үү тэгээд? Горимын санал байхгүй л дээ. Мэдээлэлтэй холбогдуулж Сангийн сайд болон ажлын хэсгээс асуулт асууж, үг хэлэх цөөнхийн гишүүд байна уу? Цогтгэрэл гишүүнээр тасаллаа. Бөхчулууны Пүрэвдорж гишүүнээр тасаллаа. Норовын Алтанхуяг гишүүн асуулт асууя.

Н.Алтанхуяг: Асуулт асуух биш л дээ. Эхлээд жаахан шударга баймаар байна. Одоо энэ Улсын Их Хурлын гишүүдэд 11 сарын 1-ний өдөр Их Хурлын гишүүд ч биш, цөөнхөд л тараасан байна. Гишүүдэд Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээллийг хүргүүлсэн. Энэ ингэж байгаа юм. 9 хуудастай гээд. Тэгээд сая энэ дотроос шал өөр юм уншиж байгаа юм. Тэгэхээр энэ Жавхлан гэдэг хүн өөрөө гэмт хэрэгтэн хүн мөн юм байна гэж би итгэлээ. Яагаад гэхлээр Даваасүрэн гишүүн энэ хүнийг энэ Хөгжлийн банкнийг хэрхэн дампууруулсан тухай бол хэд хэдэн удаа ярьсан. Тэр хүнийг алчих вий дээ.

Тэгэхээр энэ хүн өнөөдөр юу хийж байна вэ гэхээр энэ Ерөнхий сайдын нэрийг барьж тараасан мэдээллээсээ шал өөр буюу, шал өөр буюу гүтгэлгийн шинжтэй материалыг Улсын Их Хурлын индэр дээрээс уншиж байна. Энэ одоо ард түмэн энэ дээр үнэхээр анхаарал хандуулах хэрэгтэй. 9 хуудас материал тараачхаад сая тэнд түмэн юм уншсан. Тэр нь дандаа худлаа юмнууд байгаа шүү.

Тэгэхээр одоо бид нар яаж, юу асууж, юу мэтгэлцэх юм? 17 оны хуулийг

өөрчилж байгаад Жавхлан энэ Хөгжлийн банкин дээр хүмүүсээ тавьж байгаад өчнөөн төчнөөн мөнгө идчихсэн гэж хэд хэдэн удаа Даваасүрэн гишүүн ярьсан. Энийг яагаад хуулийн байгууллага шалгахгүй, энэ хүн яагаад тэр Улсын Их Хурлын индэр дээрээс ийм гүтгэлгийн шинж чанартай материал уншиж байна. Одоо бид нар Их Хурлын дарга энийгээ янзалж болохгүй юм уу? Одоо тэр түрүүн уншсан материалыг манай гишүүдэд өгмөөр байна шүү дээ. Энэ ард иргэд чинь сая Жавхлангийн уншсан юмыг чинь үнэн гэж ойлгож байгаа шүү дээ. Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэл гэж үзэж байгаа шүү дээ.

Гэтэл ийм гүтгэлгийн шинжтэй юм хийж байна шүү дээ. Тэгэхээр тэр Жавхлангийн уншсан юмыг манай бүлгийн гишүүдэд, ер нь бүгд Их Хурлын бүх гишүүдэд өгөх хэрэгтэй. Энэ Монгол Улсын Их Хурал дээр яригдаж байгаа, хэлэлцэгдэж байгаа юмнууд үнэн, зөв баримттай юм л яригдах учиртай. Тэгэхээр би энийгээ саяын Цогтгэрэл даргын хэлж байгаа шиг бид нарт тараагаач. Нэг ийм юм тараачхаад тэгчхээд энэнээсээ шал өөр утгатай юм ерөөсөө Их Хуралд танилцуулж болохгүй. Болдоггүй. Би одоо энд 4 ч удаа сууж байгаа. Хэзээ ч ийм юм байдаггүй. Дэлгэрүүлж ярьж байна гэж, дэлгэрүүлж ярина гэж тэгж ярьдаггүй. Энэ чинь протокол болж бид нарт ирсэн байхгүй юу. Яг ийм юм ярина гээд энэний дагуу бүлэг бэлдэж байгаа биз дээ? Энэний дагуу бүлэг ямар дүгнэлт хийх вэ гээд бэлдчихсэн байгаа шүү дээ. Тийм, тэгээд яаж байгаа юм? Энэ Оюун-Эрдэнэ сайдын бид нарт тараасан мэдээллийг Сангийн сайд нь өөр мэдээлэл болгоод уншчихаж болдог юм уу? Ард түмэн бол саяын Жавхлангийн уншсан юмыг үнэн л гэж ойлгоно шүү дээ. Агуулга нь юу гэж гарав гэхээр ерөөсөө энэ 12-14 онд 6 онд ч байна уу дампууруулаад хаячихсан юм байна. Одоо бид нар ерөөсөө үйлээ үзэж байна. Энэ өр ширэнд баригдаад. Ийм л мэдээлэл хийлээ шүү дээ. Ийм л гүтгэлэг хийлээ шүү дээ.

Тэгэхээр энэ дээр чинь яаж одоо ийм болох юм? Одоо материалаа тараачих л даа Жавхлан. Хуулийнхаа дагуу материалаа тараа. Улсын Их Хурлын бүх гишүүдэд тараа. Одоо бид нар бол Цогтгэрэл даргаа арга хэмжээ авах хэрэгтэй. Нэг завсарлага аваад Ерөнхий сайдтай уулзах хэрэгтэй. Энэ Ерөнхий сайдын тараасан мэдээлэл энэ шүү дээ. 9 хуудастай. Энэ улс ингэж болох юм уу? Улсын Ерөнхий сайдын мэдээллийг Сангийн сайд нь өөр болгож уншиж болох юм уу? Ингэж гүтгэлгийн шинжтэй юм ард түмэнд ингэж цацаж болох юм уу? Хаана байна? Та нар хэвлэлийнхнийг үймүүлээд л баахан бужигнуулаад л. Тэгээд 4 гишүүний эрхийг гүдгэлзүүлэе.

Ерөөсөө улс төр хийж байгаа шүү дээ. Энэ банкиг дампууруулсан хүн нь энэ хүн юм чинь тэн дээрээс тиймэрхүү гүтгэлгийн юм унших байлгүй дээ. 17 онд яах гэж хууль өөрчилсөн юм? Тэгээд сая шууд ингэж уншиж байгаа юм. Би энэ хэдэн минут, секунд үлдчихэж. Тийм. Улсын Их Хурал, Засгийн газраас батлагдсан төслийг Хөгжлийн банк шууд хэрэгжүүлдэг гэнэ. Тийм юм байдаггүй. Тэндээс батлагдсан бүгд, энд Ерөнхий сайдаас хүн сууж байгаад гарчихлаа. 40 гаруй хувь нь санхүүжигдсэн байдаг юм. Ингээд би асуувал их сайхан нээлттэй хэдүүлээ олон нийтэд шударга, зөв юм яримаар байна.

Жавхлан буруугаа хүлээгээд наадхаа эсвэл тараа, эсвэл буцааж ав. Бид Ерөнхий сайд дээр орьё.

Г.Занданшатар: Болдын Жавхлан сайд асуулгад хариулна.

Б.Жавхлан: Нөхөр Алтанхуяг гишүүн одоо сандарч эхэлж байгаа юм. Таны одоо сандрах хугацаа чинь мөн л дөө. Саяын миний уншиж танилцуулсан дотор нэг ч тоо, үсэг зөрүүтэй зүйл байхгүй. Та бүхэнд тарааж өгсөн материалууддаа яв цав нийцнэ. Та ерөөсөө сандрах хэрэг байхгүй. Өнөөдөр

Хөгжлийн банкин дээр байгаа 3.2 их наядын 1.8 их наяд нь чанаргүй зээл. Үүний 1.5-ыг нь та өгсөн. Нөхөр Алтанхуяг. Та өгсөн. 2012 оны 12 сарын 15-ны 175 дугаар энэ тогтоол байж байна. Бодлогын зөвлөл нэртэй бондын зарцуулалтын шийдвэрийг гаргадаг. Үүнийх нь дарга нь Монгол Улсын Ерөнхий сайд Алтанхуяг гэж та мөн биз дээ? Норовын Алтанхуяг гэж мөн үү? Алтантуяа болоогүй биз дээ буцаад? Таны шийдвэрээр энэ бүх баримт, материалууд чинь одоо Хөгжлийн банкин дээр байж байна. Энийг чинь бүгдийг нь нэг бүрчлэн одоо үзүүлэхэд ч бэлэн. Танд тараах дахиж материал шаардлагатай бол танд тэр бүх шийдвэрүүдийг чинь аваачаад өгье.

Одоо Хөгжлийн банкин дээр байгаа “Чингис” бондын эх үүсвэрээр зээл өгсөн 1.5 их наядын чанаргүй зээл та энэ зөвлөлөөрөө шийдвэр гаргаж өгүүлсэн. Таны гаргасан шийдвэрийн дагуу Хөгжлийн банк тэнд зөвхөн гэрээ байгуулдаг л ийм үүрэгтэй явж ирсэн байгаа юм. Юу үнэн, энэ үнэн байгаа. Та одоо сандраад хэрэггүй. Та одоо энэ Хөгжлийн банкны асуудлаар, Монгол Улсын өр, зээлийн асуудлаар нэг тийм шударга хүн болж ярих танд эрх байхгүй шүү. Танд эрх байхгүй шүү. Таны өмнөөс таны тавьсан балгийг, таны тавьсан өрийг өнөөдөр энэ үе төлж байна. Та тухайн үед яг шударга хэлж байсан л даа. Өө яадгийн өр тавиад байя, тавиад байя. Үр хүүхдүүд маань төлчихнө биз гээд. Одоо яг тэр чинь л болж байна. “Чингис” бондын өрийг энэ жил одоо 12 сард 136 сая доллароор төлөөд барагдуулж байгаа юм. Дуусаж байгаа юм. Таны авчирсан өрийг энэ үеийнхэн төлж байгаа юм. Гэтэл “Чингис” бондынх чинь 1 тэрбум нь чанаргүй зээл болоод одоо Хөгжлийн банкин дээр байж байгаа. Юугаараа төлөх юм? Өнөөдөр татвар төлөгчдийн мөнгөөр таны авчирсан өрийг төлж байгаа шүү. Бодит байдал ийм байгаа юм. Та эндээс хаашаа ч зугтаах аргагүй. Одоо сандраад хэрэггүй.

Г.Занданшатар: Үг өгсөн. Үгээ тэгээд хэлээд суучихсан. Би юу хэлэхийг нь хянах эрх байхгүй. Одоо Хөгжлийн банкны захирал тодруулж хариульга гэсэн тээ? 85. Та Хөгжлийн банкнаас асуу. 85 Хөгжлийн банкны Гүйцэтгэх захирал. Асуулгад нь хариульга. Үгүй ээ энэ мэдээлэл хийнэ гээд Ерөнхий сайд. Дараагийн хүн нь асуултаа асууя. Тогмидын Доржханд гишүүн асуулт асууя. 5 минутаар явсан. Тодруулах юм байхгүй.

Т.Доржханд: Одоо ингээд бүгдээрээ сайхан, нээлттэй, шударга байх нь зөв байх. Тэгээд сая Сангийн сайдын уншсан зүйл бол миний ойлгосноор, ер нь бол энэ зээлийн асуудлуудыг энэ Ардчилсан намын нөхдүүд анхнаасаа сайхан замыг нь төөрүүлээд өөрсдөө шийдвэр гаргаад, тэгээд засаг дээрээс бүх юмыг нь шийдээд явчихлаа л гэдэг ийм л ерөнхий ойлголт авчихлаа.

Ардчилсан намын нөхдүүд маань та нар битгий худлаа яриад бай, тийм зүйл байхгүй, одоо бидэнд өгсөн танилцуулгаа хийгээч гэсэн ийм байр суурьтай байна. Тэгээд жүжиг тоглохоо больцгоо л доо. Яг бодит байдал дээр энэ хулгайг та нар хамтдаа хийсэн. Ардчилсан намынхан бол тэр тусдаа менежменттэй явдаг байсан компанийнх нь удирдлагыг нь, Солонгос менежментийнх нь багийг нь хөөж явуулаад л, өөрсдөө Засгаар шийдвэр гаргаад л ингээд л явсан нь үнэн шүү дээ. Бодит байдал үнэн шүү.

Дараа нь Ардын намынхан тэрийг нь, хуулийг нь өөрчлөөд л хулгай хийе гээд л. Бүр сайхан замыг нь алдуулсан нь бас бодитой үнэн шүү дээ. Аль аль нь та нар бүгдээрээ л хулгай хийсэн шүү дээ. Тэгээд үр дүнд нь өнөөдөр Сангийн сайд нь одоо дампуурчих гээд байна. Хөгжлийн банкны асуудлын бондыг шийдэхгүй Монгол Улс Хөгжлийн банкаараа дамжуулаад деполт зарчих гээд байна. Одоо энийгээ санхүүжүүлэе гээд. Ийм байдлаар оруулж ирж байгаа юм. Тэгсэн тэндээс Даваасүрэн гишүүн хөөе

хөөе хулгай хийсэн мөнгийг гаднаас зээл аваад санхүүжүүлэх гээд байна. Энэ Жавхлан ямар муухай нөхөр вэ гээд. Ингээд л ийм гурвалжин, дөрвөлжин. Би маш энгийн үгээр нь хэлж өгч байгаа шүү. Маш ойлгомжтойгоор ийм л юм болж байгаа юм.

Гэхдээ үр дүн хаана байгаа юм бэ? Үр дүнг нь энэ Хөгжлийн банкин дээр Түр хороо байгуулаад бид нар явсан. Ажиллаж байна 6 сар. Ямар ч үр дүн байхгүй. Хуулийн байгууллагууд дээр 86 хэрэг боогдоод явж байгаа гэсэн одоо хүртэл шийдвэрлэгдсэн зүйл байхгүй. Тэр дээр нөгөө Ардын нам, Ардчилсан нам, нөгөө том Ерөнхийлөгч байсан нөхдүүдийн асуудал нэг ширхэг ч байхгүй. Байхгүй. Хариуцлага тооцье гээд хуулийн байгууллага орж ирэхэд та нар энийг нууцын журмаар гэж байгаад хариуцлага тооцох хүмүүсээ бүгдийг нь аваад л, өмөөрөөд л гараа биз дээ? Бодит байдал энэ шүү дээ.

Одоо ингээд бие биедээ дургүйцээд байдаг. Шударга байцгаая. Ил тод байцгаая. Хариуцлагаа ярих юм бол аль алиныг нь дэлгэрэнгүй ярья л даа. Энэ Засгийн газар тэр Ардчилсан намын хүсээд байгаа материалыг нь өгчих л дөө. Яагаад өгөхгүй байгаа юм? Саяын ярьсан юмнууд бодитой юм бол өгчих л дөө. Ардчилсан нам ч гэсэн буруугүй бол буруугүйгээ хэлээд ярь л даа. Ил тод ярьцгаая л даа. Хамгийн гол нь та нарын хийсэн энэ хамтарсан хулгайнаас чинь болоод Монгол бас өнөөдөр дампуурах гээд байна шүү дээ. Энэ юу үнэн, тэр үнэн шүү.

Хөгжлийн банкны энэ 500 сая “Евро”-гийн бондыг бид нар төлж чадахгүй. Хөгжлийн банк төлж чадахгүй бол Монгол Улс дагаад диполт зарлана. Улсаараа хохирно. Тэгэхэд энэ Засгийн газраас болохоор ямар ч байсан Засгийн газар баталгаа гаргачих тэр боломжийг өгчихөө. Тэгсэн тохиолдолд бид нар төлүүлж чадахгүй бол дахин санхүүжилт

хийе гэдэг ийм л өрөвдөлтэй нөхцөл оруулж ирж байгаа байхгүй юу.

Монгол Улс хулгайндаа ялагдчихсан, авлигадаа ялагдчихсан. Нийлээд ууж, идэх болохоороо найз нөхөд болчихдог. Хариуцлага тооцох болохлоороо эндээ жүжиглээд яах вэ дээ. Тэгээд хуулийн байгууллагын оруулж ирсэн зүйлийг нь үүгээрээ хамгаалж явдаг, хэн ч хариуцлага хүлээдэггүй. Энэ чинь Монгол Улсын парламентын нэр хүндийг унагаад байгаа шүү.

Хоёрдугаарт, Түр хороонд санхүүжилт байхгүй. Хоёрхон эксперт байгаа шүү дээ. Шинжээч гээд. Оюу Толгойн гэрээ, хэлэлцээрийг шалгах явцад Сангийн яам дээр бид нар ажлын хэсэг гаргаад явахад 3, 4 контейнер бичиг баримтыг 2 сар бид нар 200-гаад хүн ингэж ухаж байж гаргаж ирсэн байдаг. Тэрний үр дүнд бид нар 2 тэрбум долларын илүүдэл зардал байна. Хууль зөрчсөн байна гээд өнөөдөр Оюу толгой өнөөдөр бас үр дүнд хүрээд явж байгаа нь тэр мэргэжилтнүүдийн ажил байдаг байхгүй юу.

Гэтэл өнөөдөр энэ Хөгжлийн банкны Түр хороон дээр 2-хон эксперттэй. Санхүүжилт нь байхгүй. Тэгтэл Оюу Толгойн тэр зөрчилтэй бичиг баримтаас 2-3 дахин илүү их материал тэнд байгаа байхгүй юу. Энийг шалгах хүн, хүч байхгүй. Санхүүжилтийг нь гаргаж өгдөггүй. Үгүй тэгээд яаж бид нар хариуцлага тооцох гээд байгаа юм бэ? Яаж шударга дүр үзүүлчхээд энд худлаа ярьдаг.

Гэхдээ эргээд авлигадаа бид нар цэг тавьж чадах юм бэ? Олон нийтэд хамгийн их хүлээлт үүсгэсэн хэрэг бол энэ Хөгжлийн банк шүү. Хөгжлийн банк. Хөгжлийн банкны энэ асуудлыг бүгдээрээ нээлттэй, ил тод ярья. Ардчилсан нам энэ бүлэг нь цэгцэрсэн юм бүлэг шиг ажилла. Завсарлага ав, шаардлагаа хатуухан тавь. Ингэж байж бид нар энэ асуудлыг тавиад явах нь зүйтэй. Ингэж байгаа тохиолдолд

Ардчилсан намыг би дэмжье. Шаардлагаа тавь, материал ав. Тэгээд бүгдээрээ ил тод нээлттэй ярилцъя. Ардын нам ч гэсэн бодитой мэдээллээ өг. Энэ дунд хамгийн чухал нь үр дүн чухал шүү. Хариуцлага.../минут дуусав./

Г.Занданшатар: Яг чухал. Үр дүн нь чухал шүү. Хамгийн гол нь. Болдын Жавхлан сайд хариулъя. Тэр материал яагаад тараагаагүй юм?

Б.Жавхлан: Доржханд гишүүнтэй ерөнхийдөө санал нийлж байна. Нийлж байна. Ер нь ийм болчихсон Хөгжлийн банкныг л бид авсан шүү дээ. Оюун-Эрдэнийн Засгийн газар маш хүнд Хөгжлийн банкныг хүлээж авсан. Үндсэндээ дампуурчихсан байсан. Дампуурчихсан, тухайн үед шалгасан материалууд нь ч байхгүй. Ер нь ямар чанаргүй зээлтэй, ямар хэмжээтэй банк авснаа ч бид нар мэдэхгүй л хүлээж авч байсан.

Харин жил хагасын хугацаанд бид нэлээдгүй арга хэмжээ авсан. Хатуу арга хэмжээнүүд авсан. Үр дүн харин гарч байгаа шүү. Үр дүн харин гарч байгаа. Өөрийн хөрөнгө нь тэг болчихсон байсан банкныг хүлээж авсан. Одоо ямар ч байсан 1 жилийн хугацаанд бид 800-гаад тэрбум төгрөг төлүүллээ. Төлүүллээ. Энд олон хүний хүч хөдөлмөр орсон. Улсын Их Хурал дээрээс ч дэмжлэг үзүүлсэн. Засгийн газрын бид бүх бүтцээрээ ажилласан. Хууль, хүчний байгууллагууд ч ажилласан. Хэвлэл мэдээллийн байгууллагууд ард түмний хариуцлагын индэр гэдэг маш том индэр ажиллуулсан. Ил тодын индэр гэж. Энэний үр дүн ингэж гарсан. Жил хагасын өмнө бид энэ банкныг авахад хойтон жилийн төлөх юун “Самурай” бонд, юун “Евро” бонд төлөх мантай байсан. Одоо харин бид “Самурай” бондоо хугацаанаас нь ч өмнө төлчих ийм боломжтой болж ирлээ.

Хойтон бид заавал 12 сар хүлээх шаардлага байхгүй. Өнөөдрөөс бид “Самурай” бондыг төлөөд явахад ч бэлэн

болсон. “Евро” бондынхоо бэлтгэл ажилд орсон. Бэлтгэл ажилд орсон. Хөгжлийн банкныхан зээлжих зэрэглэлүүдийг хэвээр нь хадгалж чадлаа. Засгийн газрынхаа зээлжих зэрэглэлийг мөн хэвээр нь хадгалж чадлаа. Энэ бол гадна зах зээл дээр маш том зэрэг мессеж. Ийм хүнд үед. Энэ бондуудын эргэн төлөгдөх асуудал болон Хөгжлийн банканд дотор чанаргүй зээлийн асуудал яригдаад эхлэхээр их сандардаг юм хүмүүс. Гадна талд чинь Ардчилсан намын бонд. Алтанхуягийн Засгийн газрын үед гаргасан бонд, Ардын намын Засгийн газрын үед гаргасан бонд гэж ярьдаггүй шүү дээ гээд. Үнэн л дээ. Энэ яг үнэн. Гадна талд Монгол Улсын Засгийн газрын бонд л гэж ярьдаг. Харин тийм учраас бид хойтон энэ бондуудыг хариуцлагатайгаар төлөх ёстой.

Тийм учраас Алтанхуягийн Засгийн газрын үед гаргасан “Чингис” бондыг бид маш хариуцлагатайгаар энэ жил, одоо 12 сарын 5-нд 136 сая долларын сүүлийнх нь төлбөрийг төлөөд ингээд “Чингис” бонд гадна талдаа төлбөр нь дуусаад, дотор талдаа чанаргүй зээлтэйгээ бид үлдэнэ. Ийм үр дүнгүүд гарч байгаа. Ийм үр дүнгүүд гарч байгаа юм. Жилийн эцэс болтол бид 1 их наядыг төлүүлнэ. 1 их наядыг төлүүлнэ. Ингээд өөрийн хөрөнгийн үзүүлэлтүүд энэ банкны бусад макро үзүүлэлтүүд бид олон улсын энэ хөрөнгө оруулагч нарынхаа өмнө хүлээсэн үүрэг, шаардлагадаа хүрэх зорилго тавиад ажиллаж байгаа. Ийм хүнд чөтгөрийн тойрог дотроос энэ банк эсэн мэнд үлдэнэ гэсэн үг. Одоо энд хэн ч саад болж чадахгүй. Яаж ч сандраад нэмэргүй.

Өнөөдрийн ярьж хэлж байгаа зүйлүүд дээр нэг ч зөрүүтэй тоо байхгүй. Нэг ч зөрүүтэй тоо байхгүй. Байх ч үндэс байхгүй энэ. Энэ бүх зүйл ил тод болоод 1 жил гарантай боллоо Алтанхуяг гишүүнээ. Та одоо битгий сандар. Таны “Чингис” бондын өрийг бид энэ үеийнхэн чинь яг таны хэлснээр хойч үеийнхэн чинь төлж барагдуулж дуусаж байна.

Хөгжлийн банкин дээр байгаа энэ чанаргүй зээлүүдийг та очоод тэнд өр барагдуулах албаныг даргалаад төлүүлэх учиртай хүн шүү та. Чамтай би алалцаад одоо явж байгаа юм. Чанаргүй зээлийг очиж хоёулаа цуг барагдуулна шүү.

Г.Занданшатар: Сая Тогмидын Доржханд гишүүн асуултаа асуусан. Үгүй, 1 хүний дараа ахиад ингээд байх юм. Дураараа эрхлээд. 85. Үг хэлнэ. Мандуул Хөгжлийн банкны Гүйцэтгэх захирал. 85. Саяын 2 асуултад хариулчихъя. Нийлүүлээд хариулчих.

Н.Мандуул: Баярлалаа. За яах вэ, Хөгжлийн банкны гүйцэтгэх удирдлагын хувьд бол Ардчилсан нам, Монгол Ардын нам гэсэн ямарваа нэгэн ялгаа байхгүй. Бидний хувьд хууль батлагдсан хуулийнхаа хэрэгжилтийн үечлэлээр нь зээлүүдээ хувааж үзэж байгаа юм.

Яг өнгөрөгч оны эцсээр Монголбанкнаас шалгалт орж, Хөгжлийн банк нийтдээ 3.2 их наяд төгрөгийн зээлийн активтай байсан. Үүний 1.8 их наяд төгрөг нь чанаргүй зээл болсон гэсэн дүгнэлт гаргасан байгаа. Хөгжлийн банкны хувьд үүсгэн байгуулагдсан цагаасаа хойш 2011 онд 1 хууль батлагдсан. 2017 онд дахиад 1 хууль батлагдсан байгаа юм.

Тэгэхээр би яг энэ хуулийн хэрэгжилтийн дагуу чанаргүй зээлүүд нь яаж хуваагдаж байгааг хэлье. 2012-16 онд энэ 1.8 их наяд төгрөгийн чанаргүй зээлийн 1.3 их наяд төгрөг нь энэ онуудад гарчээ. 2012-16 онд.

Харин шинэ хууль батлагдсанаас хойш буюу 2017-2022 онд 500 тэрбум төгрөг ингэж гарсан байна. Эх үүсвэрийн хувьд Хөгжлийн банк “Чингис” бондыг бас зарцуулалтыг нь хариуцсан байгаа. Нийтдээ 3.5 тэрбум долларын зээлийн олголт хийсэн байдаг. Үүнээс 2.7 тэрбум доллар буюу 80 хувь нь Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэрээр гарсан зээл байгаа. Үлдэх 20 хувь буюу 0.8 тэрбум

доллар нь бол Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын шийдвэрээр гарсан ийм зээл байдаг. Баярлалаа.

Г.Занданшатар:

Ширнэнбаньдын Адьшаа гишүүн.

Ш.Адьяа: Өнөөдөр энэ Хөгжлийн банкны тухай жил гаруй хугацаанд бид нар ярилаа. Энэ ард түмний боломжийг хулгайлсан Монгол Улсын эдийн засгийг дампуурах хэмжээнд хүргэсэн энэ асуудлыг ингэж улс төржсөн байдлаар бид ярьж болохгүй. Үр дүн байх ёстой. Хэн нь илүү хар вэ гэдгийг өнөөдөр маргалдаад л, завсраас нь тэгээд л Доржханд тэнд 2 тал руу нь урдаг нохой шиг дайраад оноо авна гэвэл энэ андуурал шүү. Ингэж явахгүй. Бид асуудалд бодитой хандъя. Энийг цаашид яаж таслан зогсоох вэ, ямар үр дүн гарах вэ гэдгийг л бид ярих ёстой. Хариуцлага ярих ёстой. Би энэ улс төржиж асуумааргүй байна. Энэ Хөгжлийн банкны ажлын хэсэг төрийн нэрийн өмнөөс хяналт тавьж байгаа Ерөнхий прокурорын орлогчоос асуулт асууя. Энэ дэлхийд байхгүй нэг юм байгаа юм энэ Хөгжлийн банкны зээл олголт дээр. Хөгжлийн банкнаас барьцаагүй, ирээдүйд олох орлогоосоо энэ зээлийг төлнө гэсэн ийм хууль, эрх зүйн бичиг баримт гаргасан байдаг. Энэ хэчнээн компани байгаа юм? Энэ хууль, эрх зүйн орчныг хэдийд, ямар албан тушаалтан, ямар хуулийн шийдвэрээр энийг гаргасан юм бэ гэдэг энд л би хариулт авмаар байна.

Бусад нь ил тод, тодорхой байгаа. Ингэж өнөөдөр маргалдаад, тэмцэлдээд энэ асуудлыг улам бүдгэрүүлж байна. Улс төрчид оролцоод, маргаан тэмцээн хийгээд, хэвлэл мэдээллээр ил тод гээд энэ чинь улам бүдгэрч, жинхэнэ гэм буруутай хүмүүс нь ард нь үлдэж, наана хэвлэл, социалын хэмжээнд энэ хэргийг мөрдөж байгаа гэсэн ийм халхлалт энд явагдаж байна гэж бодож байна. Энийг ард түмэн ингэж харж байгаа. Энэ одоо хэчнээн компани байна? Энэ эргэн төлөлт ямар байна? Энэ хүмүүст ямар хариуцлага

хүлээсэн гэдэг талаар би энэ төрийн нэрийн өмнөөс энэ хэргийн, цаашлаад энэ хэргийн хохирлыг барагдуулахад хяналт тавьж байгаа прокурорын байр суурийг л сонсьё.

Г.Занданшатар: Ерөнхий прокурорын орлогч Максимын Чинбат. Чинбатын Максим.

М.Чинбат: Их Хурлын гишүүн Адьяагийн асуултад хариулъя. Авлигатай тэмцэх газраас Хөгжлийн банкны асуудалтай холбогдуулж 2012 оноос 21 онуудад олгосон энэ зээлийн асуудалтай холбогдуулж 50 гаруй хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулсан. Ингээд хэрэг бүртгэлтийн шатанд явуулсан ажиллагааны үр дүн, шалгалтын ажиллагааны үр дүнд өнөөдрийн байдлаар бол бид 2 мөрдөн байцаалтын хэргийг шүүхэд шилжүүлэх саналтай Авлигатай тэмцэх газраас хүлээж аваад байна. Өчигдөр Нийслэлийн прокурорын газарт ирүүлсэн. Энэ 2 хэрэг дээр бол Хөгжлийн банкны эрх бүхий албан тушаалтнууд, аж ахуйн нэгжийн албан тушаалтнууд, төрийн албан тушаалтнууд албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглаж өөртөө болон бусдад давуу байдал олгосон 80 гаруй албан тушаалтан, аж ахуйн нэгж яллагдагчаар татагдаж ингэж орж ирсэн байна.

Үүнээс гадна Авлигатай тэмцэх газарт Хөгжлийн банкнаас зээл аваад чанаргүй ангилалд орж, зээлийг төлөөгүй 20 гаруй хэрэгт бол хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулж байна. 22 оны 1 сарын 20-ноос хойш мөрдөн шалгах ажиллагаа явагдаж байгаа эдгээр хэргүүд дээр 2.3 их наяд төгрөгийн зээл олгосон энэ асуудлыг нь шалгаад эндээс бол 778 тэрбум төгрөгийн хохирлыг биечлэн төлүүлсэн гэсэн мэдээг сая бас сайдын мэдээлэлд уншигдлаа. Энэ бол яг мөрдөх байгууллага, прокурорын зүгээс эрүүгийн хэрэг дээр гаргасан ийм тоон үзүүлэлт бол зээлийн эргэн төлөлтийн дүн мэдээ байгаа юм. Энэ дотроос нэр бүхий 14 аж ахуйн

нэгж бол зээлийг бүрэн төлж барагдуулсан. Ийм дүнтэй байна.

Г.Занданшатар: Нэмэлт байдаггүй юм байна дэгээрээ. Гүйцээж хариулж болно. Сая 2 минут хариулсан учраас. 2 минутаар. Хариулах хүн байхгүй юу? Болдын Жавхлан сайд.

Б.Жавхлан: Алтанхуяг гишүүн маань жоохон сандраад алалцана энэ тэр гээд. Бодвол ичсэн хүн хүн ална гэдэг шиг болох гээд байх шиг байна та тээ? Та яг Норовын Алтанхуяг гэж мөн гэсэн тээ? Би танд нэг юм уншиж танилцуулъя. 2013 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн 76 дугаар Засгийн газрын тогтоол, Сайншанд аж үйлдвэрийн цогцолборын бүтээн байгуулалтыг эхлүүлэх тухай гээд нэлээн урт.

Би 1 л заалтыг нь уншъя. 2 дугаар заалт дээр ингэсэн байдаг юм. Сайншанд аж үйлдвэрийн цогцолборын байгаль орчны төлөв байдлын үнэлгээ, суурьшлын бүсийн хэсэгчилсэн төлөвлөгөө, зөвлөх үйлчилгээнд 2013 онд шаардагдах 14 тэрбум төгрөгийг зохих журмын дагуу санхүүжүүлэхийг Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөл Шинэбаатарт зөвшөөрсүгэй. Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг гэж одоо би таныг мөн гэж ингэж л бодож байна. Ийм олон арван тогтоол байгаа. Энэ тогтоолын дагуу шууд тэнд зээл олгогдсон байдаг. Өнөөдөр энэ зээлүүд чинь чанаргүй болчихсон. Эргэж төлөгдөөгүй ингээд байж байгаа. 1.1 их наяд төгрөгийн чанаргүй зээл байгаа шүү Алтанхуяг гишүүнээ.

Г.Занданшатар: Салдангийн Одонтуяа гишүүн. Одонтуяа гишүүн чинь дараа шүү дээ. Уучлаарай. Одонгийн Цогтгэрэл гишүүн.

О.Цогтгэрэл: Ерөнхий сайдын мэдээлэл гэж 2 долоо хоног тутам болдог.

Г.Занданшатар: Ном, материалаа л тараачих л даа.

О.Цогтгэрэл: Маш чухал энэ Улсын Их Хурлын арга хэрэгслийг ингэж бас завхруулж байна. Ерөнхий сайдын мэдээллийг Сангийн сайд нь өөрчилж уншаад, Улсын Их Хурлын дарга нь дэг зөрчиж хаацайлаад. Тэгэхдээ бас Их Хурлын, ард иргэдийн мэдэх эрхийн хүрээнд, өмнөх материалын хүрээнд Ардчилсан намын бүлгээс бэлтгэсэн 20 минутын танилцуулгыг нь 4 минутад нь багтаагаад товчлоод бас уншиж танилцуулъя. Асуулт асуух цаг байхгүй болох нь.

Монгол Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хөгжлийн банк хууль нь батлагдаж, үйл ажиллагаа нь эхэлснээс хойш 11-хэн он өнгөрсөн залуухан байгууллага. Гэвч Хөгжлийн банканд болж өнгөрч буй энэ үйл явдлууд нь улс төрийн хараат, улс төрчдийн мэдэлд байдаг том мөнгөтэй, төрийн болон төрийн өмчит байгууллагууд хэрхэн ялзардаг, улс оронд ямар хэмжээний хор хохирол учруулдгийг Монголчууд бидэнд үзүүлсэн сургамжтай, харамсалтай жишээ болж байна.

10 гаруйхан жилийн түүхтэй Хөгжлийн банкны хөнжлийг нээж үзэхэд асуудал дагуулсан ийм олон зүйл байхад үүнээс удаан хугацаанд салхи хураагүй төрийн байгууллагууд, төрийн өмчит компаниуд дээр ямар гамшиг, аюул нүүрлэж буйг төсөөлөхөд хүнд.

Хөгжлийн банк эх үүсвэр татах, зээл олгох, зээлээ төлүүлэх, татсан эх үүсвэрээ эргүүлэн төлүүлэх үндсэн үйл ажиллагаа эрхэлдэг. Гэвч эдгээр үзүүлэлтүүдийн чанар 2017 оноос огцом муудаж эхэлснээр аргагүй эрхэнд олны анхааралд ирсэн. Үүний шалтгаан нь Хөгжлийн банкны тухай хуульд 2017 онд өөрчлөлт оруулсан. Улс төрөөс хараат болгох нөхцөлийг бүрдүүлж, тэдний шахалт шаардлагаар барьцаагүй, барьцаа хангалтгүй, зээлийн судалгаа муу

төслүүдийг санхүүжүүлэх үүд хаалгыг нээж өгсөн явдал гэсэн дүгнэлт гардаг.

Хөгжлийн банкны 2017 оны хууль одоо ч хүчин төгөлдөр үйлчилж байгаа. Банкны албан тушаалтан хөгжлийн төслийг дангаар тодорхойлох, Улсын Их Хурлын бодлогоос гадуур байгаа нөхцөлд дараа дараагийн эх үүсвэр маань хариуцлагагүй зарцуулагдах үүд хаалга нээлттэй хэвээр байна.

Хөгжлийн банкны зээлүүдийн эргэн төлөлтийн асуудал улс даяараа анхаарал хандуулж эхэлснээс хойш даруй 1 жил шахам хугацаа өнгөрч байна. Үүнээс өмнө концесс, ЖИДҮ тэргүүтэй улс төрчдийн цөлмөсөн хэргүүд илэрч, Засгийн газар хүртэл огцорч байсан. Гэвч энэ хэргүүдийн ард бодитойгоор чухам ямар үйл явдлууд өрнөж, ямар хэмжээний хохирол улсад учирч, эрх мэдлээ хэтрүүлж албан тушаал ашиглан хийсэн дарга нарын гарын салаагаараа урсгасан мөнгө ямар дүнтэй болсон нь өдгөө ч бас нууц хэвээрээ л байна.

Асуудлын шалтгаан хийгээд түүнийг задруулсан шийдэл нь одоог хүртэл нууц. Эдгээрийг залган Хөгжлийн банк одоо яригдаж буй Тавантолгойн гэрээний дуулианууд ч гарч байна.

Гэтэл өнөөдрийг хүртэл Хөгжлийн банкин дээр хийгдсэн удаа дараагийн шалгалтуудын материалыг ил болгохгүй, аудитын байгууллага хянах, шалгах эрх бүхий байгууллагуудын дүгнэлтийг Улсын Их Хурал олон нийтэд танилцуулагдахгүй байгаа нь эрхгүй бас хардлага төрүүлнэ. Улс төрийн зорилготой багахан хэсэг нь ил болсноос бус өнөөг хүртэл Хөгжлийн банк, ЖИДҮ, концесс, Эрдэнэс Тавантолгойн будилааны ихэнх хэсэг нь нууц хэвээрээ байгаа. Яагаад ийм байдалд оров? Яагаад ийм хүндрэлт байдлаас гарах вэ гэдэг шалтгаан руугаа хандсан бодлого, цаашдын төлөвлөгөөг танилцуулахгүйгээр Ардчилсан намыг

хэдэн хүнийг нийгмээр яллуулахад анхаарч буй нь тун ч харамсалтай.

Энэ бол асуудлын жинхэнэ шалтгаан нь цаашдын бодлого, төлөвлөгөө рүүгээ анхаардаггүй, аливаа аргалаад хэн нэгэн буруутныг олж, шонд өлгөж асуудлыг аргалж өнгөрдөг эрх баригчдын шалгарсан аргын нэг. Энэ арга барилаасаа татгалзаж, Хөгжлийн банкаа цаашид яах вэ гэдэг? Цаашид засаглал, менежментийг хэрхэх вэ гэдэг үндсэн асуудал дээрээ бас төвлөрөхгүй. Хугацаа их хойшилж байна.

Иймд олны үр нуршина. Ардчилсан намын бүлгээс дараах асуулт, санал, дүгнэлтийг бас танилцуулж байна.

Нэгдүгээрт нь улс орны хөгжлийг том мега төслүүд хэрэгжүүлэх замаар хөгжүүлнэ гэсэн энэ үзэл баримтлал, философийг бас эргэж харах ёстой. Яагаад гэвэл үүний цаана төр улсын нэрийн өмнөөс бонд босгож, зээл авч төрийн компани байгуулагдана. Улс төрчдийн захиалгаар улс төржсөн хүсэл зоригоор шийдвэр гарна л гэсэн үг. Сонсогдох үгс нь их гоё ч гэсэн бодит байдал дээр том төр, том даргын тоог л нэмнэ. Энэ туйлын зөв бодлого уу? Энэ асуултад бид юуны өмнө бас хариулах ёстой.

Хоёрдугаарт нь Хөгжлийн банк Монгол Улсын хөгжилд хэрэгтэй, байх ёстой гэж үзвэл засаглалыг нь сайжруулах ёстой. Олон улсын шилдэг туршлага, хараат бус мэргэжлийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын урамшуулсан тогтолцоо, хөндлөнгийн аудит зэргийг энд бас багтах ёстой.

Гуравдугаарт, Монгол банкны оролцоо, хэмнэлт, зохист харьцааны шалгуурыг Хөгжлийн банканд бас эрс нэмэгдүүлэх ёстой. Одоо өөх ч биш, булчирхай ч биш гэдэг шиг банк ч биш, компани ч биш, төрийн өмчит үйлдвэрийн газар ч биш эрх баригч улс төрчдийн касс болж бас хувирсан.

Тэгээд ингээд уншвал дүгнэлт байна. Тэгээд 30-хан секунд үлдэж байна. Ард иргэдийн бас мэдэх эрх гэж зүйл байгаа. Сая Сангийн сайдыг нь ингэж гуйвуулан уншиж байгаа, тараагдаагүй материалыг уншиж байгаа, Улсын Их Хурлын гишүүдийн мэдэх, бэлтгэх эрхэнд бас халдаж байгаа энийг залруулах үүднээс Улсын Их Хурлын тухай хуулийн 33.1.4-т заасан эрхийн хүрээнд Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн зүгээс мэдээллээ тараагаач, мэдээллийг авч улам нягталж асуудалд хандья гэж Улсын Их Хурлын даргаас 1 цагийн завсарлага өгөхийг хүсэж байна.

Г.Занданшатар: Дүгнэлтээ гүйцээгээд уншчихсан тээ? Тэгээд цагийн завсарлага авчаж байгаа юм байна тээ? Тэгэхдээ энэ чинь хэлэлцүүлэг дээр завсарлага авах юм байгаа бил үү? Хэлэлцүүлгийн үеэр. Зочдоо танилцуулчихъя. Тэгээд Цогтгэрэл гишүүн гүйцээгээд уншчих уншчих. Түрүүн буруу ойлголт гараад юу яачихсан. Мэдээллээ дуусгаагүй байх. Яг тараасан мэдээллээ үг, үсэггүй уншина гэсэн утга, заалт байхгүй шүү дээ. Мэдээлэл дэлгэрүүлж өгч болно. Шаардлагаа нэмэгдүүлж болно. Шүүхийн процесс ч гэсэн шаардлага нэмэгдүүлнэ, нэмэлт яаж болно гэж. Тэгээд цөөнхийн бүлэг хүсэж байгаа учраас 1 цагийн завсарлага өгье.

Ардчилсан намын бүлгийн саналаар 1 цагийн завсарлага өглөө.

Зочдоо танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Дамбын Батлутын урилгаар Орхон аймгийн Эрүүл мэндийн салбарын албан хаагчдын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Хүн ардынхаа эрүүл энхийг хамгаалах та бүхний ариун үйлсэд өндрөөс өндөр амжилтыг хүсэн ерөөе. Эмч, эмнэлгийн ажилтан та бүхнээрээ Монголын ард түмэн бахархаж байгаа

шүү. Энэ хүнд цаг үеийг даван туулахад та нарын хичээл зүтгэл онцгой их байлаа.

Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэлээс тавьсан шаардлагын дагуу 1 цагийн завсарлага өглөө. Тэр нэмэлт материал энэ тэрээ тараах зохилтой бол одоо тэгээд. Ном хэвлэчихсэн, тараасан юм байгаа юм уу? Хөөе Жавхлан сайдаа. Материалаа тараа гээд байна шүү дээ. Тэр материалаа өгч байж хийе.

15.07 цаг

*Баасан гараг 04 Аравнэгдүгээр сар 2022
Төрийн ордон “Их хуралдай” танхим
16 цаг 06 минут.*

ҮРГЭЛЖЛЭЛ

Г.Занданшатар: Улсын Их Хурлын намрын ээлжит чуулганы 11 дүгээр сарын 4-ний өдрийн үдээс хойших нэгдсэн хуралдааныг үргэлжлүүлбэ.

Ажлын хэсэг Сангийн сайд, холбогдох бусад албан тушаалтнуудыг оруулъя. Ардчилсан намын бүлгийн авсан завсарлагын хугацаа дууссан байна.

Одонтуяа дарга удирдвал удирд удирд. 4.10-аас завсарлагын хугацаа дуусна. Сангийн сайдыг дууд. Ажлын хэсэг Болдын Жавхлан Сангийн сайд, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Дашзэвэгийн Амарбаясгалан, Эдийн засаг, хөгжлийн сайд Чимэдийн Хүрэлбаатар, Монголбанкны Ерөнхийлөгч Бядрангийн Лхагвасүрэн. Хөгжлийн банкныхан байна. Прокурорынхон байна. Авлигатай тэмцэх газрын Азжаргал дарга байгаа юм байна шүү дээ тээ? Түрүүн тэнд сууж байсан. Авлигатай тэмцэх газрын Тэргүүн дэд дарга Азжаргал байна. Бусад нь орж ирье. Дуудъя.

Ардчилсан намын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл завсарлагын хугацаа

дууссан байна. Үг хэлэх үү? Үг хэлэх үү? Одонгийн Цогтгэрэл гишүүн.

О.Цогтгэрэл: Улсын Их Хурал дээр Монгол Улсын Ерөнхий сайд 2 долоо хоног тутамд хийдэг асар чухал ийм ард түмний мэдэх эрхэнд тийм хөшүүрэг өгсөн асар чухал заалт ерөнхийдөө ийм бантан болж байна. Өнгөрсөн 2 жилийн хугацаанд Ерөнхий сайд, Ерөнхий сайдын албан бичиг дээр, бланк дээр хаяглагдаж ирсэн Ерөнхий сайдын мэдээлэл гэдэг зүйлд Ерөнхий сайд өөрөө ганц ч удаа орж ирсэнгүй. Энэний өмнөхийг бас нэг шалтгаар бас л хойшлуулж байсан. Урьд нь ерөөсөө энэ 2 жилийн хугацаанд ганц ч удаа орж ирээгүй. Ингээд сайд нь урдаас нь төлөөлж орж ирдэг. Сайд орж ирээд Ерөнхий сайдын өмнөөс орж ирсэн мэдээллийг өөрөө залруулаад, шал өөр болгоод уншчихдаг.

Сая одоо бид нар нэхсээр байж нэг материал авч байна. 2 цаас ирж байна. Саяын 1 цаас нь хаана байна? 2 цаас ирж байна л даа. Нэг нь 15 хуудас. Энэ дээр энэ камерт харагдахгүй байх даа. Энэ нэг ном дагалдаж ирж байна. Хөгжлийн банктай холбоотой үйл ажиллагаа, тогтоол шийдвэр гээд. Огноог нь харахаар 2012 оны 8 сараас 16 оны 6 сар. Энэ Хөгжлийн банк гэдэг байгууллага чинь уг нь 11 оноос 22 оны 11 жилийн үйл ажиллагааны тайлан болоод нөхцөл байдлыг энд сонсож байгаа гэж бид нар ойлгож байгаа.

Тэгэхээр ерөөсөө энэ нэг бол ажил хийсэн нь 12-16 он юм уу? Аль эсвэл энд зөвхөн улс төржүүлэх гэж зөвхөн 12-оос, энэ сүүлийн 6 жил хаачихсан юм? Монголын төр байгаагүй юм уу? Одоо ирсэн материал 12-16 он, сая Жавхлан сайдын тэнд голд уншсан материал 12-16 он. Тэнд хэрхэн завхруулсан тухай. Энэ сүүлийн 6 жил чинь Монголын төр уг нь байсан биз дээ? Асуудлыг бас ингэж хэтэрхий улс төржүүлж, ингэж ерөөсгөлөөр хандвал энэ Хөгжлийн банк гэдэг зүйл цааш цаашид улам л хүндрэлтэй зам руугаа энд ямар нэгэн

гарц, шийдэл байхгүй, цаашид яах гэж байгаа, авах арга хэмжээний тухай бодлого шийдвэр юу ч байхгүй. Яг энэ чигээрээ үргэлжилнэ. 17 онд завхруулсан нөгөө хуулийн заалт байгаа. Хөгжлийн банкныг. Улсын Их Хурлын хаврын чуулганаар тухайн жилийн төсөл, хөтөлбөрийн жагсаалтыг батална гэсэн заалтыг авч хаяж байгаад тэрнээс хойш завхруулсан заалт яг тэр чигээрээ, дахиад дээрээс нь энэ ном дээр энэ тухай ганц зүйл, заалт Монголын төр 12-16 онд л ажилласан. Ийм л зүйл, заалттай ном.

Тэгээд 17 оноос хойших саяын тэр нөхцөл байдал, асуудал хүндрүүлсэн хуулийн төслийн нэмэлт өөрчлөлт энэ бүх зүйл бүгд хэвээр, нөхцөл байдал бүгд хэвээрээ байгаа. Нөхцөл байдал бүгд хэвээрээ байхад энэ тухай юу ч дурдахгүйгээр ингэж улс төржүүлсэн тайлбар хийж байгаа нь харамсалтай байна.

Тэгээд Улсын Их Хурлын дарга та бас энэ Улсын Их Хурлын үйл ажиллагааны энэ үндсэн чиглэл, энэ бас хуулиар олгогдсон эрх хэмжээнд Засгийн газрын гүйцэтгэх засаглалыг бас шахаж шаардаж ажиллах, Улсын Их Хурал дээр мэдээлэл хийх, мэдээлэл нь чанартай байх, мэдээлэл нь үнэн, зөв байх энэ нөхцөл байдлыг та хангаж ажиллах нь бас таны Улсын Их Хурлын даргын үүрэгт бас байгаа байх. Таныг бас хуулиа биелүүлж, сахиж ажиллахыг бас бид бүгдийн зүгээс бас шаардаж байна.

Г.Занданшатар: Уг нь бүлгийн завсарлага өгөөд завсарлагатай холбогдуулж завсарлага дууссан, үгүй л гэсэн асуудаг. Тийм, үгүй л гэж. Энтэй холбогдуулаад үг хэлчихлээ. Тэгээд үг хэлүүлээд л аминдаа л дэмжээд л байна та нарыг. Цаг энэ тэр гаргаж өгөөд л. Мэтгэлцээний цаг хүртэл гаргаж өгөөд л байна. Одоо ингээд асуулт, хариултаа үргэлжлүүлэе. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Нэлээн томоохон хэмжээний 7 банк байдаг юм. Дампуурсан. Тэрний 6-г нь манай Монгол Ардын нам нугасалж авсан. Тэгээд Сэргээн босголтын банк бил үү? Тэр нь Ардчилсан намд хамаатай л даа. Тэгээд банк дампууруулаад сурчихсан нөхдүүд тэндээсээ баахан зээл аваад. Банк дампуураад сурчихсан нөхдүүд тэр зангаараа л энэ Хөгжлийн банкнаас баахан зээл аваад л, тэгээд тэрүүгээрээ буцаагаад улсаараа төлүүлчихнэ гэсэн чинь нөгөөдөх нь харамсалтай нь нөгөө арилжааны банк биш гадаадаас бонд босгочихсон, тэгээд бондынх нь төлбөр зайлшгүй төлөгдөх учраас нөгөө сурсан зангаараа банк наах гэсэн нөхдүүд тэгээд баларчхаад ингээд сууж байгаа юм л даа. Банк дампууруулах бол Ардын намын үндсэн хийж чаддаг ажлуудын нэг л дээ.

Тэгээд Жавхлан гуай арай хэтрээд байгаа юм биш үү? Та яасан айхтар улс төржиж байна. Наадахаа, улс төрөө өөр дээрээ хий. Өөрийн чинь 2017 онд батлагдсан тэр өөрийн чинь бланкан дээр батлагдсан, өргөн барьсан тэр хуулиар энэ ард түмний банкиг хэдхэн даргын банк болгосон шүү дээ. 2016 он хүртэл наадах банк чинь 2000 аж ахуйн нэгжид зээл өгдөг ийм жирийн хүн, бизнесмен очоод хэн нэгэн даргын явуулахгүйгээр очоод зээл авдаг байсан банк байсан байхгүй юу даа.

Тэгээд энэ хуулийг өөрөө банканд байсан. Бас юмаа мэдэж байгаа л даа. Яаж луйвардахаа. Тэгэнгүүт тэр тогтоолын төсөл гаргаж байгаад энэ банкиг Хөгжлийн банкиг 40 хүн зээл авдаг банк болгоо биз дээ чи? Дарга нарын банк болгоо биз дээ? Ард түмний банкиг. Тэгээд бүх юмыг л улс төржүүлээд. Та нар энэ сонсголоор байна шүү дээ энэ Хөгжлийн банкиг Ардчилсан нам дээр наана гэвэл ёстой гонжийнжоо, голионы баас. Наадах банк чинь дөнгөж цөөхөн 300 орчим тэрбум төгрөгийн юутай байсан. Хэдэн хувьтай байлаа? Алдагдалтай банк байсан. Найдваргүй зээл 9.9 хувьтай л байсан. Энийг тэгээд

хэд болгосон юм? Та нарын үед л наадах чинь 40-хөн эрх мэдэлтэн, албан тушаалтан тэд нарын компаниуд зээл авдаг банк болгож хувиргаж байгаад л бүгдийг нь хулгайлаа биз дээ? Өөрийнхөө бузрыг өөрсөд дээрээ наацгаа за. Чамаас хариулт авах ч үгүй.

Г.Занданшатар: Асуултад Чимэдийн Хүрэлбаатар сайд хариулна. Энэ асуулт хариулт чинь.

Ч.Хүрэлбаатар: Хэдүүлээ нээх улс төржүүлмээргүй л байна. Улс төржмөөргүй л байна. Яривал ярина шүү дээ ер нь.

Хөгжлийн банк анх байгуулагдсан. Байгуулагдахдаа нэлээд олон талаас нь ярьсан. Нэг иймэрхүү хулгай гараад байдаг юм шүү. Хулгайчдын гар, хөлийг хол байлгах хэрэгтэй гэж ярьж ярьж байгаад Хөгжлийн банк байгуулаад Korea Development Bank буюу Солонгосын Хөгжлийн банкнаас менежментийн баг авчирч тавьсан. Харамсалтай нь үүнийг 12 оны сонгуулийн дараа хөөж явуулсан л даа. Хөөж явуулаад өөрсдийн гарын хүмүүсүүдээ тавьсан. Одоо уншина би. Баримт ярина. 2012 оны 12 сарын 3-ны өдөр Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж гарын үсэг, Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж, Улсын Их Хурлын дарга З.Энхболд, Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг, Ажлын албаны дарга Очиржав гэсэн. Энэ дээр 1 заалтыг нь л уншаад өгье.

1.Засгийн газрын үнэт цаасыг арилжаалах замаар бүрдүүлсэн хөрөнгийн эх үүсвэрээс гэж байгаа юм. Нөгөө 1 аравны тэрбум америк доллар “Чингис” бондоос гэж байгаа юм. Төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх асуудлыг тухай бүр Засгийн газрын хуралдаанаар шийдвэрлэж, Улсын Их Хурлын даргад бичгээр танилцуулж байх гэж. Ийм л зарчмаар явуулж ирсэн. Ингээд сая түрүүн энэ Хөгжлийн банкны захирал залуу тайлбар хэлэхдээ нийтдээ 1.8 тэрбум

америк, 1.8 их наяд төгрөгийн муу зээлийн 1.3 их наяд буюу дийлэнх нь 2012-2016 оны үед бий болжээ гэж хэлж байна. Энэ арай улс төржөөгүй болов уу гэж би бодож байна.

Тэгэхээр Жавхланг буруутгаад байгаа тэр хууль бол зөв болсон юм. Бизнесийн зориулалтаар өгдөг зээлийг тэнд Засгийн газар нь шийдвэрлээд, Их Хурлын дарга нь бичгээр авч танилцаад зөвшөөрлийг нь өгөөд явдаг буруу шүү дээ. Тэгээд мөнгөтэй хүмүүсүүдийн үгээр төлөөний хүмүүсүүдээр орж ирээд, мөнгөтэй хүмүүсүүдийн үг, дуу, хоолой болж энэ зүйлийг буруу тийшээ явуулах гэж оролдож байгаа хүмүүс бий. Их Хурал дотор.

Гэхдээ бид нар энэ дээр улс төржихгүйгээр бодитойгоор асуудлуудаа яриад шийдвэрлээд явах ёстой.

Тийм учраас улс төржиж ярихгүйгээр бодитой зүйлээ л яриад явсан нь зөв. Зөв болгож, хуулиа улс төрчид нь хийдэг. Тэр зээл олгодог, улс төрчид нь зээл олгодог энэ тогтолцоог салгасан тэр 2017 оны тогтолцоог буруутгаад хэрэггүй. Харин ч 1.8 их наяд төгрөгийн чанаргүй зээлийн 1.3 нь улс төрчид буюу Засгийн газар, Их Хурлын дарга 2 ярьж байгаад шийдчихдэг байсныг тэрүүгээрээ өөрчлөөд, харин хаа очиж тэр бизнесийн зарчмаар яг банкны мэргэжлийн хүмүүсүүд нь зээл олгодог энэ тогтолцоо руу шилжүүлэх гэж оролдсон.

Харамсалтай нь тухайн үеийн Хөгжлийн банкны удирдлагуудад ноцтой алдаанууд гаргасан. Гаргасан. Дураараа авирласан. Тэгээд дараа нь тэр бүх буруутанг эргээд улс төрчид рүү чихэх ийм оролдлогыг хийж байгаа. Тэдний гар, хөл нь ч энэ дотор сууж байгаа. Бид нар асуудлуудыг бодитой болгож явахгүй бол эцэст нь буруу, хаана алдаа хийчхэв вэ гэдгээ бид нар олох ийм боломжгүй л болно шүү дээ. Энэ ном бүгдэд нь тараагдаж өгсөн. Би өчигдөр орой авсан, үзсэн. Заримыг нь, дийлэнхийг нь би анх

удаагаа л үзэж байна. Энэ чинь өнөөдөр би заавал яриад байх албагүй л дээ. Энэ олон нийтэд угаасаа бий болно, хүрнэ. Үнэн, худлыг нь ялгаад яриад явна. Энд би, чи гээд тулаад байх шаардлага байхгүй.

Гэхдээ энэ Хөгжлийн банк гэдэг зүйлээсээ бид нар тал талдаа, аль аль улс төрийн хүчин бид нар бүгдээрээ л сургамж авах ёстой. Харин 2017 оны тэр Хөгжлийн банкны тухай хуульд оруулсан Жавхлан тухайн үедээ гишүүн байхад санаачилсан хууль бол энэ том завхрал бүр ноцтой аюул болохоос урьдчилан сэргийлж бас аварсан. Харамсалтай нь тэнд бас эрх мэдлээ хэтрүүлж хэрэглэсэн улс төрчид нь ч бий. Мэргэжлийн ёсоор ажиллах ёстой Хөгжлийн банкны удирдлагын алдаа ч бий.

Харин тэр бүх зүйлийг энэ Жавхлан дээр аваачиж наах гэж байгаа бол энэ харин буруу шүү. Тэгвэл буруу шийдвэрүүд гарна, буруу дүгнэлтүүд явна л гэдгийг хэлье.

Г.Занданшатар: Болдын Жавхлан сайд.

Б.Жавхлан: Пүрэвдорж гишүүнээ одоо нээх сандраад хэрэггүй дээ. Энэ товхимол ийм юм байгаа юм шүү. Энэ яагаад 12-16 он бэ гэхээр. Энэ хооронд яг Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэрүүд, Хөгжлийн банктай холбоотой тэр зээлүүдтэй шууд хутгалдаж гарсан байдаг байхгүй юу. Дандаа чиглэл өгсөн ийм тогтоолууд. Энэнээс хойш Засгийн газар дээр нэг ч тогтоол, ийм зээл, ийм төсөл, хөтөлбөрийг санхүүжүүл гэсэн ийм чиглэл өгсөн юм огт гараагүй юм.

Тийм учраас тэрийг товхимол болгож, та бүхэнд мэдээлэл болгож, үзэхэд бас амар болгож нэг дор ингэж мэдээлэл өгч байгаа юм шүү. Энэнээс хойш бол Засгийн газар дээр гаргасан шийдвэрүүд ерөөсөө огт байхгүй. Тэрүүгээрээ ялгаатай байгаа юм.

Тэр хуулийг 17 онд орсон Хөгжлийн банкны тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлт бол Засгийн газраас өргөн барьсан хууль шүү. Сая Хүрэлбаатар сайд бас буруу хэлчихлээ. Засгийн газраас өргөн барьсан хувилбар дээр Их Хурал ажлын хэсэг гараад явсан. Намайг мэргэжлийн хүн гээд. Би ажлын хэсгийг ахлаад явсан байгаа юм. Тэрнээс би санаачилсан зүйл биш. Ерөнхий концепцын хувьд сая Хүрэлбаатар сайд хэлчихлээ. Их Хурал дээр, Засгийн газар дээр Хөгжлийн банкны зээлийг шийддэг биш, энэ улс төрийн байгууллагаас улс төрийн институтээс ангид болгож, дотоод хяналт шалгалтыг нь сайжруулж, дээрээс нь Хөгжлийн банк 17 оны тэр хуульд өөрчлөлт ортол Засгийн газрын байгууллагыг дотоод аудитаараа л энэ банкиг шалгадаг ийм хязгаарлагдмал ийм битүү тогтолцоотой байсан.

Энийг харин хөндлөнгөөс бие даасан мэргэжлийн байгууллага, Монголбанк шалгадаг болсон. Энэ хуулиар. Харин энэнээс хойш Монголбанкны удаа дараагийн шалгалтаар энэ банкны энэ чанаргүй зээлүүд харин ил болж ингэж гарч ирж байгаа юм шүү. Энэ хуулийн тогтолцооны өөрчлөлтийн үр дүн нь энэ юм байгаа юм.

Харин 16 оноос хойш гарсан энэ чанаргүй зээлүүд дээр завхрал гарсан, Хөгжлийн банкны удирдлагууд дээр алдаа гарсан маш олон зүйлүүд байгаа. Харин энэ дээр бид одоо манай Засгийн газар харин ч хүний, өөрийн гэхгүй энэ дээр хариуцлага тооцож, энэ дээр хатуу чанга ажиллаж байгаа. Ажиллаж байгаа.

Тийм ч учраас өнөөдрийн үр дүнгүүд гарч байгаа юм. Харамсалтай нь энэ 1.8 их наядын 1.5 их наядыг нь чанаргүй зээлийг үүсгэсэн энэ товхимол дотор байгаа энэ шийдвэрүүдэд оролцсон. Тухайн үед тэр бодлогын зөвлөл гэж байгаа юм. Бодлогын зөвлөл юу байх вэ дээ. Бондын зарцуулалтыг шийддэг байсан. Тэр зөвлөл дээр ямар ч хариуцлага яригдахгүй байгаа шиг өнөөдөр. Ямар ч

асуудал яригдахгүй байгаа. Өнөөдөр тэр 1.3 их наяд хэрвээ төлөгдчихсөн бол, хэвийн байсан бол өнөөдрийн Хөгжлийн банкны энэ хүндрэл, ирэх жил гарах болзошгүй бид нарын давж туулах гэж зовж байгаа, зүдэрч байгаа, хамаг хүчээ тавьж байгаа энэ асуудлууд, энэ эрсдэлүүд байхгүй байх байсан. Тэгээд ийм л учиртай юм.

Тэгэхээр одоо бүгдээрээ харыг нь хараар ялгаад, цагааныг нь цагаанаар ялгаад, тос, усыг нь ялгаад, одоо энэ банкны цаана, энэ банкны асуудал, эрсдэлтэй асуудлын цаана энэ олон улсад Монгол Улсын л нэр гарна. Ёстой нээрээ та бүхний хэлдгээр тэр намын засаг, энэ намын засаг гэж харахгүй. Монгол Улсын Хөгжлийн банк л гэж харна.

Тийм учраас энийгээ сайхан ярьж аваад бүгдээрээ энэ банкаа авраад, энэ чанаргүй зээлүүдээ төлүүлээд, нэг ил яриад ингээд явах нь зүйтэй.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Асуулт, үг нэг явсан. Одоо Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр Засгийн газрын гишүүнээс асуулт асууна. Мэтгэлцээний цаг эхэлж байна. Асуулт, хариулт 20 минут үргэлжилнэ. Шууд микрофон нь нээлттэй явчих нь байна шүү дээ. Нийт 20 минутад багтаагаад л асуултаа хариулъя. Ингээд Баттөмөрийн Энхбаяр гишүүн.

Б.Энхбаяр: Баярлалаа. Улсын Их Хурлын тухай хуулийн 109.12, 109.13 дахь заалтад зааснаар энэ асуулттай холбоотойгоор иргэдээс ирүүлсэн асуултыг юуны түрүүнд үг, үсэг гээхгүйгээр асуух ёстой юм байна. Хуульчлагдчихсан. Тийм учраас би энэ албан ёсоор Тамгын газраас албажуулсан энэ иргэдээс ирүүлсэн асуултыг эхлээд асууя. Сангийн сайдаас болон Хөгжлийн банкны захирал.

Нэгдүгээрт, иргэн Лхагвасүрэнгээс Хөгжлийн банкнаас төлөх гадаадын зээл тусламж, бондын төлбөрийн хэмжээ хэд байгаа вэ? Хэдийд төлөхөөр төлөвлөгдсөн бэ? Иргэн Сарантуяа, Хөгжлийн банкнаас зээл олгохдоо Банкны тухай хуулийн холбогдох заалтыг баримтлан олгосон уу? Хөгжлийн банкны тухай хуулийн дагуу олгосон уу гэсэн асуулт байна.

Г.Занданшатар: Шууд хариулт явахаас өмнө цагаас хасчхаарай. Энэ Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу 109.11-т заасны дагуу D-parliament цахим хэлэлцүүлгийн платформ дээр Ерөнхий сайдын мэдээллийг 7 хоногийн өмнө байршуулж байгаа. Энэ 7 хоногийн хугацаанд иргэдээс мэдээлэлтэй холбогдуулж ирсэн асуулт, саналуудыг энэ 2 бүлгийн төлөөлөл, 2 намын бүлгийн гишүүдийн төлөөлөл Засгийн газрын гишүүдээс асууж энэнтэй холбогдуулж мэтгэлцээн өрнүүлэх ийм шинэ дэгтэй байгаа юм. Тэгээд ард иргэдийн санал бодол дээр тулгуурлаж асуулт, хариулт явж байгаа гэдгийг би өмнө нь хэлэхээ орхигдуулсан байна. Ингээд цаг явлаа. Болдын Жавхлан сайд.

Б.Жавхлан: Энхбаяр гишүүний асуултад хариулъя. Ирэх жил 23 оны 9 сарын 25-нд 500 сая долларын “Евро” бонд. Энэ бол Хөгжлийн банкны бие даан гаргасан бонд. Засгийн газрын баталгаагүй. 23 оны 12 сарын 25-нд 2013 онд гаргасан 30 тэрбум иений “Самурай” бондын төлөх хугацаа болж байгаа юм. Энэ “Самурай” бонд нь бол Засгийн газрын баталгаагүй юм байгаа юм.

Тэгэхээр бид сүүлийн жил гаруйн хугацаанд одоо 777 тэрбум төгрөг, 800-гаад тэрбум төгрөгийн зээл төлүүлчээд байна. Бэлэн мөнгөөр. Энэ маань Хөгжлийн банк өөрөө бие дааж, ядаж “Самурай” бондоо төлчих хэмжээнд хүрчихсэн. Үзүүлэлтүүд ч сайжирсан байгаа. Тодорхой үр дүн гарсан гэсэн үг.

Тэгэхээр одоо ямар нэг Засгийн газрын баталгаа эрсдэлд орохгүйгээр, одоо төсөвт хүндрэл учрахгүйгээр харин Төв банкны валютын нөөц дээр бас жоохон ялгаатай л байж таараа. Мэдээж энэ чинь 200 гаран сая доллар болно.

Гэхдээ бид энийг хугацаанаас нь өмнө ч төлөх ийм чадвартай болчихсон байгаа. 6 сараас эхлээд бид “Самурай” бондыг хугацаанаас нь өмнө төлбө гээд хөрөнгийн зах зээл дээр бонд holder-уудтай саналууд тавьсан. Харин эерэг хандлага гэвэл юу вэ гэвэл Засгийн газарт итгэж байна. Монголын Засгийн газарт. Хугацаанаас нь өмнө бид нар татах шаардлагагүй байна. Хугацааг нь хүртэл бид нар бондуудаа барина гээд бидэнд ийм хариунууд ирсэн. Гэхдээ наана нь бид нар дуудаж төлөхөд бэлэн болсон.

“Евро” бонд бол 9 сарын 25-нд гэдгийг би дахин хэлье. Энэндээ одооноос бид бэлтгэл ажилдаа ороод байгаа. Зээл бол энэ Хөгжлийн банк маань өөрөө Хөгжлийн банкны тухай хууль гэдэг бие даасан ийм хуультай ийм институт.

Тэгэхээр Хөгжлийн банктай холбоотой бүхий л үйл ажиллагаа, зээл, дотоод засаглал, шийдвэр гаргах процесс, Засгийн газартай харьцах шугам энэ бүх зүйл энэ хуулиараа зохицуулагдаад явдаг. Банкны тухай хууль дээрээс бол Хөгжлийн банкны үйл ажиллагааг зохицуулах зүйл байхгүй.

Г.Занданшатар: Хоёр дахь асуулт Мандуулаас асуусан. Мандуул наадах чинь асаалттай байгаад байна шүү дээ.

Н.Мандуул: Энхбаяр гишүүний асуултад хариулъя. 2011 онд Хөгжлийн банкныг байгуулахдаа Хөгжлийн банкны тухай хуулийг баталсан байдаг. Түүний дараа 2017 онд Хөгжлийн банкны тухай хуулийн шинэчлэн найруулгыг баталсан. Түүгээр гол бидний банкны барих ёстой хууль маань Хөгжлийн банкны тухай хууль байгаа. Түүн дээр байгаа заалтаар энэ хуулиар зохицуулаагүй бусад

асуудлыг Банкны тухай хуулиар зохицуулна гэсэн тийм заалтын дагуу банк үйл ажиллагаагаа явуулж байна.

Үүнээс гадна Хөгжлийн банканд зориулаад 2017 онд Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаал актив ангилах, активын эрсдэлийн сан байгуулах, зарцуулах тухай журмын дагуу Хөгжлийн банк зээлийн активаа хэвийн, чанаргүй гэсэн ангиллаар ангилаад явж байгаа. Баярлалаа.

Б.Энхбаяр: Иргэн Нандингэрэл. Чанаргүй зээлийн эргэн төлөлт хэдэн хувьтай байгаа вэ? Иргэн Гэрэлт-Од. Чанаргүй зээлийг ямар хугацаанд хэрхэн барагдуулах талаар ямар арга хэмжээ авч, ажиллаж байгаа вэ? гэсэн асуулт асуусан байна.

Н.Мандуул: Асуултад хариулъя. Чанаргүй зээл өнгөрсөн оны 12 сард Монголбанкны шалгалт албажиж, Хөгжлийн банкны чанаргүй зээлийг 57 хувьтай байна гэсэн дүгнэлт гаргаж, эрсдэлийн сан байгуулах акт тогтоосон байдаг. Бид түүн дээр бас түүний дагуу он гарснаас хойш ажиллаад эргэн төлөлтийг бол одоогийн байдлаар 780 тэрбум гараад явж байна. Он гарахад эргэн төлөлтийг 1 их наяд төгрөгт хүргэх зорилготой. Мөн сайдын илтгэлд дурдагдсан банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцаа үзүүлэлт маань бол бараг тэг- рүү дөхөж очсон байсан. Монголбанкны тавьдаг шаардлагаар бол банк дор хаяж 12 хувьтай ийм үзүүлэлттэй байх ёстой байсан.

Тэгэхээр бидний зорилго оны эцэс гэхэд өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцаагаа 20 хувьд хүргэх зорилготой байна. Чанаргүй зээлийн хувьд бол 50 гаран хувьтай явж байна. Тэгэхдээ бид бас оны эцсээр олон улсын аудитын байгууллагаар санхүүгийн аудит хийлгэх ёстой. Түүгээр чанаргүй зээлийн харьцаа маань бас илүү нарийвчлан гаргах болно. Бидний зорилго бол ямар ч байсан гэсэн оны эцэс гэхэд 40 хувиас доош бууруулах, тэгээд он гараад бид үүнийгээ 20 хувиас

доош буулгах тийм зорилго тавин ажиллаж байна.

Б.Энхбаяр: Иргэн Галбадрах шинээр хөрөнгө оруулалтын гадаадын эх үүсвэрүүд татан төвлөрүүлэх тал дээр ямар байр суурьтай байгаа вэ? Иргэн Отгонбаатар Хөгжлийн банк өөрөө эрсдэлээ удирдах чадвартай болсон уу? Цаашдаа Монгол улсын хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдийг Хөгжлийн банкны санхүүжилтээр төлөвлөж, төлөвлөн хэрэгжүүлэх боломжтой байна уу гэсэн асуулт асуусан байна.

Г.Занданшатар: Болдын Жавхлан сайд.

Б.Жавхлан: Энхбаяр гишүүний хэлсэн иргэдийн асуултад хариулъя. Одоогоор бол юун шинэ хөрөнгө оруулалтын эх үүсвэр манатай л байгаа юм. Одоо бид чинь үндсэндээ дампуурчихсан банкны үзүүлэлтүүдтэй явж ирсэн учраас сүүлийн жил гаруй хугацаанд. Тийм үзүүлэлттэй банканд хэн ч, хаанаас ч, ямар ч эх үүсвэр өгөхгүй.

Тийм учраас одоохондоо бид ерөөсөө л өр барагдуулах алба л ажиллуулж байгаа юм. Өр барагдуулах алба нь амжилттай ажиллаад, үр дүн гараад, үзүүлэлтүүд сайжраад, тэгээд нэг хүнээс эх үүсвэр татах, эх үүсвэр асуух хэмжээнд очоод ирэх цагт ийм боломжууд нээгдэнэ гэж ингэж харж байгаа.

Хөгжлийн банкны одоогийн хуулиар бол Хөгжлийн банк бие дааж, шийдвэр гаргах, бие дааж эрсдэлээ удирдах, бие дааж шийдвэр гаргасныхаа төлөө өөрсдөө хариуцлага хүлээх ийм хуулийн тогтолцоотой ингэж явж байгаа юм. Тийм учраас одоохондоо мөн л энэ эрсдэл удирдана гэдэг маань өмнө нь гарсан энэ чанаргүй зээлүүдийг төлүүлдэг л ийм эрсдэлээ удирдаад явж байгаа юм.

Тэгэхээр одоо энд Хөгжлийн банкны дараагийн хувь заяаг бас одооноос бид ярих ёстой болж ирж байгаа юм. Бид

чанаргүй зээлээ төлөвлөөд, ирэх жилээс Хөгжлийн банкны үзүүлэлтүүд ер нь их боломжийн болно. Өөрөөр хэлбэл дахин шинэ гарааны түвшинд очно л гэсэн үг. Тэрнээс цааш харин энэ засаглалыг нь сайжруулж, шинэ түвшинд гаргаж, дахиж ийм алдаа гаргахгүй байх, энэ бол Засгийн газрын маш том зорилтууд бас их том сорилт болно. Сорилт болно. Энийг бид одооноос бодож байх ёстой. Одоо бол нөгөө чанаргүй зээлүүд дотроо дарагдаад, энэ дараагийн хувь заяаны асуудал бас 2, 3-т яригдаад байгаа юм. Тэгэхдээ энийг бол бид өнөөдрөөс онцгой анхаарч ингэж явж байгаа.

Хөрөнгө оруулалтууд одоо тэгээд банк ирэх жилийнхээ хүндрэлүүдийг даваад, тэгээд үзүүлэлтүүд нь сайжраад ирэхийн цагт мэдээж энэ Шинэ сэргэлтийн бодлого болон ойрын хугацааны, ялангуяа яг цэвэр хөгжлийн төслүүд, ялангуяа дэд бүтцийн хөгжлийн зээлүүдийг одоо санхүүжүүлэх, тэрэнд хамтарч оролцох, тухайлбал, “Эрдэнэс Тавагтолгой”, “Тавантолгойн дулааны цахилгаан станц”, Дорноговийн нефт боловсруулах үйлдвэр, нефт боловсруулах үйлдвэрийн дамжуулах хоолой гэх мэт ийм томоохон хөгжлийн зээлүүд дээр бол Хөгжлийн банк зайлшгүй оролцоод явах ийм шаардлага, хэрэгцээ байгаа. Гэхдээ тэр эрийн цээнд хүрнэ гэдэг нь тэр хэмжээнд одоохондоо бол ярихад илүү эрт байна. Энэ хэдэн чанаргүй зээлүүдтэйгээ ноцолдох л ойрын жилийн хугацааны зорилго байна.

Б.Энхбаяр: Надад ирүүлсэн иргэдийн асуултыг би асууж дууслаа. Одоо өөрөө асууна. Тэгэхээр Хөгжлийн банкны Түр хороог миний бие саяхнаас даргалж байгаа. Тийм учраас өнөөдрийн 1 цаг, 2 цагийн хооронд энэ асуудал угаасаа ярьж амжих ч үгүй, багтах ч үгүй. Нэлээн нухацтай авч үзнэ гэж бодож байгаа. Улсын Их Хурлын Түр хороон дээр дарга болоод би бас хэлсэн. Хэлсэн байгаа. Та бүхэн уйдаагүй бол би уйдаагүй гээд хэлчихсэн байгаа. Энэ юу гэсэн үг вэ гэхээр би ер нь 1 сарын хугацаанд ард

түмэнд хэвлэл мэдээллээр дамжуулж ил тод сонсгол хийе гэсэн бодолтой байгаа. Энэтэй холбоотой бүх албан тушаалтнуудыг дуудаж асууя гэсэн бодолтой байгаа. Энэ дотор сая жишээлбэл гишүүд бас талцаад байна. 2012 онд байгуулагдсан энэ Бондын зөвлөл гээд байгаа юм. Энэ зөвлөлийн бүх гишүүдийг дуудаж асууна гэсэн бодолтой байгаа. Энийг байгуулсан Монгол Улсын 2 ч Ерөнхийлөгч байна. Энэ хүмүүсийг дуудаж байгаад асууна гэж, гэрчээр дуудан байцаана гэсэн бодолтой байгаа. Монгол Улсын Сангийн сайдаар ажиллаж байсан хүмүүсийг дуудаж мөн асууна гэсэн бодолтой байгаа.

Мөн холбогдох бүх албан тушаалтнуудыг бас дуудна. Хилээр гараад явчихдаг зарим нэг хүн байгаа. Хүмүүсээ зугтаалгадаг, сурцтай. Энэ гарч явуулахгүй байх талд нь бас анхаарах шаардлага үүсэх байх. Өнөөдрийн тухайд тодорхой хувь хүн болон хуулийн этгээд рүү чиглэсэн асуулт би асуухгүй.

Яагаад гэхээр Түр хорооны хүрээнд энэ асуудлыг нотлох баримтын хүрээнд сайтар шинжлэн судалсны үндсэн дээр зөвхөн нотлох баримтын хүрээнд асуудлыг ярина гэсэн ийм бодолтой байгаа. Энэний гол агуулга бол энэ дээр бас улс төржиж, хүн хэлмэгдүүлж болохгүй.

Нөгөө талаасаа бас ял завшуулж болохгүй гэсэн шударга ёсны ийм зарчмын үүднээс хандана гэсэн ийм итгэл үнэмшилтэй байгаа.

Эхний асуудал энэ хуулийн байгууллагаас Улсын Ерөнхий прокурорын орлогч болон Авлигатай тэмцэх газрын дэд дарга нараас асууя. 2016 оны Хөгжлийн банкны шалгалтын дүнгээр нэлээн олон асуудлууд, зөрчил дутагдлууд бас явж байсан. Би яг хувилж бол мэдэхгүй байна. Тэгэхдээ ер нь 10 хүрэхгүй хувьд нь асуудал яригдсан байх. Хуулийн байгууллага дээр. Нэлээн гол асуудлууд бол хэл сураггүй болсон.

Дарагдсан, хөөн хэлэлцэх хугацаагаар зарим нь цагаадсан, заримыг нь шалгаж байна гэж барьсан. Ийм зүйл байдаг.

Тэгэхээр энэ өнөөдрийн мэдээлэлд гол бас хөндөгдөөд байгаа асуудал бол энэ найдваргүй болчихсон 1.3 их наяд төгрөгийн зээлийн 75 хувь нь үндсэндээ энэ Бондын зөвлөлтэй холбоотой гэдэг асуудал яригдаад байгаа юм. Тэгээд энэ Бондын зөвлөлийг ер нь шалгасан уу? Шалгаж байгаа юу? 16 оны шалгалтын дүнгээр хууль хяналтын байгууллагад шилжүүлэхэд шалгаагүй шүү. Тэгэхээр эхний асуудал бол та бүхэн энэ зүйлүүдийг шалгасан уу? Энэ зөвлөлд байгаа хүмүүсийг ер нь дуудаж асууж байцаасан асуудал байгаа юу, үгүй юу гэдгийг би асуух гэж байгаа юм.

Хоёрдугаарт би Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт бас явуулчихсан байгаа. Энэ Бондын зөвлөлийн бүх хуралдааны тэмдэглэлийг Түр хороонд ирүүл гэдэг бичиг явуулчихсан байгаа. Энэ хуралдааны тэмдэглэлүүдийг бүгдийг нь ирүүлээрэй. Бүгдийг нь ирүүлээрэй. Энэ хуралдааны тэмдэглэл дээр энэ хүмүүс яаж тэр шийдвэрээ гаргаж байсан юм? Юу ярьж байсан юм гэдгийг би ард иргэдэд, олон нийтэд ил болох сонирхолтой байгаа. Нээлттэй. Ийм эхний асуулт байна.

Г.Занданшатар: 80, Ерөнхий прокурорын орлогч Максимын Чинбат.

М.Чинбат: Энхбаяр гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр энэ Хөгжлийн банкны эрх бүхий албан тушаалтнуудтай холбоотой хэрэг би сая түрүүнд, ер нь бол одоо яг ажиллагаанд 26 хэрэг шалгагдаж байна. Мөрдөн байцаалтын 2 хэрэг прокурорын хяналтад орж ирсэн. Энэ хэрэг дотор бол 2012-20 оны хооронд нэр бүхий аж ахуйн нэгжүүдэд зээл олгохдоо Хөгжлийн банкны тухай хууль, Хөгжлийн банкны зээлийн бодлого, зээлийн үйл ажиллагааны журмыг зөрчиж, бусдад зээл олгосон. Энэ байж болзошгүй гэсэн

үндэслэлээр энэ хэрэг бас шалгагдаж байна.

Мөн энэ дотор энэ Бондын зөвлөлийн асуудлын хэмжээнд яригдахаар энэ “Гудамж” төслийн хүрээнд нэмэлт санхүүжилт олгож, аж ахуйн нэгжүүдэд нэмэлт гэрээ байгуулж, санхүүжилт олгосон. Үндэслэлгүйгээр энэ гэрээний үнийн дүнг нэмэгдүүлж, бусдад давуу байдал олгосон байж болзошгүй гэдэг хэрэг, Хөгжлийн банкны эрх бүхий албан тушаалтнууд “Чингис”, “Самурай” бондын эх үүсвэр болох гадаад валютын ханшийн эрсдэлээс хамгаалах үйл ажиллагаа явуулаагүйн улмаас их хэмжээний хохирол учруулсан, болзошгүй гэсэн ийм бие даасан ийм үндэслэлээр хэрэг нээсэн энэ хэргүүд бол шалгагдаж байгаа.

Тийм учраас бол Мөрдөн шалгах ажиллагааны холбогдох шатанд нь бол зайлшгүй асуух, тодруулах гэрч бүхий зайлшгүй энэ улсуудыг нь бол Авлигатай тэмцэх газар шалгалтын ажиллагаа явуулж байгаа болно.

Г.Занданшатар: Авлигатай тэмцэх газрын Тэргүүн дэд дарга Азжаргал. 1 дүгээр. Индрийн 1 номерын микрофон.

Г.Азжаргал: Асуултад хариулъя. Авлигатай тэмцэх газраас яг таны асуусан энэ хэрэг үйлдэл дээр бол 43 хэрэг бүртгэлтийн хэрэг мөрдөн шалгах ажиллагаа явуулаад 15 хэрэгт нь эрүүгийн хэрэг үүсгээд, 26 иргэд нь хэрэг бүртгэл дээр мөрдөн шалгах ажиллагаа явагдаж байна. Ингээд саяын энэ 15 хэрэгт эрүүгийн хэрэг дээр 2 хэргийг нь нэгтгээд, 15 хэрэг дээр нь 2022 оны 11 дүгээр сарын 3-ны өдөр шүүхэд шилжүүлэх саналтай прокурор хяналтад шилжүүлсэн байна.

Б.Энхбаяр: Хоёр дахь асуулт нь Хөгжлийн банкны захирал Мандуул захирлаас асуулт байна. Энэ Хөгжлийн банкны ер нь шалгалтын дүнгүүд бол олон нийтэд ерөөсөө урьд нь ил тод ингэж бас

болохгүй ийм үйлдлүүд бас байсан. Яг одоо энэ Хөгжлийн банкны асуудал ингэж өндөр авахад та шүгэл үлээсэн. Миний санаж байгаагаар энэ оны 1 сард үлээсэн шиг санаж байна. Ингээд энэ Хөгжлийн банк чинь юу болчхов, яачив, ийчив гэдэг олон нийтийн анхааралд орж өнөөдөр Улсын Их Хурал, Засгийн газар, хууль хяналтын байгууллага цулаараа бараг л өр барагдуулах алба шиг ажиллаж байгаа. Ард иргэд маань энд хэвлэл мэдээллийн байгууллагууд их олноороо хүч түрж дэмжлэг үзүүлсэн. Тэгэхээр танаас би шууд нэг ийм асуулт байгаа юм. Танд одоо ямар нэгэн яг одоо энэ өр барагдуулах ажлыг яг гардан байлдаанд нөгөө хүнд гаруудтай нүүр тулж байгаа хүн бол та л байгаад байна л даа. Тэгэхээр ямар нэг хүндрэл байна уу? Дарамт шахалт байна уу? Улс төрийн дарамт шахалт байна уу? Тэр дотроо? Өөрөөр хэлбэл улс төрийн албан тушаал хашиж байгаа ийм хүмүүсээс таныг ингэ, тэг гэж байгаа ийм ямарваа нэгэн ийм дарамт шахалт байна уу гэдэг ийм асуулт байна.

Н.Мандуул: Асуултад хариулъя. Яах вэ, ажил хариуцаад хариуцлага хүлээж байгаа хүний хувьд зовлон нээх тоочоод баймааргүй байна. Гэхдээ мэдээж хүндрэл байлгүй яах вэ энэ. Яг үнэндээ манай банкны гүйцэтгэх удирдлага ер нь мэргэшсэн.../минут дуусав./

Г.Занданшатар: 20 минут дууссан уу? Энийг гүйцээгээд хариулчихвал. Асуулт, хариулттайгаа нэг. Тэр яах вэ, гүйцээгээд дуусгачих 80. 20 минут дууссан уу? Одоо Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын дэд дарга Салдангийн Одонтуяа. Засгийн газрын гишүүнээс асуулт асууна.

С.Одонтуяа: Тэгэхээр юуны өмнө бас энэ Улсын Их Хурлын дэгд өөрчлөлт ороод ийм мэтгэлцээний гэдэг ч юм уу, бас ийм иргэдээс ирж байгаа асуултыг оруулдаг, бүлгүүдээс гишүүд асуултдаа хариулж мэтгэлцэх ийм боломж олгож байгаа энэ дэг бол бас их зүгээр дэг байна.

Дэвшилттэй. Сая нөгөө e-parliament-аас, иргэдээс ирсэн асуултыг бас нэлээдийг нь Энхбаяр гишүүн асуучихлаа. Тэгэхдээ бас дутуу хариулсан. Би бас гүйцээгээд хэд хэдэн зүйлийг асууя. Иргэдээс ирсэн асуултыг, өөрийнхөө бас энэ бүлгийн гишүүдээс ирсэн асуулт, бас надад энэ интернэтээр ирсэн нэлээд олон асуулт байна. Энийг асууя.

Нэгдүгээрт, сая Сангийн сайдын энэ тайланг сонслоо. Тэгээд таны тайлан ерөөсөө дандаа харь гаригаас ирсэн юм шиг л тайлан байх юм. Өнгөрсөн 6 жил, бүтэн цикл шүү дээ. Их Хурлын 4 жилийн бүтэн цикл, дахиад 2 жилийн цикл. 14-15, 16 онд Ардчилсан намтай хамтарсан ингээд нийлэх юм бол 8 жилийн цикл байгаа байхгүй юу. Энэ 8 жил өнгөрөхөд яагаад ерөөсөө энэ асуудлууд ер хийгдэхгүй байж байгаад өнөөдөр гэнэт ингээд бүх бурууг нь Алтанхуяг гэдэг хүн рүү чихчих вэ? Энэ хүн чинь бүр 8 жилийн өмнө ажлаа өгчихсөн хүн шүү дээ.

Тэгэхээр ийм харь гаргийн юм ярьж болохгүй. Одоо Их Хуралд би мэднэ л дээ. Монгол Ардын нам дотор сангийн асуудал улс орны эдийн засгийг хариуцдаг хэдхэн л хүн байдаг юм. 3, 4-хөн л хүн байдаг шүү дээ. Энэ хэд чинь л Сангийн яам, Төсвийн байнгын хороо ингээд л энийгээ ээлжлээд л дарга болоод л явдаг байхгүй юу.

Тэгэхээр энэ тэнгэрээс буусан юм шиг юм битгий ярь. Дандаа тэгнэ, ингэнэ гэсэн ирээдүй цаг дээр ярих юм. Та нар ямар мөрийн хөтөлбөр ярьж байгаа биш. Дээрээс нь 1 ч хүнд хариуцлага тооцсон талаар ярьсангүй. Энийг иргэд хүлээж байгаа. Тэгээд түрүүн Пүрэвдорж хэлчихлээ шүү дээ. Монгол Ардын намын үед ерөөсөө банкнууд дампуурдаг. Санаатайгаар. Дээрээс нь хадгаламж, зээлийн хоршоод бүгд дампуурдаг. Өчигдөр тэр Анод банкны хүмүүсийн live явж байгаа юм чинь л ерөөсөө Монгол Улсын л байж байгаа царай шүү дээ.

Тийм учраас энэ бүхэл бүтэн 6 жил 65-уулаа байчхаад яагаад энэ асуудлыг ийм хүртэл нь явуулчихсан юм бэ гэдэг нэгдүгээр асуулт. Энэ 6 жил юу хийчихсэн юм бэ? Яагаад энэ асуудлыг хэлсэнгүй вэ гээд. Дээрээс нь би Ардчилсан намынхныг гүтгэлээ гээд байх юм. Би энэ нээлттэй сонсголын чинь талаар 2 тоо асуух гэсэн юм.

Нэгдүгээрт ингэж байгаа юм. Энэ нээлттэй сонсгол чинь 3 сарын 8-нд болсон. Банкны гол үүрэг ерөөсөө гадаадаас бага хүүтэй бонд босгох. Энэ бол Хөгжлийн банкны гол үүрэг. Тэгэхээр Ардчилсан намын үед Ардчилсан нам энэ үүргээ маш сайн биелүүлж байсан байгаа байхгүй юу. Энэ бонд босгож байгаа хэлбэр. Монгол Ардын намын үед энэ чинь өөрөө маш багасчхаж байгаа. Энийг би юу хэлэх гэж байна гэхээр ерөөсөө л нөгөө ард түмнээ шулдаг, татвар төлөгчдийг шулдаг ийм л юман дээр та нар ажиллаж байгаа.

Дээрээс нь би нэг тоо зөрүүтэй байгаа. Би энийг асуух гээд байгаа юм. Энэ юу вэ гэхээр Ардчилсан намын үед энэ чанаргүй зээлийн чинь тоог нь нээлттэй сонсгол дээр 6 хувь, 5 хувь, 12 хувь, 9 хувь гээд. 12 болоод ирэнгүүт банк нь сайн ажиллаад, 9 хувь руу буулгасан байгаа. Гэтэл Монгол Ардын намын үед, энэ Ардчилсан намын үед яагаад энэ чанаргүй зээл юм гайгүй байсан юм бэ гэхээр 5 жилийн хугацаанд нэг л даргатай байсан байгаа байхгүй юу. Удирдлагын тогтвортой байдал. Монгол Ардын намын үед 5 жилийн дотор 5 дарга солигдсон байна. Тэгэнгүүтээ 8 хувь, 10 хувь, 19 хувь, 26 хувь. Сүүлдээ бүр энэ Мөнхсүх гээд даргын үед хувьд 28 хувь болоод, дараа нь 29 хувь болоод нэмэгдэж байгаа юм. Энэ тоо нь яагаад энэ Монголбанкны тоотойгоо зөрөөд байгаа юм бэ гэдгийг би асуумаар байгаа юм.

Монголбанк бол энэ дээр та нараас гаргасан тэр Хөгжлийн банкны чинь дүгнэлтээс дандаа 2 дахин их алдагдал байна гэдгийг гаргаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ тоо яагаад зөрөөд байдаг юм бэ? Монголбанк, Хөгжлийн банк хоёрын тоо нийлж болдоггүй юм уу гэдэг энэ асуултыг би та нарын энэ сонсголын чинь дүнгээс асуух гээд байгаа юм.

Хоёрдугаарт, энэ мөнгө босгох асуудал дээр үнэхээр Ардчилсан нам бол хангалттай сайн ажиллаж байсан. Тэгээд дараагийн асуудал бол зээлийн эргэн төлөлт байгаа. Тэгэхээр арилжааны банкнууд бол бүгд ерөнхийдөө 10 хувьтай л байгаад байна л даа. Тэгэхээр сая энэ төрийн банкнууд чинь яагаад ийм муу байдаг юм бэ гэхээр ард иргэд хэлж л байгаа шүү дээ. Энэ чинь нөгөө улс төрчид нь оролцоод л, тэгээд л чанаргүй зээл өөрсдөө аваад л ингээд л энэ банкиг дампууруулдаг гээд.

Тэгэхээр сая энэ Монголбанкны чинь тоогоор 57 хувь чанаргүй зээл гэсэн хэр нь таны сая илтгэлд 75 хувь гэж нэг уншигдах болох юм. Тэгэхээр энэ одоо үнэхээр чанаргүй зээл нь 75 хувь юм уу, эсвэл би буруу сонсчхов уу? Энийг хариулж өгмөөр байна. Тэгээд бусад банкнууд чинь нөгөө өр барагдуулах албатай байдаг шүү дээ. Тэгээд зүгээр аж ахуйн нэгжүүдээ очоод шууд зүгээр бүх юмыг нь хаагаад дээрэмдээд авчихдаггүй шүү дээ. Хугацаа өгдөг, тусалдаг, зөвлөн туслах үйлчилгээ дэмждэг, тодорхой хэмжээгээр эргэлтийн зээл дутвал өгдөг, ингээд хамтарч ажиллаж байж зээлийг нь төлүүлдэг байхгүй юу.

Тэгэхээр Хөгжлийн банкин дээр энэ зээл төлөгдөх асуудал чинь өр барагдуулах албыг чинь АТГ хийж байгаа байхгүй юу. АТГ чинь уг нь бас энэ дээр их ингэж цаг заваа зараад байх ёсгүй юм байгаа шүү дээ. Уг нь энэ эдийн засгийнхаа арга барилаар энэ банк чинь өөрөө энэ өр барагдуулах албатай. Алба нь ажиллаад энэ бүр чанаргүй зээл болохоос нь өмнө урьдчилан сэргийлээд, дэмжээд ингэж ажиллах ёстой байсан юм. Тэгээд та нар яагаад бүр энэ хүртэл нь тулгачхав гэдгийг асуумаар байна. Нэг асуулт бол энэ 2017 оны таны өргөн

барьсан хуулийг барьснаас болоод л энэ хамаг замбараагаа алдчихлаа гэж манай бүлгийнхэн ихэнх нь, дийлэнх нь түрүүн асуултдаа яриад байна л даа. Гэтэл Хүрэлбаатар гишүүн энэ бол зөв гэж.

Тэгэхээр одоо та энэ асуудал дээр саналаа хэлээч. Эргээд харахад энэ хууль чинь ер нь зөв юм уу, буруу юм уу? Буруу бол эртхэн залруулах хэрэгтэй. Ийм Хөгжлийн банкаа 50, 60 хувийг нь чанаргүй зээл рүү оруулчихаад бид нар тайван сууж чадахгүй байна шүү дээ. Шаардлагатай гэвэл Их Хурал дахиад бид нар хяная л даа. Бид нар оролцъё. Энэ чинь бас эргээд л төсвийн мөнгөөр л аягүй бол энэ зээлүүд чинь төлөгдөнө.

Мандуулаас нэг асуулт асууя. 2016 оны 12 сарын 30-нд Улсын Их Хурлын тогтоол гараад Хөгжлийн банкны энэ эдийн засгийн чадавхыг дээшлүүлэх зорилгоор “Чингис” бондын юуг шууд бүр тэглээд хаасан байгаа гэж би бол ойлгодог.

Тэгэхээр энэ танай банкин дээр “Чингис” бондтой холбоотой өр, төлбөр байдаг юм уу? Нөгөө 888 төсөл гээд байдаг. Тэрэнтэй холбоотой төлөгдөөгүй зээл байдаг юм уу? Энэ асуултуудыг асууя.

Б.Жавхлан: Одонтуяа даргын асуултад хариулж эхэлье. Түрүүний миний уншсан мэдээлэл дотор тэнгэрийн юм юу байх вэ. Энэ ийм л юм байгаа юм. Та яагаад сүүлийн 6 жил ерөөсөө яриагүй юм бэ гэж. Харин тийм, бид нар яриагүй нь алдаа болчихжээ. Яагаад гэвэл бид нар улс төржүүлээгүй байхгүй юу. Одоо нүүр тулчихсан байгаа, энэ хүндэрчихсэн байгаа нөхцөл байдалтайгаа л бид ноцолдоод нээх улс төржүүлэе гэж бодоогүй юм.

Гэтэл өнөөдөр бид нар энэ түвшинд тайлагнахаас өөр аргагүй болж ирж байна. Үнэн, бодит байгааг нь хар цагаанаар нь ялгаад, тос, усаар нь ялгаад олон нийтэд мэдээлэл өгөхөөс өөр аргагүй. Бондын

асуудал яригддаг, гадаад өр зээлийн асуудал яригддаг. Па пэ болоод сөрөг хүчин маань гэнэт жинхэнэ тэнгэрээс унаад ирчихсэн юм шиг гэнэт гайхаад эхэлдэг.

Тэгэхэд чинь бид нар улс төржүүлээгүй шүү дээ. Хөгжлийн банкны гэнэт ийм чанаргүй зээлүүд гарахаар па пэ болоод л явчихдаг. Анх удаа сонслоо, хаанаас юун жинхэнэ тэнгэрийн тоо гараад ирэв ээ гээд. Тэр тэнгэрийн тоонууд дотор чинь энэ ном дээр байгаа асуудлууд л байгаа юм. Би тэгээд таны асуултууд чинь бөөнд нь хариулж байгаа учраас жоохон дараалалгүй, урд хойно нь би агуулгаар нь холбоод яриад явчихъя. 17 онд болсон Хөгжлийн банкны нэмэлт, өөрчлөлт байгаа юм. Засгийн газар өргөн барьсан. Засгийн газар өргөн бариад Их Хурал дээр би ажлын хэсгийг нь ахалсан байгаа юм. Тэр хууль яагаад гарсан бэ гэвэл энэ тогтоолуудаас болоод гарсан байхгүй юу. Энэ тогтоолуудаас энэ олгогдсон тэр нэг аравны, өнөөдөр чанаргүй болчихоод байгаа 1.1 их наяд төгрөг.

Цаашаа эрсдэлтэй, чанаргүй болох ийм том эрсдэлтэй тулсан учраас энэ банкны засаглал болохгүй байна гээд Засгийн газар дээрээс энэ нэмэлт, өөрчлөлтүүдийг хийгээд өргөн барьсан байдаг юм. Энэ нэмэлт хууль бол маш сайн хууль болсон. Энэ хуульд өөрчлөлт орсноос хойш Засгийн газрын нэг ч шийдвэр зээл олго гэж гараагүй. Улсын Их Хурлаар нэг ч удаа жагсаалт баталж, Хөгжлийн банкаар зээл олгуулаагүй. Энэ хууль гарснаар өнөөдрийн 1.5 их наядын зээл чинь 3 их наяд болох эрсдэл зогссон байхгүй юу. Зогссон. Ийм сайн өөрчлөлтүүд болсон. Би танд бүр 6 чиглэлийнх нь өөрчлөлтийг би танд бүр яг сайхан нэг бүрчлэн уншаад тайлбарлая. Ийм чиглэлүүд дээр өөрчлөлт орсон байдаг юм.

Энэ 16, 17 оны өөрчлөлт орох хүртэл тус хууль дээр Хөгжлийн банканд хэн шалгалт хийх нь тодорхойгүй байдаг

байсан. Монголбанкийг бүр шалгалт хийж болохгүй ийм хязгаартай байсан. Ингээд энэ хуулиар Монголбанк, мэргэжлийн байгууллага энэ банканд шалгалт хийдэг ийм эрхтэй болсон.

Хоёрдугаарт энэ ном дээр шүү. Тусгайлан Засгийн газар, Улсын Их Хурлын санхүүжүүлэх шийдвэр гаргадаггүй болсон. Энэ хуулиар. Дахиж хэзээ ч гараагүй. ТУЗ нь хараат бус гишүүд тоо нэмэгдсэн. 3-4 болгосон. Нийт санхүүжилтийн 60 хувиас дээш экспортын санхүүжилт байх ёстой шүү. 60-аас доошгүй үнэхээр хөгжлийн зээлүүдийг санхүүжүүлэх ёстой шүү гэдэг ийм хязгаарыг оруулж өгсөн. Хуульд тусгайлан төсөл, хөтөлбөрт тавигдах шаардлагуудыг нь нэмсэн гэсэн үг. Төслийн ТЭЗҮ-г санхүүжүүлэхгүй гэж тусгайлан заасан. Өөрөөр хэлбэл төсвийн шинжтэй улс хийх ёстой ийм ажлуудыг өмнөөс нь орж Хөгжлийн банк санхүүжүүлэхгүй шүү.

Өнөөдөр Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын ТЭЗҮ-г 50 тэрбум төгрөгөөр Хөгжлийн банкнаас санхүүжүүлээд гаргачихсан байдаг юм. Шууд Засгийн газрын шийдвэр гаргаад. Гэх мэт зүйлийг Хөгжлийн банкнаас санхүүжүүлэхгүй шүү гэдэг ийм хязгаарлалт, түгжээнүүдийг энэ хуульд хийж өгснөөрөө маш сайн ийм өөрчлөлт болсон гэж би бодож байна.

Үр дүн нь гарсан байна. Үр дүн нь гараад өнөөдрийн 1.8 их наядын 25 хувь нь 16 оноос хойш, таны түрүүний асуусан 75 хувь чинь тэр юм байгаа шүү. 75 хувь нь энэ хуульд өөрчлөлт орохоос өмнө энэ хуулийн цоорхойгоор гарсан, энэ ном дээр заасан заалтууд байхгүй юу. Энэ хуульд өөрчлөлт ороогүй байсан бол энэ ном 2 дахин зузаан болох байсан. Ийм байна.

Хариуцлага тооцсон асуудал байлгүй яах вэ. Одоо хуулийн байгууллагуудаар явж байгаа нэг хэсэг байна. Захиргааны хариуцлага хүлээгээд

одоо ажлаасаа халагдсан нэг хэсэг байна. Өнөөдөр ажиллаж байгаа энэ баг бол цэвэр өр барагдуулах чиглэлээр ажиллаж байна. Хууль хүчний байгууллагуудтай хамтарч ажиллаж байна. Ингэтлээ энэ чанаргүй зээлүүд нь муудчихсан байгаа юм. Хууль хүчний байгууллагууд дээр явж байгаа зүйл бол энэ өөрөө зээл олгосон процесс өөрөө хууль зөрчсөн.

Тийм учраас тэр үйлдлээрээ хуулийн байгууллагууд дээрээ явж байгаа гэсэн үг. Тэр хариуцлага хүлээдэг процесс бол хуулиараа явна. Энэ дээр бол манай хуулийн байгууллагууд маш сайн ажиллаж байгаа. Хүч өгч байгаа. Ингээд бол өнөөдрийн үр дүн гарч байгаа гэсэн үг. Түрүүн чанаргүй зээлийн хувь хэмжээг би хэлчихлээ. Өр барагдуулах алба яг үнэхээр л одоо энэ банкны удирдлагууд очсоноосоо хойш 1 ч төгрөгийн шинэ зээл гараагүй. Юу нь зээл өгөх манатай. Өмнөх энэ 1.8 их наяд, энэ чанаргүй зээлүүдтэй ноцолдож байгаа юм.

Та түрүүн эх үүсвэр гээд ярилаа. Одонтуяа гишүүнээ наадахыг чинь хэн ч харсан гэсэн ямар ч 10 жилийн хүүхэд харсан ч гэсэн ойлгомжтой тоонууд байгаа байхгүй юу. Хөгжлийн банк 4 бонд гаргасан юм. 2012 онд анх 20 сая долларын бонд гаргасан, дараа нь “Чингис” бондыг Хөгжлийн банк руу шилжүүлсэн. 13 онд “Самурай” бонд 30 тэрбум иен гаргасан. 18 онд 500 сая долларын “Евро” бонд гаргасан. 16 оноос хойш шинэ эх үүсвэр гаргах орон зай үлдээгүй энэ Хөгжлийн банканд. Орон зай үлдээгүй. Өмнөх өрнүүдийнхээ хэмжээнд л үйл ажиллагаа явуулахаас өөр аргагүй болж ирсэн. Тэр чанаргүй зээл. Та хэвийн зээл гэж байна. Хэвийн зээл нь 9 байсан. Яагаад өндөр болчхов гээд. Аргагүй шүү дээ. Энэ өгсөн, энэ 12-16 онд өгсөн зээлүүд чинь зээлийн дундаж хугацаа нь 5 жил байхгүй юу. 5 жилээс цааш болж байж чанартай юу, чанаргүй юу гэдэг нь харагдана. Чансаа нь харагдана. Судалгаатай өгч үү, үгүй юу, бэлтгэлтэй өгч үү, үгүй юу гэдэг нь 5 жилийн дараанаас харагдах байхгүй юу. Хугацаа

нь ийм юм чинь. Тийм учраас тэнд чинь 9 хувь гэж харагдаад байгаа юм. 12 онд өгчихсөн, 13 онд өгчихсөн зээлүүд чинь одоо хугацаа нь 7, 8, 10 жил болоод төлөгдөөгүй байгаа байхгүй юу. Тэгээд чанаргүй зээл нь тэнгэрт гарчхаад байгаа юм. Та тийм үг их хэрэглэх дуртай юм байна.

Тэгээд тийм учраас чанаргүй зүйлүүд нь ийм юм болчихсон байгаа юм шүү. Одоо хэрвээ тэгдэг бол сайхан л байна. Та тэрэн дээр очиж сайхан зөвлөгөө өгөөч. Энэ банкин дээрээ. Энэ чанаргүй зээлийг ер нь яаж төлөвлөдөг юм, явал их хурдан сайхан төлөгддөг юм. Алтанхуяг гишүүн ер нь манай өр барагдуулах албанд очоод хэд хоног сайхан цуг суугаач та. Тухайн үед гаргаж байсан шийдвэрүүдээ тавьж сууж байгаад өгсөн зээлүүдийг чинь хэн хэн авсан юм байна? Төсөл, хөтөлбөрүүдээ санхүүжүүлж үү, үгүй юу? Сайхан суугаарай та. Таныг урьж байна. Одоо Мандуулд хариулах юм үлдсэн үү? Тэр хариуцлага дээр ямар ямар хүмүүст хариуцлага тооцож, хэдэн хүн ажлаас халагдсан, хэдэн хүнийг шүүх рүү шилжүүлсэн энэ талаар мэдээллүүдийг өгөөч.

Н.Мандуул: Асуултад хариулъя. Шинэ удирдлага банкны удирдлага дээр ирснээс хойш бас нэлээн томоохон өөрчлөлтүүд хийсэн. Бүтэц, өөрчлөлт хийгээд одоогийн байдлаар 40 гаруй хүмүүсийг ажлаасаа чөлөөлөгдсөн байгаа. Үүн дээр бас янз янзын жишээнүүд байгаа. Жишээ нь өөрөө Хөгжлийн банканд ажиллаж байгаад 1 компанийн зээлийг хариуцдаг байж байгаад ажлаасаа гараад нөгөө компанидаа очоод ажилладаг ч юм уу. Энэ бол манай томоохон зээлүүд дээр гарсан үзэгдэл. Ер нь бол банкны хувьд хүний нөөцийн асуудал тун хүнд байсан. Эх үүсвэр босгох тал дээр бол тогтвортой, мэргэжлийн талдаа хүмүүс ажилладаг. Зээл талдаа ажилладаг хүмүүс нь дунджаар...

Г.Занданшатар: Тодорхой хариулаарай. Цаг яваад байна шүү.

Н.Мандуул: Дунджаар 1.3 жилийн юу байсан. Тэгэхээр тийм байна.

Тэр “Чингис” бондын асуултад хариулъя. 2012 оны 11 сарын 28-нд “Чингис” бондыг Засгийн газар гаргаж 1.5 тэрбум долларыг босгосон байдаг. 2013 оны 4 сарын 30-нд Хөгжлийн банк тухайн үеийн Эдийн засгийн хөгжлийн яам, Сангийн яам гурвалсан санхүүгийн зуучлалын гэрээ гэж байгуулсан. Түүгээр энэхүү “Чингис” бондын хөрөнгө буюу 269.9 сая доллар, нэмэх нь 2 их наяд төгрөгийг Хөгжлийн банканд зарцуулахаар шилжүүлсэн байдаг.

Тэгснээрээ “Чингис” бондын эх үүсвэрээс Хөгжлийн банк нийтдээ 1.5 тэрбум долларын 354 сая долларыг нь шууд зээл олгож, 197.9 сая долларыг нь дамжуулан зээл, 1 тэрбум долларыг улсын төсвөөс эргэн төлөгдөх багц гэсэн байдлаар зарцуулсан байдаг. 2016 оны 12 сарын 28-нд 81 дүгээр Засгийн газрын тогтоолоор энэхүү “Чингис” бондын санхүүгийн зуучлалын гэрээг дуусгавар болгож, улсын төсвийн багцыг Засгийн газар руу шилжүүлсэн. Ийм операц явсан.

Тэгэхээр засаг болон Хөгжлийн банк хоорондын энэхүү санхүүгийн зуучлалын гэрээ дуусгавар болсноор “Чингис” бондын өр төлбөр, засагт төлөх өр төлбөр маань бол байхгүй болсон гэсэн үг. Баярлалаа.

Г.Занданшатар: Одонтуяа гишүүний микрофоныг өгөөч. Тэгэхээр одоо энэ төрийн өмчийн аж ахуйн нэгжүүд авчихсан зээлийг нь хэрхэн яаж төлүүлэх юм бэ? Голцуу л эргээд л харахад бас энэ найдваргүй л зээлүүд харагдаад байх юм. Та нар хувийнхныг болохоор ерөөсөө дор нь л хамаг хөрөнгийг нь битүүмжлээд л, нэлээн л хэцүү л байх шиг байна лээ шүү дээ хувийнхан. Тэгэхээр энэ төрийн өмчит аж

ахуйн нэгжүүдээ яах гэж байгаа юм бэ? Минут бага учраас товчхон хариулчих.

Г.Занданшатар: Жавхлан сайд. Болдын Жавхлан сайд.

Б.Жавхлан: Тэр 16 он хүртэл өгсөн төрийн өмчийн үйлдвэрийн газруудад өгсөн зээлүүд маш хэцүү байгаа шүү. Маш хэцүү байгаа. 16 оноос хойш төрийн өмчийн үйлдвэрийн газруудад өгсөн зээл байхгүй. Харамсалтай нь байхгүй байгаа. Би танд ганц, 2 жишээ хэлье. Сайханбилэг Ерөнхий сайдын үед тэр Канадад төлөөтэй явж байгаад одоо хэдэн ийм саравч аваад ирсэн байдаг юм. Хөгжлийн банкнаас санхүүжүүлээд. Тэрийг одоо тэгээд 10 хэд билээ? 20-иод тэрбум төгрөг тээ?

Г.Занданшатар: Асуулт нь хариулттайгаа адилхан цагаар явж байгаа.

Б.Жавхлан: 20 тэрбум төгрөг. Энэ одоо жишээ нь Батлан хамгаалахын яамны баланс дээр байж байх жишээтэй. Тэгэхээр одоо энийг үнэндээ яах учраа олохгүй байгаа юм. Та нар ирээд сайхан хэлээд өгөөрэй. Ийм байгаа юм. Тэгээд эцэст нь хэлье. Энэ Хөгжлийн банкны энэ чанаргүй зээлийн асуудлууд энийг эргэн төлүүлэх, энэ завхрал, энэ бүх юмыг манай Засгийн газар гаргаж ирж тавьсан. Тэр дундаа одоо эцсийн өмчлөгчийг төлөөлж байгаагийн хувьд Сангийн сайд миний бие энийг эхлүүлсэн. Тэр хэмжээгээрээ нэлээн цохилт авч байна. Хувь хүн дээр ирж байгаа тэр асуудал бол мянга дахь асуудал шүү. Мянга дахь асуудал. Тэглээ гээд энэ бүхнийг зогсоож чадахгүй. Бид нар явуулдгаар нь л явуулна. Тийм. Хөгжлийн банк одоо 12 жил болж байгаа.../үг тасрав./

Г.Занданшатар: За одоо болно.

Б.Жавхлан: Ийм байна. Тэгэхээр одоо би энэ бүх ажил зогсохгүй гэдгийг би дахин дахин хэлье. Баярлалаа.

С.Одонтуяа: Одоо 21-хэн секунд. Тэгэхээр ер нь ийм шүү. Одоо бүр 12 оны л Ардчилсан намын юмыг л ярьдгаа одоо нэг больчихмоор байна. Ерөөсөө бүр залхаж байна. Тэгэхээр одоо сүүлийн 6 жил та нар 65-уулаа улс орныг удирдана, ядуурлаас гаргана, энэ бүх асуудлыг шийднэ гэсэн бол шийд л дээ. Тэгээд л аль нөгөө Алтан.../минут дуусав./

Г.Занданшатар: Гишүүд цаг дууслаа. Асуулт, хариулт 20 минут үргэлжиллээ. Үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Ерөнхий сайдын мэдээллийг сонслоо. Хөгжлийн банкны асуудлаар Хөгжлийн банкны асуудлыг Хянан шалгах түр хороо байгуулагдсан. Хянан шалгах түр хороо бол энэ нотлох баримтыг цуглуулахад туслах үүрэгтэй. Шүүх, хуулийн байгууллагад үүрэг болохгүйгээр нотлох баримтыг шилжүүлж болно гэсэн хуультай. Хяналт шалгалтын түр хорооны нээлттэй сонголт хүртэл завсарлалаа.

Үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Ерөнхий сайдын мэдээллийг сонслоо.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

17.10 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР*

